



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГ

2016 ОНЫ 12-Р САР (Монгол улсад явца 21 өдөр) 2017 төсвийн

Шилэн дансны тухай хуулиар үзсэн болон орон нутгийн төсвийн байгууллагууд 28 төс
дотамантайгаар нийтэд нэг төд болгох ёстой. Эдгээрээ зургааг нь сонгогч ач ахыгууд
мэдэллээ хэрхэн нэг төд болгосон байдлыг ажиглав.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ДҮН

ЭНТ-үүд, Төсвийн санхүүжилтээр...

Эрүүр...

Сүхий...

Төсвийн...

...

ИРГЭНИЙ НИЙСЭМИЙН АЖИГЛАЛТЫН
СОНГОГЧИЙН ТӨГӨӨЛӨЛ

2016 ЖИЛИЙН ТАЙЛАН

Гарчиг

ӨМНӨТГӨЛ	4
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР	
Хүний эрх	8
Эрх зүйн шинэчлэл	14
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	20
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	26
Сонгууль, улс төрийн санхүүжилт	30
Төрийн ил тод, хариуцлагатай байдал	36
Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	36
Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь	41
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР	
Олборлох салбарын засаглал	48
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	54
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ ба бизнесийн орчин	62
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР	
Тэгш хамруулах боловсрол	68
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	73
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	76
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД	82

Товчилсон үг

АШУИС	Анагаахын шинжлэх ухааны их сургууль
АТГ	Авлигатай тэмцэх газар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БХАН	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДӨЧИ	Дэлхийн өрсөлдөх чадварын индекс
ДЭЗФ	Дэлхийн Эдийн Засгийн Форум
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУИС-ХЭС	Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль
МҮОНРТВ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НДЭХ	Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүдийн хөдөлгөөн
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОҮИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ТАН эвсэл	Төлсөн Авснаа Нийтэл
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХАХНХЯ	Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХАСҮМ	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЭЗ	Хүний эрхийн зөвлөл
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШУТИС	Шинжлэх ухаан, техникийн их сургууль
УДЭТ	Улсын Драмын Эрдмийн Театр

ӨМНӨТГӨЛ

Монгол Улсад ардчилсан шинэтгэл ид өрнөж, нийгэм, улс төр, эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлт явагдаж байсан 90-ээд оны дундуур үйл ажиллагаагаа эхэлсэн Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн (Соросын сан) хожмоо Нээлттэй Нийгэм Форум (ННФ) болон өөрчлөн байгуулагдаж энэ онд 20 дахь жилийнхээ босгыг давлаа. Төрийн үйл хэрэгт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үйлсийг зорилгоо болгосон бид энэ хугацаанд бодлогын үр нөлөөтэй, олон талын оролцоог хангасан өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэх, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд иргэд, иргэний нийгмийн оролцоог бодитой болгох чиглэлээр хичээл зүтгэл гарган ажиллалаа. Иргэний нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн судлаачидтай хамтран хийж ирсэн бодлогын судалгаа шинжилгээ, мониторинг нь улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хянах, үнэлж дүгнэхэд зохих хувь нэмэр оруулж байна.

Манай улсын хувьд 2016 он УИХ-ын ээлжит сонгууль тохиосон чухал жил боллоо. Бид “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-ний гишүүн байгууллагууд болон сайн дурынхантай хамтран Сонгуулийн хуульд шинээр тусгагдсан санхүүжилтийн заалтуудын хэрэгжилт, санал тоолох автомат машины ажиллагаа, хэвлэл мэдээллийн сурталчилгаа, санал хураалтын явцад мониторинг хийлээ. Ийнхүү ажиглах явцад сонгуулийн бүхий л үе шатанд улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн санхүүжилтийн мэдээлэл ил тод бус, түүнд тавих хяналт хангалтгүй хэвээр байгаа нь нотлогдлоо. Мониторингийн үр дүнд үндэслэн хуулийг цаашид боловсронгуй болгох, түүнчлэн хэрэгжилтийг нь сайжруулахад чиглэсэн тодорхой зөвлөмж гарган олон нийт, холбогдох талуудад хүргүүлээ.

Хүний эрхийг эрхэмлэн баталгаажуулах нь ардчиллын суурь зарчим болохын хувьд бид олон улсын болон дотоодын хүний эрхийн байгууллагуудтай хамтран өргөн хүрээний үйл ажиллагаа явуулж ирлээ. 2016 онд хүний эрхийг хэрэгжүүлж, хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх, хүний эрхийн тухай мэдлэг ойлголтыг урлаг, соёлын арга хэмжээгээр дамжуулан түгээх арга зам эрэлхийлж “Хүний эрхийн тухай ярилцъя” олон нийтэд зориулсан лекц, хүний эрхийн сэдвээрх “Өглөөний уулзалт”, “Кино хэлэлцүүлэг” зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулж байгаа нь олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын хувьд хүний эрхийн “халуун сэдэв”-ээр яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, мэдлэг мэдээлэл олж авах чухал талбар болоод байна.

Иргэдийн эрх, үүргийн тэнцвэрт байдал хангагдах нь тухайн улс орны иргэнд үйлчлэх эрх зүйн хэм хэмжээ болон шүүхийн хараат бус байдлаас ихээхэн хамааралтай билээ. Эдгээр салбарын эрх зүйн шинэчлэл, батлагдсан хуулийн хэрэгжилтэд мониторинг, үнэлгээ, шинжилгээ хийн төрийн бодлогод тусгуулах зэргээр мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагууд, бие даасан судлаачидтай хамтран нийт 12 хуулийн төслийг иргэний нийгмийн төлөөллөөр хэлэлцүүлэн холбогдох төрийн байгууллагад санал, зөвлөмж хүргүүлээ. Эрүүгийн хуулийн төсөлд тусгалаа олсон хүний эрх, эрх чөлөөг сайжруулсан 10 зүйлийг сурталчлан таниулах мэдээллийн томоохон арга хэмжээг зохион байгуулав. Мөн хууль сахиулах байгууллагын зарим ажиллагаанд 8 төрийн бус байгууллага мониторинг хийж дүнг нь холбогдох хууль сахиулах байгууллагуудад хүргүүлээд байна. Нийт 48 төрийн бус байгууллага мониторинг хийх санал ирүүлсэн нь хууль сахиулах салбарын үйл ажиллагаанд хяналт тавих иргэний нийгмийн сонирхол, чадавх нэмэгдэж буйг харууллаа.

2009 оноос өрнөж буй шүүхийн шинэтгэлийн үр дүн, үйл явцад судалгаа, шинжилгээ хийн бодлогын түвшний зөвлөмж, мэдээлэл боловсруулах ажлын хүрээнд 2016 онд шүүгчийн хариуцлага, хуульчийн

мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд шүүхэд итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцохтой холбоотой эрх зүйн асуудлыг хөндсөн бие даасан судалгаанууд хийж холбогдох хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулах санал, зөвлөмжийг салбарын төрийн байгууллагуудад хүргэв. Мөн шүүгчдийн хууль хэрэглэх үр чадварыг нэмэгдүүлэх, шүүх дэх олон нийтийн хяналтыг дээшлүүлэх зорилгоор шүүхийн хэрэг хянан шийдвэрлэж буй үндэслэл буюу шүүхийн шийдвэрт хөндлөнгийн дүн шинжилгээ хийх төслийг МУИС-ийн Хууль зүйн сургуульд тэтгэлэг олгон хэрэгжүүлж байна.

Шүүхийн бие даасан хараат бус байдалд мониторинг хийх цуврал сургалтын үр дүнд иргэний нийгмийн байгууллагууд энэ салбарт ажиглалт хийх чадавхтай болж 13 аймгийн анхан шатны шүүхийн хуралдаанд төрийн бус байгууллагууд хамтран ажиглалт хийн практик туршлага хуримтлууллаа. Энэ нь шүүхийн зүгээс иргэний нийгэмтэй хамтран ажиллах боломжийг нээхийн зэрэгцээ шүүхийн шинэтгэлтэй холбоотой бодит мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн үйл ажиллагаа боллоо.

Сүүлийн үед батлагдсан томоохон хууль тогтоомжийн талаар иргэд мэдээлэл багатай байгаагаас тулгамдсан аливаа асуудалд хуулиар олгогдсон эрх, боломжоо ашиглаж мэдэхгүй байгаа талаарх судалгааны дүнд тулгуурлан ННФ иргэдийн хэрэгцээнд суурилсан, баталгаатай, тогтвортой хууль зүйн анхан шатны туслалцаа үзүүлэх шинэ хөтөлбөр эхлүүллээ. Тус хөтөлбөр нь олон улсын санаачилгын дор Нээлттэй Нийгэм Сангуудын дэмжлэгтэйгээр 2020 он хүртэл хэрэгжих юм.

Улсын төсвийн хомсдол, өр зээлийн төлөлт давхцаж байгаа энэ үед юуны өмнө төсвийн сахилга бат, хариуцлагатай байдлыг хангахад чухал нөлөөтэй Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг улам үр сайжруулах, мөн орон нутгийн төсвийн ид тод байдлыг нэмэгдүүлэх, улсын төсвийн төлөвлөлтөд ул суурьтай, тооцоо судалгаатай хандах, өр зээлээ барагдуулах стратегийг бодитой тооцож боловсруулах зэрэгт иргэд, иргэний нийгэм, судлаачдыг өргөн оролцуулахад анхаарч ажиллалаа.

2015 оны туршид орон нутгийн 30 гаруй ТББ-ууд хамтран хэрэгжүүлсэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн мониторинг эерэг үр дүн авчирч төсвийн зарцуулалтын холбоотой мэдээллийн ил тод байдал орон нутагт сайжирч ирэв. Гэсэн хэдий ч УИХ-ын сонгуулиас хойш хуулийн хэрэгжилтэд ухралт ажиглагдаж эхэлсэн тул иргэний нийгмийн байгууллагууд 2016 оны сүүлээр мониторингийн үйл ажиллагаагаа сэргээж, бүх аймаг, нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын гүйлгээг Сангийн яамны Төрийн сангийн гүйлгээтэй тулгаж, баримт болон гүйлгээнд холбогдох шийдвэрийн ил тод байдалд хяналт тавьж байна.

Хоёр жил тутамд хийгддэг Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээ энэ жил 3 дахь удаагаа хийгдлээ. 2016 оны байдлаар Орон нутгийн төсвийн ил тод байдлын үзүүлэлт гурван жилийн өмнөхөөс 2.8 хувиар дээшилсэн нь энэ чиглэлээр дорвитой ахиц дэвшил гарахгүй байгааг дахин харууллаа. Түүнчлэн Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас гаргадаг дэлхийн 100 гаруй орныг хамарсан судалгааны дүнгээс үзэхэд Засгийн газрын төсвийн ил тод байдлын үзүүлэлтээр манай улс 51 оноо авч дэлхийн дунджаас 6 оноогоор илүү гарсан ч, засаглалыг сайжруулахад чухал нөлөө үзүүлэх төсвийн үйл явцад иргэд оролцооны үзүүлэлтээр 19 оноо авсан нь иргэдийн оролцоо маш бага байгааг илтгэж байна. Иймээс бид цаашид төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нөлөөлөл, судалгааны ажлууд хийж, үр дүнд нь тулгуурлан олон талт, цуврал хэлэлцүүлэг өрнүүлэхээр төлөвлөж байна.

Манай улс эдийн засгийн хямралыг даван туулах нэг гарц нь эрдэс баялгаа зүй зохистой ашиглах явдал билээ. Энэ салбарын засаглалыг сайжруулахад чиглэсэн мэдлэг туршлага

солилцох, дүрэм журам боловсруулах, хяналт мониторинг хийх, олон талт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг бид иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран сүүлийн 10 жил тасралтгүй явуулж ирлээ. 2016 онд ОУИТБС-ын шинэ стандартын хүрээнд эрх зүйн орчныг бүрдүүлэх, гэрээний ил тод байдлыг хангах, энэ салбарт ажиллах иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулахад илүүтэй анхаарч ажиллав. ОУИТБС-ын стандартад тусгагдсан “ашиг хүртэгч эзэд”-ийг ил тод болгох шаардлагын хүрээнд аж ахуйн нэгж, өмч хөрөнгийн бүртгэл мэдээллийн тогтолцоо, эрх зүйн орчныг үнэлэх бодлогын судалгаа хийн, үр дүнг холбогдох талуудад өргөн хүрээнд танилцуулсан нь үр дүнгээ өгч Нээлттэй засаглалын түншлэлийн 2015-2018 оны Үндэсний төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг төрийн бодлогод тусгалаа оллоо.

Түүнчлэн, олборлох үйлдвэрлэлийн салбарын гэрээний ил тод байдалд онцгойлон анхаарч төр болон олборлох үйлдвэрлэл эрхлэгчид, иргэний нийгмийнхний ойлголт, байр суурийг нэгтгэхэд үр дүнтэй хамтран ажиллаж олон талт хэлэлцүүлэг болон нөлөөллийн ажил явуулсны үр дүнд Бүтээгдэхүүн хуваах гэрээний нууцын зэрэглэл хүчингүй болж гэрээний ил тод байдлыг хангах чухал нөхцөл боллоо. Ингэснээр эрдэс баялгийн салбарт хийгдэж байгаа том, жижиг гэрээг www.iltodgeree.mn цахим санд байрлуулж, гэрээтэй холбоотой бусад тайлан мэдээ, байгаль орчны үнэлгээ, менежментийн төлөвлөгөө зэрэг цогц мэдээллийг олон нийт нэг дороос үзэх боломж нээгдлээ. Үүнтэй зэрэгцэн иргэний нийгмийн байгууллагуудыг байгалийн нөөц баялаг ашиглах гэрээнд дүн шинжилгээ хийх чадавхтай болгохыг зорьж цуврал сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, мониторинг нөлөөллийн ажлын тэтгэлэг олгон иргэний нийгмийн сүлжээг бэхжүүлэх бүхий л талын чармайлт гарган ажиллаж байна.

ННФ-ын Боловсрол, Нийгмийн бодлогын хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын боловсролын тогтолцоонд тэгш хамруулах зарчмыг суулгахад чиглэсэн нөлөөлөл, мониторингийн ажлууд тодорхой төвшинд хийгдэж талуудын байр суурийг нэгтгэх, энэ чиглэлээр төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог бий болгоход чиглэсэн оролдлогууд хийгдсээр байна. 2016 оны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах бодлогын нөлөөллийн ажил хийх иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлж, цаашдын институцийн хөгжлийг дэмжихэд нь түлхүү анхаарлаа. Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ нийслэл болон орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйлчилгээнд гарсан ололт, амжилт, тулгарч буй асуудлыг баримтжуулан ажиглалт хийж үр дүнгээ гаргаад байна. Мөн энэ хөтөлбөрийн хүрээнд залуучуудын дундах хүчирхийллийн элементүүдийг урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлыг хоёр дахь жилдээ үргэлжлүүллээ. Нийгмийн ажилтан бэлтгэдэг АШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль болон ШУТИС-ийн Нийгмийн ажилтны тэнхимтэй хамтран ажилласны үр дүнд АШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль “Залуучуудын дундах хүчирхийлэл ба урьдчилан сэргийлэл” нэртэй 3 кредитийн хичээлийн хөтөлбөр, сурах бичгийн хамт боловсруулж сургалтдаа нэвтрүүлээ. Харин ШУТИС-ийн Нийгмийн ажилтны тэнхим бакалаврын сургалтын хөтөлбөрөө шинэчилж мөн залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулга, арга зүйг багтаан зуны сургалтын хөтөлбөр боловсруулаад байна.

Ийнхүү бид 2016 оны үйл ажиллагаагаа товчлон багцалж, дүгнэн нэгтгэснээ уншигч Танд хүргэж байгаадаа баяртай байна. Та бүхэнд хүргэж буй энэхүү тайланг уншиж танилцаад санал бодлоо хуваалцах аваас бид тун таатай хүлээн авах болно. Манай үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn сайт руу орж үзнэ үү.

Гүйцэтгэх захирал П. Эрдэнэжаргал

ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР



Хүний эрх

Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын Форумын үйл ажиллагаа тогтмолжин хууль эрх зүйн шинэчлэл, хүний эрхийн “халуун сэдэв”-үүдээр нөлөөллийн ажил явуулах туршлага хуримтлуулж, хүний эрхийн үндэсний тогтолцоонд өөрийн байр суурийг эзлэх боллоо.

Өнгөрч буй 2016 он Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форумын хувьд чадавхаа бэхжүүлсэн, туршлага олон улсад болон орон нутагт таниулсан түүхэн чухал он байлаа. Үүний зэрэгцээ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг”-ээс авсан зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжтой, хэрэгжилтэд хяналт тавих бүтэцтэй төлөвлөгөөг Засгийн газраар батлуулахад бодитой нөлөөлж ажиллалаа. Түүнчлэн хүний эрхийн боловсрол мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийг хөндсөн чухал сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлэх зорилго бүхий уламжлалт ажлууд хэдийнээ олон нийт, зорилтот бүлгийн эрэлтэд нийцсэн арга хэмжээ болж чадлаа.

Хүний эрхийг хамгаалах үндэсний механизмыг бэхжүүлэх

Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум 2010 оноос эхлэн НҮБ-ын Хүний эрхийн



зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” механизмыг үр нөлөөтэй ашиглах зорилгоор ажиллаж ирсэн билээ. Энэ хүрээнд хоёр дахь удаагийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг”-ээс хүлээн авсан 150 зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газар батлах явцад амжилттай нөлөөллийн ажил явууллаа. Тус төлөвлөгөө нь хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Орон тооны бус зөвлөлийг төр, иргэний нийгмийн



Хүний эрхийн ТББ-уудын Форум “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг”-ээс хүлээн авсан 150 зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газар батлах явцад амжилттай нөлөөллийн ажил явууллаа.”



Хүний эрхийн ТББ-уудын Форумын гишүүдийн уулзалт

оролцоотой байгуулах; төрийн байгууллагууд жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор хариуцсан зөвлөмжийн хэрэгжилтийн тайлангаа тавих; Зөвлөл тайланг нэгтгэж, дараа оны 2 дугаар сарын дотор Засгийн газарт тайлагнах зэрэг хэрэгжилтэд хяналт тавих үр нөлөөтэй механизмыг бий болгосноороо өмнөх төлөвлөгөөнөөс давуу талтай байв. Үүний зэрэгцээ хариуцсан төрийн байгууллага шаардлагатай тохиолдолд дэд ажлын төлөвлөгөөг

иргэний нийгэмтэй хамтран боловсруулж болохыг Засгийн газрын тогтоолоор үүрэг болгосон юм.

ННФ нь Хүний эрхийн ТББ-уудын Форум, ХЭҮК, ГХЯ, ХЗДХЯ-тай хамтран зөвлөмжийн хэрэгжилтийн асуудлаар цуврал зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан бөгөөд цаашдаа төрийн байгууллага нэг бүртэй хариуцсан тодорхой зөвлөмжийн хүрээнд зөвлөлдөх уулзалт зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Хүний эрхийн ТББ-уудын Форум нь 2015 оноос эхлэн сар тутмын хурлаа үйл ажиллагааны үндсэн хэлбэр болгохын зэрэгцээ гишүүн байгууллагын идэвхтэй, эрх тэгш оролцоонд тулгуурлан ажиллах болсон. Үйл ажиллагаандаа баримтлах зарчим стандартыг тусгасан дүрмийн хэлэлцүүлэг өрнүүлэх, орон нутагт хамтран ажиллах хүрээгээ өргөжүүлэхэд өнгөрсөн онд анхаарлаа хандуулж ажиллалаа.

ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Форумын үйл ажиллагааны үндсэн механизм болох сар бүрийн хурал (1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 11, 12-р сард) тогтмол зохион байгуулагдав.
- “Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө” сургалт зохион байгууллаа (2017 оны 5 сард).
- АСЕМ-ын хурлын үеэр “Зүүн хойд Азийн ИНБ-уудын дугуй ширээний ярилцлага”, “Хүний эрхийн иргэний нийгмийн байгууллагын үндэсний уулзалт зөвлөгөөн” боллоо (6 сард).
- Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдад асуулга хүргүүлэв (9-р сард).
- “НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга зам” цуврал зөвлөлдөх уулзалтыг ХЭҮК, ГХЯ, ХЗДХЯ, Хүний эрхийн ТББ-уудын Форумтай хамтран 12-р сард зохион байгуулав.
- “Хүний эрхийн ТББ-уудын Форумын үйл ажиллагааны зарчим, гишүүнчлэл, зохион байгуулалтын бусад асуудал” сэдэвт сургалт-хэлэлцүүлэг болов (12-р сард).



Тухайлбал, АСЕМ-ын хурлын үеэр “Хүний эрхийн иргэний нийгмийн байгууллагын үндэсний зөвлөгөөн”-ийг Улаанбаатар хот, 21 аймгийн ТББ-уудтай хамтран амжилттай зохион байгуулсан бөгөөд энэхүү арга хэмжээ нь орон нутагт үйл ажиллагаагаа хүргэх эхлэл алхам тавьсан чухал ач холбогдолтой үйл ажиллагаа байв.

Хүний эрхийн ТББ-уудын Форум нь зөвхөн НҮБ-ын хүний эрхийн механизмд хандахаас гадна дотоодод болж буй хүний эрхийн асуудалд анхаарал хандуулж, хамтарсан нөлөөлөл хийж хэвшлээ. Өнгөрсөн онд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хэд

хэдэн хамтарсан нөлөөллийн үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

НҮБ-ын гэрээний хороодод мэдээлэл хүргүүлэх, тодорхой дүгнэлт зөвлөмж авах чиглэлээр анхаарч ажиллаж байгаа бөгөөд Хүний эрхийн хороонд иргэний, улс төрийн эрхийн асуудлаар мэдээлэл бэлтгэж хүргүүлээд байна. Үүний зэрэгцээ, тус Форум нь олон улсын, бүс нутгийн байгууллагатай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, өөрсдийн туршлагаа хуваалцахад мөн анхаарч ирлээ. Энэ хүрээнд АСЕМ-ын хурлын өмнө болсон Ази, Европын Ард Түмнүүдийн Чуулганы үеэр “Зүүн Хойд



Зуун гар талд: АСЕМ-ын хурлын өмнө Ази, Европын Ард Түмнүүдийн Чуулганы үеэр болсон “Зүүн Хойд Азийн Иргэний нийгмийн байгууллагуудын дугуй ширээний ярилцлага” Энэ ярилцлагад Хүний эрхийн ТББ-уудын Форумын гишүүд мөн оролцсон юм.

Доорх зурагт: “Butterfly Effect” номд Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форумын туршлагыг тусгасан хуудас



Азийн Иргэний нийгмийн Дугуй ширээний ярилцлага” зохион байгуулж, хүний эрхийн чиглэлээр харилцан туршлага солилцсон юм. Хүний эрхийн ТББ-уудын Форумын хүний эрхийн нөлөөллийн ажлын туршлагыг Тайланд, Мьянмар, Австрали, Уганда зэрэг дэлхийн улс орнууд нөлөөллийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд UPR-Info байгууллагаас 2016 онд нийтлүүлсэн “Butterfly Effect” номд Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форумын туршлагыг тусгасан нь дэлхийн улс орнуудтай туршлагаа хуваалцах сайхан боломжийг бий болголоо.

ННФ нь сүүлийн 3 жил Хүний эрхийн ТББ-уудын Форумын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сургалт, уулзалт хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт, сар тутмын хурал зохион байгуулахад техникийн туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН НИЙТИЙН ЛЕКЦ

- “Хүний эрхийн үндэсний байгууллага: Тавигдах шаардлага, чиг үүрэг”, С.Цэрэндорж, ХЭҮК-ын анхны дарга, Хүний эрх, ардчилал судалгааны төвийн тэргүүн, ХЗУ-ны доктор
- “Иргэний оролцоо ба иргэний нийгэм”, Х.Номингэрэл, Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ
- “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө”, Д.Гангабаатар, МУИС-ийн ХЗС-ийн багш, ХЗУ-ны доктор, дэд профессор
- “Хүний эрхийг хамгаалах асуудлаарх олон улсын чиг хандлага, Солонгос Улсын жишээ”, Кионг Уан Ан, профессор, БНСУ-ын ХЭҮК-ын дарга асан
- “Соёлын эрхийн ач холбогдол”, Ч.Амарбаяр, ХЗУ-ны доктор, өмгөөлөгч
- “Хөдөлмөрийн хуулийн хэрэгжилт ба ажилтан, ажил олгогчийн эрх, үүргийн уялдаа”, Б.Уранцэцэг, ХЗУ-ны доктор, профессор
- “Хүний эрхийн хамгаалагчдын эрх зүйн орчныг бий болгох” хүрээнд Ажлын хэсэг байгуулж, төсөл боловсруулах ажлыг ХЭҮК-той хамтран эхлүүлэв.

“ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ЯРИЛЦЬЯ” ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ

- “Эрүүдэн шүүхээс ангид байх эрх ба Бие даасан Мөрдөн байцаах алба”, Чиглүүлэгч: Өмгөөлөгч, дэд проф. Б.Галдаа
- “Хүний эрх цаг үеийн асуудлууд”, Чиглүүлэгч: ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж
- “Хүүхэд залуучууд ба хүний эрхийн боловсрол”, Чиглүүлэгч: БХАН ТББ
- “Хүүхдэд ээлтэй хот”, Я.Байгальмаа, Нийслэлийн ХГБХ-ийн газрын дарга
- “Хүүхдэд эрх, хамгаалал-Эрх зүйн орчин”, Хүүхэд хамгааллын ТББ-уудын үндэсний сүлжээ
- “Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн талаарх хөндлөнгийн илтгэл”, Японы хүүхдийг ивээх сан ба ТББ-уудын төлөөлөл
- “Ахмадын эрхийг баталгаажуулья: Монголд насаар ялгаварлан гадуурхах явдал байдаг уу”, Чиглүүлэгч: Хүний эрх хөгжил төв ТББ
- “Сургуулийн төлбөр ба хүүхдийн эрхийн зөрчил”, Чиглүүлэгч: Ж.Буд-Эрдэнэ, эцэг эхийн төлөөлөл
- “МУ-ын хохирол үнэлгээний өнөөгийн байдал, эрх зүйн орчин”, Чиглүүлэгч: Хохирол, үнэлгээчдийн холбоо ТББ
- “Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өртөг: Хүн худалдаалах гэмт хэргийн жишээн дээр”, “Эрүүгийн хууль-Зорчих эрхийг хязгаарлах ялыг гүйцэтгэх боломж”, Чиглүүлэгч: Хүйсийн тэгш эрхийн төв ТББ, Өмгөөллийн Номос ХХН

Хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх, энэ чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авах тухай зөвлөмжүүд НҮБ-ын хүний эрхийн механизмаас удаа дараа өгч байсан бөгөөд энэ чиглэлээр ХЭҮК-той хамтран хуулийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлээ.

Хүний эрхийн боловсрол, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх

ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ

ННФ хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих, нийгэмд хүний эрхийн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх үйл явцыг байнга дэмжиж ирсэн бөгөөд зарим үйл ажиллагаа тогтмолжиж, агуулга болон хамрах хүрээ нь өргөжиж байна. Тухайлбал, ХЭҮК-той хамтран зохион байгуулдаг “Хүний эрхийн олон нийтийн лекц”, “Хүний эрхийн тухай ярилцья” арга хэмжээ, Эмнести интернэшнл ТББ-тай хамтран зохион байгуулдаг “Хүний эрхийн кино хэлэлцүүлэг” нь тогтмолжиж, тухайн цаг үеийн “халуун сэдэв”-үүдээр мэдлэг мэдээлэл солилцон туршлагаа хуваалцах, хамтын ажиллагаа, сүлжээ хөгжүүлэх чухал талбар боллоо. Энэ онд “Хүний эрхийн кино хэлэлцүүлэг” арга хэмжээг орон нутагт таниулах ажлыг эхлүүлсэн бөгөөд



“Төмөр хошуут сахиусан тэнгэрүүд” киног Дархан-Уул, Ховд аймгуудын иргэний нийгмийн байгууллагад үзүүлж, эрүүгийн процесст хүний эрх хамгааллын асуудлаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. Түүнчлэн эдгээр үйл ажиллагаа нь хүний эрхийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийг бий болгох, энэ чиглэлийн судалгаа, шинжилгээг хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Нийт иргэд, төрийн албан хаагчид, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудын хүний эрхийн боловсрол нимгэн, хөгжлийн асуудлыг хүний эрхээс тусад нь авч үзэх хандлага хүчтэй цухалзах болсон өнөө үед энэ чиглэлийн үйл ажиллагааг тогтмол давтамжтайгаар зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байсаар байна.



Ай-синема кино театрт болсон Хүний эрхийн кино хэлэлцүүлгийн үеэр. Оролцогчид “Төмөр хошуут сахиусан тэнгэр” кино үзэж дараа нь хэлэлцүүлэг өрнүүлэв.

ТЕАТР ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ

Урлагаар дамжуулан хүний эрхийн боловсрол, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд ННФ аль ч үед чухалчилж ирсэн билээ. Тиймээс ч Глоб интернэшнл төв ТББ-ын санаачилсан “тавилттай уншлага” хэмээх үзвэрийн шинэлэг төрлийг хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх, тулгамдсан асуудалд шийдвэр гаргагчид, олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор олон нийт, зорилтот бүлэгт таниулах ажлыг “Театр хүний эрхийн төлөө” санаачилгын хүрээнд хэрэгжүүлж ирлээ.

Уг санаачилгын хүрээнд УДЭТ, Глоб интернэшнл төв ТББ-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд 2016 онд зохиолчдыг чадавхжуулахад анхаарлаа хандууллаа. Энэ зорилгоор

нийт 20 орчим зохиолчийг шат дараатай сургалт, хэлэлцүүлэгт хамруулж, туршлагатай зохиолч, найруулагч, мэргэжилтнүүдээр зохиол бүтээлд нь зөвлөгөө туслалцаа үзүүлсэн юм. Үүний дунд сургалтад хамрагдсан зохиолчид оюуны өмчийн эрх, дунд сургуулийн хүүхдүүдийн дундах хүчирхийлэл, ахмадын эрх, бэлгийн хүчирхийлэл зэрэг сэдвээр хэд хэдэн бэсрэг жүжгийн зохиол туурвисан билээ. Энэ оны ажлын гол үр дүн бол зохиол бүтээлээрээ дамжуулан хүний эрхийг зөрчихгүй байх, цаашлаад хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах чиглэлээр зохиолчдод санаа сэдэл өгсөнд оршино.

ХҮНИЙ ЭРХИЙН КИНО ҮДЭШ

- “Дэвид Гейлийн Амьдрал”, Найруулагч: Элен Паркер, Гол дүрүүдэд: Кевин Спеси, Кейт Винслет, Лора Линнэй. Кино зохиолыг бичсэн: Чарльз Рэндольф.
- “Хатагтай”, Найруулагч: Люк Бэссон, Гол дүрүүдэд: Мишель Ёо, Дэвид Тьюлис, Жонаттан Рагетт. Кино зохиолыг бичсэн: Ребекка Фрэйн.
- “Түүний төрх нь”, Найруулагч: Даниэл Рибэйро, Гол дүрүүдэд: Гийермо Лобо, Фабио Ауди, Тэсс Аморим, Кино зохиолыг бичсэн: Даниэл Рибэйро.
- Дархан-Уул, Ховд аймагт кино хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- “Төмөр хошуут сахиусан тэнгэрүүд”, Гол дүрүүдэд: Хилари Свенк, Франсе О’Коннор, Жулиа Ормонд, Моли Паркер, Лора Фазер, Брүүк Смиф, Вера Фармига, Луйз Смиф, Марго Матиндале, Анжелика Хюстен

ТЕАТР ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ

- Жүжгийн зохиол хэрхэн бичих вэ?”, зохиолчдод зориулсан сургалт
- Зохиол хөгжүүлэх уулзалт, сургалт
- Зохиолчдод мэргэжилтнүүдээр зөвлөгөө өгүүлэх уулзалт

Эрх зүйн шинэчлэл

Эрх зүйн шинэчлэлийн чиглэлээр ажиллах иргэний нийгмийн байгууллагуудын чадавх бэхэжсэнээр хэлэлцэгдэж буй хуулийн төсөлд санал шүүмж хүргүүлэхээс эхлээд хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд мониторинг хийх, үр дүнд нь нөлөөллийн ажил явуулах зэргээр энэ салбарт ажиллах төрийн бус байгууллагуудын идэвх оролцоо нэмэгдэж байна.



“Эрүүгийн эрх зүй, захиргааны эрх зүйн хүрээнд нийт 10 гаруй хуулийн төслөөр иргэний нийгмийн хэлэлцүүлэг зохион байгуулж, санал зөвлөмж гаргалаа.”

Хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, баталгаажуулах хүрээнд ННФ нь эрх зүйн шинэчлэлийг байнга дэмжиж ирсэн бөгөөд энэ хүрээнд шинээр боловсруулж, шинэчлэн найруулж байгаа хууль тогтоомжийн төсөлд иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлэх, шаардлагатай тохиолдолд техникийн туслалцаа үзүүлэн ажиллаж байна. Энэ хугацаанд эрүүгийн эрх зүй, захиргааны эрх зүйн хүрээнд нийт 10 гаруй хуулийн төслөөр иргэний нийгмийн хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан санал зөвлөмжийг тусгасан нийт 12 “Хуулийн шүүмж” цуврал гаргаад байна. Мөн шинээр байгуулагдсан, шинэчлэгдсэн хууль сахиулах албадыг бэхжүүлэх, дотоод дүрэм журмаа хүний эрхийн зарчим стандартад нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хууль сахиулах зарим үйл ажиллагаанд мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулахад анхаарч ажиллалаа.



Эрх зүйн шинэчлэлийн үйл явцад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь

Нэг талаас, Монгол Улсад өрнөж буй эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэхэд



ШИНЭ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ

- “Шинэ эрүүгийн хуулийн онцлох 10 зүйл” сэдэвт мэдээллийн яармаг ажиллуулж, иргэний нийгмийн байгууллагаас эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд онцолж буй мэдээллээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэлээ.
- Шинэ Эрүүгийн хуулийн сургалтыг иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудад зориулан зохион байгууллаа.
- “Эрүүгийн эрх зүйн шинэчлэл”-ийг дэмжих нөлөөллийн ажлыг 300 орчим ТББ хамтран эхлүүллээ.
- Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн төлөөх нөлөөллийн ажлын хүрээнд сайн дурын ажилтнууд бэлтгэх цуврал сургалтыг зохион байгууллаа.

иргэний нийгмийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх нөгөө талаас, шинэчлэгдэн буй эрх зүйн орчныг иргэний нийгэмд таниулах зорилгоор “Хуулийн хэлэлцүүлэг”-ийг 2014 оноос санаачлан эхлүүлсэн юм. Энэ онд “Иргэний улс төрийн эрхийг хэрэгжүүлэх тухай хууль”-ийн төслийн хэлэлцүүлэг хийж, иргэний нийгмийн

байгууллагуудын саналыг нэгтгэн “Хуулийн шүүмж” боловсруулан хуулийн төслийн Ажлын хэсэгт хүргүүллээ.

Мөн түүнчлэн хууль сахиулах байгууллагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дүрэм журмыг хүний эрхийн суурь зарчимд нийцүүлэх, хууль, дүрмийн төсөлд иргэний нийгмийн санал бодлыг



Мэдээллийн яармагийн үеэр

ХУУЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- “Иргэний улс төрийн эрхийг хэрэгжүүлэх тухай хууль”-ийн төслийн цуврал хэлэлцүүлгийг Швейцарын хөгжлийн агентлагийн Иргэдийн оролцоо төсөлтэй хамтран зохион байгуулав.
- “Гэрч, хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын журмууд”-ын төсөлд санал өгөх хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” хэлэлцүүлгийг Тахарын ерөнхий газартай хамтран зохион байгууллаа.



тусгуулах зорилгоор “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь”, “Гэрч, хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын журмууд”-ын төсөлд иргэний нийгмийн оролцоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох талуудад санал, зөвлөмж илгээлээ.

УИХ-ын ээлжит сонгуулийн дараа хууль тогтоох байгууллагаас Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулийн мөрдөгдөж эхлэх хугацааг хойшлуулж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай,

Хууль сахиулах ажиллагааны тухай зэрэг 5 хуулийг хууль санаачлагчид буцаасан шийдвэр гаргаснаар эрүүгийн эрх зүйн шинэчлэл хэрхэх эсэх нь тодорхойгүй болсон. Үүнтэй холбогдуулан иргэний нийгмийн байгууллагууд эвлэлдэн нэгдэж, 300 орчим ТББ хамтран нөлөөллийн үйл ажиллагаа эхлүүлээ. Эхний ээлжид УИХ-аас 2015 онд баталсан Эрүүгийн хуульд дүн шинжилгээ хийх замаар хүний эрх, эрх чөлөөг дээрдүүлсэн, шинэчлэлийн хүрээнд гарцаагүй хадгалагдан үлдэх ёстой 10 онцлох зүйлийг олон нийтэд таниулах ажлыг



“Хүний эрх хөгжил төв” ТББ-аас санаачлан Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан зохион байгуулж буй цуглаанд Хүний эрхийн ТББ-уудын Форумын гишүүд хоёр дахь жилдээ амжилттай оролцлоо. Доорх зурагт: Уг цуглаанд оролцож үг хэлсэн төрийн байгууллагын төлөөлөгчид



гүйцэтгэсэн юм.

Энэ хүрээнд эрүүгийн эрх зүйн шинэчлэлд хамааралтай сэдвээр олон нийтийн лекц, кино хэлэлцүүлэг, мэдээллийн яармаг, цуврал хэлэлцүүлэг өрнүүлж оюутан залуучууд, иргэний нийгмийн байгууллагад шинэчлэлийн үзэл баримтлал, шинэ хууль тогтоомжийн үзэл санааг

таниулахын зэрэгцээ нийгмийн сүлжээгээр дамжуулан нөлөөллийн ажлууд явууллаа. Тус үйл ажиллагаа нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хамаарах хуулиудыг УИХ-аас батлах хүртэл үргэлжлэх тасралтгүй үйл явц билээ.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хууль тогтоогч, бодлого

СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- “Тахарын тойргийн алба хаагчдад зориулсан сургалт”-ыг Тахарын ерөнхий газартай хамтран Дорнод, Өвөрхангай аймагт зохион байгуулав.
- “Шинээр сонгогдсон иргэний зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалт”-ыг Цагдаагийн ерөнхий газартай хамтран Улаанбаатар хот, Ховд аймагт тус тус зохион байгууллаа.
- “Орон нутагт хүний эрхийн хамгаалал, нөлөөлөл хийх чадавхыг бэхжүүлэх нь” эхний шатны сургалтыг Дорноговь, Дундговь, Өвөрхангай аймагт нийт 11 аймгийн 72 ТББ-ыг оролцуулан бүсчлэн зохион байгууллаа.
- Хууль сахиулах байгууллагад мониторинг хийх төрийн бус байгууллагуудад зориулсан сургалт зохион байгууллаа.
- “Орон нутгийн ИНБ-уудыг чадавхжуулах нь” хоёр дахь шатны сургалтыг “Хууль сахиулах зарим ажиллагаанд мониторинг хийх нь” сэдвээр Ховд, Дархан-Уул зэрэг нийт 10 аймгийн ТББ-уудыг оролцуулан, бүсчлэн зохион байгуулав
- “Цагдаагийн эмэгтэй алба хаагчдын манлайлал” сэдэвт сургалтыг Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын эмэгтэй алба хаагчдыг оролцуулан зохион байгуулав.

Доорх зургуудад 2016 оны 4 дүгээр сард Дорноговь, Дундговь аймгуудад зохион байгуулагдсан “Орон нутагт хүний эрхийн хамгаалал, нөлөөлөл хийх чадавхыг бэхжүүлэх нь” сургалтын үеийн бүлгийн ажиллагааг харуулав.



боловсруулагчдыг судалгаа, дүн шинжилгээгээр хангах нь ННФ-ын нэг чухал зорилт байсаар ирсэн. Энэ онд “Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх боломж”, “Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны өртөг: Хүн худалдаалах гэмт хэргийн жишээн дээр” сэдвээр өмгөөллийн Номос ХХН, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-уудаар тус тус судалгаа хийлгэж, үр дүнг олон нийтэд танилцууллаа. Тус судалгааны үр дүнг эрүүгийн хууль тогтоомжийн шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах үйл явцад оролцож буй хууль тогтоогч, ажлын хэсгийн гишүүд, олон нийтэд танилцуулахаар ажиллаж байна.

Шинэчлэлийн үйл явцад иргэний нийгмийн оролцоог хангахаас гадна шинээр бий болсон бүтэц, хууль сахиулагчдыг хуулиар

хүлээсэн чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх чадавхыг бий болгох чиглэлээр хууль сахиулах байгууллагатай идэвхтэй хамтран ажиллаж ирсэн. Энэ хүрээнд Цагдаагийн ерөнхий газар, Тахарын ерөнхий газартай хамтран аймаг, нийслэлийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлд шинээр сонгогдсон гишүүдэд зориулсан сургалтыг Улаанбаатар хот, Ховд аймагт, Тахарын албаны алба хаагчдад зориулсан сургалтыг Дорнод, Өвөрхангай аймгуудад тус тус зохион байгууллаа.

Эрх зүйн шинэчлэлийн үйл явцад оролцох иргэний нийгмийг чадавхжуулах нь

Эрх зүйн шинэчлэлийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд хариуцлагатай, чадварлаг иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг маш чухал билээ. Тиймээс ННФ-аас орон нутагт иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах, аливаа асуудлаар өөр хоорондоо үр дүнтэй хамтран ажиллах эхлэлийг тавих зорилгоор аймгууд дахь төрийн бус байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах шаталсан сургалтыг 2015 оноос эхлүүлсэн бөгөөд энэ онд баруун болон төвийн бүсийн 10 аймгийн төлөөлөл хоёр дахь



шатны сургалтад хамрагдаж, үлдсэн 11 аймгийн төрийн бус байгууллагууд эхний шатны сургалтад амжилттай оролцлоо. Хоёр дахь шатны сургалтын үеэр хууль сахиулах байгууллагад мониторинг хийх чадавхыг бэхжүүлэх зорилт дэвшүүлсэн тул танилцах дадлага хийх, мониторингийн төсөл бичих, хууль сахиулах алба хаагчидтай уулзалт зохион байгуулах зэрэг практик үйл ажиллагаанд илүүтэй тулгуурласан нь орон нутгийн төрийн бус байгууллагуудын талархлыг хүлээж байна.


Тус сургалтад хамрагдсан төрийн бус байгууллагууд шинээр батлагдсан хуулийн хэрэгжилт, төрийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн биелэлтэд мониторинг хийх чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд Захиргааны ерөнхий хууль, Шилэн данс, Цагдаагийн албаны тухай хууль, шүүхийн шинэчлэлийн хүрээнд ННФ-аас зарласан тэтгэлэгт уралдаанд амжилттай оролцож, нийт 78 мониторингийн төслийг хэрэгжүүлэхэд 72 төрийн бус байгууллага оролцоод байна.

Мониторинг

Төрийн үйлчилгээнд мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагыг дэмжих, энэ чиглэлээр ажиллах төрийн бус

байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр нь ННФ-ын үйл ажиллагааны чухал хэсэг байсаар ирсэн. Үүний дүнд хууль сахиулах салбарт мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Тухайлбал, 2016 оны мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийн уралдаанд 48 төрийн бус байгууллага төслөө ирүүлснээс 8 байгууллагад олон нийтийн цагдаагийн ажилтны хөдөлмөрийн гэрээг дүгнэх ажиллагаа, бага үнийн дүнтэй шүүхийн шийдвэрийн биелэлт, цагдаагийн албанд ирүүлсэн гомдол шийдвэрлэх ажиллагаа, шүүх хуралдааны дэг сахиулах ажиллагаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, баг хорооны цагдаагийн үйл ажиллагааг онооны картаар үнэлэх нь зэрэг сэдвээр мониторингийн тэтгэлэг олголоо. Мониторингийн дүнг товч дурдвал олон нийтийн цагдаагийн ажилтны хувцас хэрэглэлийн чанар хангалтгүй, нэг бүрийн хамгаалах тусгай хэрэгслээр хангагдаагүй, илүү цагаар ажиллах нь түгээмэл ч урамшуулал нэмж олгодоггүй зэрэг дутагдал байна. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нэр төдий явагддаг, тухайн нутаг дэвсгэр дэх гэмт хэргийн гаралттай уялддаггүй, төсвийн зарцуулалт оновчтой биш зэрэг нийтлэг дутагдал ажиглагдлаа. Мониторингийн дэлгэрэнгүй үр дүнг www.forum.mn цахим хуудсаас олж үзэх боломжтой.

Доорх зургуудад 2016 оны 4 дүгээр сард Дорноговь, Дундговь аймгуудад зохион байгуулагдсан “Орон нутагт хүний эрхийн хамгаалал, нөлөөлөл хийх чадавхыг бэхжүүлэх нь” сургалтын үеийн бүлгийн ажиллагааг харуулав.



Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь

2016 онд шүүхийн хараат бус байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны гол онцлог нь 2009 оноос өрнөж буй шүүхийн шинэтгэлийн үр дүн, үйл явцад хөндлөнгийн дүн шинжилгээ, ажиглалт хийх шүүхийн багц хуулийн хэрэгжилтийг бодлогын түвшний мэдээллээр хангах явдал байлаа.



Шүүхийн захиргааны байгууллагын чиг үүргийн хэрэгжилт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ажиглалт хийсний зэрэгцээ мөн Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүдийн нэр дэвшүүлэх, томилох ажиллагаанд ажиглалт хийж хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийлээ.”

Нээлттэй Нийгэм Форумын 2013-2016 оны стратегид шүүх эрх мэдлийн хүрээний хууль, эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэний нийгэм, судлаач эрдэмтдийн хөндлөнгийн дүн шинжилгээ, ажиглалт мониторинг хийх сонирхлыг төрүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх, энэ үндсэн дээр шинэтгэлийн үйл явцыг хэрэгжилтийн явцын талаарх мэдээллээр ханган, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, гарч буй зөрчил дутагдлыг цаг тухайд нь засаж залруулахад хувь нэмэр оруулах зорилго тавьсан юм.

Шүүхийн хараат бус байдлыг хангах судалгаа, шинжилгээ, хэлэлцүүлэг

Шүүхийн шинэтгэлийн үзэл санаа, зорилго шүүхийн тухай багц хууль болон холбогдох бусад хуульд хэрхэн нийцтэй туссан болон эдгээр хуулийг хэрэгжүүлэх үйл явц хуулийн дагуу хэрхэн зохистой өрнөж буйг судлах зорилгоор бодлогын дүн шинжилгээ, үнэлгээ, судалгааны төсөл шалгаруулах уралдаан зарлан хоёр төслийг дэмжлээ. Үүнд, “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: шүүгчийн хариуцлага”, “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд шүүхэд итгэмжлэлээр төлөөлөхтэй холбогдсон эрх зүйн асуудал”.

Нээлттэй Нийгэм Форум нь шүүхийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлсэн шүүхийн шийдвэрийн ил тод байдлын хүрсэн түвшинг сайшаан тэмдэглэж, нийтэд ил болсон шүүхийн шийдвэрүүдийн

www.mglbar.mn сайтыг хэлэлцүүлгийн хэсэг



Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн хариуцлага

Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх үндсэн механизмуудын нэг нь шүүгчийн ёс зүй, хариуцлагыг сахиулах; ёс зүйн хэм хэмжээ зөрчигдсөн тохиолдолд шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо, ажиллагаа байдаг. Энэ нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүгчийн ёс зүйн болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм зэрэг баримт бичгээр зохицуулагддаг. Уг судалгааны хүрээнд шүүгчийн сахилгын хэрэг маргаан шийдвэрлэж буй өнөөгийн практикийг судлан, олон улсын чиг хандлага, сайн туршлагад тулгуурлан Монгол Улс дахь шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор тодорхой зөвлөмжийг Шүүхийн ёс зүйн хороонд хүргүүлээд байна. Уг зөвлөмжид Шүүхийн ёс зүйн хороо, түүний үйл ажиллагааг бэхжүүлэх, дүрмийг шинэчлэх замаар хэрэг маргаан шийдвэрлэх процессын давхардлыг арилгах, нотлох баримт цуглуулах эрх хэмжээг тодорхойлон бататгах, сахилгын хэрэгт холбоотой хөөн хэлэлцэх хугацааг сунгах зэрэг асуудлыг багтаасан болно.

Сайн туршлага ТББ-ын судалгааны баг

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд шүүхэд итгэмжлэлээр төлөөлөхтэй холбогдсон эрх зүйн асуудал

Иргэдэд хууль зүйн чанартай туслалцаа авах эрх болон хууль зүйн үйлчилгээг хүртээмжтэй авах эрхийн хооронд үүсэж буй зөрчилдөөнт асуудлыг уг судалгаагаар хөндөн хуульчдын дунд түгээмэл өрнөдөг маргаанд шийдэл санал болгохыг зорьсон юм. Иргэд аливаа учирсан хэрэг маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх үйл явцад өөрийн төлөөллөөр буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрх нь хууль зүйн мэргэжлийн туслалцаа авахаас ангид асуудал. Үүнийг ялгаж салгаж ойлгоогүйгээс чанартай, мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах иргэдийн эрх бүрэн хангагдахгүй байна гэсэн судалгааны дүгнэлт гарав. Судалгааны дүнд иргэний хэрэг хянан шийдвэрлэх процесст аль тохиолдолд эрх бүхий хуульч оролцох болон аль үед хуульч биш итгэмжлэгдсэн төлөөлөгч оруулж болох талаар нарийвчлан зааж өгөх буюу хууль зүйн туслалцааг итгэмжилсэн төлөөлөгчийн оролцооноос ялгаж өгөхийг зөвлөж байгаа юм.

Судлаач Н.Цэнд-Очир, М.Норовсамбуу,
Ж.Содномдаржаа

үндэслэлд дүн шинжилгээ тогтмол хийж байх нь шүүгчийн ажлын гол илэрхийлэл болох шүүхийн шийдвэрийн чанарыг дээшлүүлэхэд чухал дэмжлэг болно гэж үзсэний үндсэн дээр МУИС-ийн Хууль зүйн сургуулиас ирүүлсэн Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх төслийг дэмжиж тэтгэлэг олголоо. Уг төсөл нь шүүхэд хэрэг маргаан хянан шийдвэрлээд гаргаж буй шүүхийн шийдвэрийн үндэслэл буюу хууль хэрэглэх ажиллагааны академик болон

практик үр нөлөөг дээшлүүлэх, хуулийн сургуулийн оюутнуудад сургалтын хэрэглэгдэхүүн болгох, шүүхийн шийдвэрт хөндлөнгийн байр сууринаас мэргэжлийн үнэлгээ хийх, улмаар шүүгчдийн хууль хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, шүүх дэх олон нийтийн хяналтыг дээшлүүлэх зорилготой юм. Дээрх дүн шинжилгээ нь МУИС-ийн Хууль зүйн сургуулийн улирал тутмын Эрх зүй сэтгүүлд нийтлэгдэж эхлээд байна.

Судалгаа шинжилгээний үр дүн, бодлогын зөвлөмжийг олон нийт, тэр дундаа сонирхогч талуудад хүргэж, хэлэлцүүлэг өрнүүлэхэд анхаарч ирлээ. Түүнчлэн, Монголын хуульчдын холбоотой хамтран шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлд хийгдсэн судалгаа шинжилгээний ажлыг хууль зүйн салбарын хүрээнд буюу шүүгч, өмгөөлөгч, хуульчдад танилцуулж хэлэлцүүлэх ажлыг зохион байгууллаа.

ЭХНИЙ ДУГААРТ НИЙТЛЭГДСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

□ Үндсэн хуулийн цэцийн шийдвэр УИХ-ын эсрэг
Ө.Сэргэлэн, Н. Баасанжав
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн
багш, Хууль зүйн доктор, дэд
профессор О.Мөнхсайхан

□ Эрүүгийн хэргийн анхан болон
давж заалдах шатны шүүхийн
тогтоол болон магадлалд
хийсэн дүн шинжилгээ
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн
багш, Хууль зүйн ухааны доктор,
профессор Ж.Эрдэнэбулган

□ Иргэний хэргийн шүүхийн
шийдвэрийн дүн шинжилгээ
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн
багш, Хууль зүйн ухааны доктор,
профессор Б.Тэмүүлэн

□ Захиргааны хэргийн шүүхийн
шийдвэрт хийсэн дүн
шинжилгээ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн
багш, Хууль зүйн ухааны доктор,
дэд профессор Г.Банзрагч



Дээр дурдсан хэлэлцүүлгийн үеэр болон хэлэлцүүлгийн дараа аймаг, орон нутагт ажиллаж байгаа шүүгч, хуульчдын зүгээс энэ төрлийн хэлэлцүүлэгт хамрагдах, дуу хоолойгоо хүргэх эрмэлзэл их байгаагаа илэрхийлж байлаа. Бодлогын шийдвэр ихэвчлэн нийслэл хотын хэмжээнд хэлэлцэгдэж гардаг нь өрөөсгөл бөгөөд зарим тохиолдолд сөрөг үр дагавартай байдаг тул өргөн оролцоог хангах нь чухал юм. Энэ нөхцөл байдлыг харгалзан Монголын хуульчдын холбооноос өөрийн цахим хуудсыг шинэчлэх, цахим хэлэлцүүлэг явуулах портал хуудас нэмэх замаар энэ боломжийг нээх санаачилга гаргасны дагуу тэтгэлэг олгон хэрэгжүүллээ.

Шүүхийн ажиглалт, мониторинг

2016 оны 10 дугаар сард Ховд хотноо баруун бүсийн болон Дархан хотноо төвийн бүсийн шүүхийн ажиглалтын арга зүйн сургалт зохион байгууллаа. Энэхүү сургалтаар иргэний нийгмийн байгууллагуудыг орон нутгийн шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн ажиглалтын арга зүйтэй танилцуулснаар Монгол Улсын хэмжээнд нийт 20 аймагт иргэний нийгмийн байгууллагууд шүүхийн ажиглалт явуулах чадавхтай болж байна. Үүнээс 13 аймгийн иргэний нийгмийн



байгууллагууд хамтран тус, тусын аймгийн анхан шатны шүүхийн хуралдаанд ажиглалт хийх замаар дадлага төсөл хэрэгжүүлэн практик туршлага олж авлаа. Энэ нь шүүхийн зүгээс иргэний нийгэмтэй



хамтран ажиллах боломжийг нээж өгөхийн зэрэгцээ шүүхийн шинэтгэлтэй холбоотой бодит мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн үйл ажиллагаа болсон юм.

Дээрх зурагт Ховд аймгийн шүүхийн Тамгын газрын дарга Д.Даваасүрэн сургалтын оролцогчдод шүүхийн үйл ажиллагаагаа танилцуулж байгаа нь.

ШҮҮХИЙН АЖИГЛАЛТЫН ДАДЛАГА ТӨСӨЛ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД

БУЛГАН

- Булганы мэдээ сонин
- Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан
- Гэрэлт ирээдүйн оршихуй ТББ
- Хуульч эмэгтэйчүүдийн холбооны Булган аймгийн салбар зөвлөл

ДАРХАН-УУЛ

- Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн салбар
- Мэдээллийн Орхон XXI зуун төв
- Худалдаа аж үйлдвэрийн танхимын салбар
- Дархан-Уул аймгийн эмэгтэйчүүдийн холбоо
- Аз жаргалын эрэлд ТББ

ДОРНОД

- НДЭХ салбар
- Үйлдвэрчний эвлэлийн холбоо
- “НАН”, Хорол тооно ТББ-ууд
- Хүний эрхийн хөгжил төв

ДУНДГОВЬ

- Скаутын холбоо
- Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан
- Үйлдвэрчний эвлэлийн холбоо
- Худалдаа аж үйлдвэрийн танхим – салбар
- Өвдгийн хөх ТББ

ЗАВХАН

- Эмнести интернэшнл Завхан бүлэг
- Улиастай сумын Ахмадын хороо
- Ахмад мэргэжилтний холбоо
- Залуусын өөртөө туслах байгууллага

ШҮҮХИЙН АЖИГЛАЛТЫН
ДАДЛАГА ТӨСӨЛ АМЖИЛТТАЙ
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУД
/үргэлжлэл/

ОРХОН

- Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн салбар
- Эрдэнэт хүмүүний Эв нэгдэл ТББ
- Төр-Иргэн Түншлэл ТББ
- Ариун хэлхээ ТББ

ӨВӨРХАНГАЙ

- “Эх Нутаг Хөгжил” төв ТББ
- Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сан ТББ – салбар
- Хүчирхэг үндэстэн ТББ
- Өвөрхангай аймгийн ХБИ-ийн холбоо

ӨМНӨГОВЬ

- НДЭХ салбар
- Говийн хөгжлийн зуун ТББ
- Ахмадын хороо
- Байгаль орчны холбоо
- Байгаль орчны иргэний зөвлөл – салбар

УВС

- Өсвөр үе ирээдүй Увс төв
- НДЭХ салбар
- Скаутын холбоо – салбар

ХОВД

- ИНБ-уудын албан бус сүлжээ
- Худалдаа аж үйлдвэрийн танхим – салбар
- Казах эмэгтэйчүүдийн Арулар холбооны салбар зөвлөл
- Иргэдийн сайн дурын клуб
- Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах ТББ
- Оролцоо хөгжил ТББ

ХЭНТИЙ

- Ажил олгогч эздийн холбоо – салбар
- ИНБ- уудын сүлжээ
- Хэнтий мэдээ сонин
- Хэрлэн тоонот эко ТББ

Түүнчлэн шүүхийн захиргааны байгууллагын зүгээс Форумын шүүхийн ажиглалтын арга зүйн ач холбогдол, үр нөлөөг хүлээн зөвшөөрч хамтран ажиллаж ирсэн бөгөөд үүний жишээ нь нийслэлийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааны танхимын ашиглалтад мониторинг хийлгэх хүсэлт гаргасан явдал юм. Тус мониторингийн дагуу гарсан зөвлөмжид тулгуурлан шүүхүүд дотоод зохион байгуулалтаа сайжруулснаар шүүх танхим хүлээгдэх явдал арилж шүүхийн захиргааны ажилтнуудын хиймэл ачаалал багассан дүнтэй байна.

Түүнчлэн, шүүхийн захиргааны чиг үүргийн хэрэгжилт болон хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд ажиглалт хийхийн зэрэгцээ Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн гишүүдийн нэр дэвшүүлэх, томилох ажиллагаанд ажиглалт хийж хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхийг зорилоо. Үүний үр дүнд Шүүхийн захиргааны тухай хуульд ШЕЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон томилох талаар салаа утгатай, тодорхойгүй заалтууд орсны зэрэгцээ зарим талаар зохицуулалт байхгүй байгаа нь тус томилгоог хараат бус болсон гэж үзэхэд хүндрэлтэй гэж дүгнэв. Энэ чиглэлд эрх зүйн судалгааны “Оюуны Инноваци” ТББ-тай хамтран ажилласан болно.

Шүүхийн захиргааны ажилтнуудын сургалт

Форум нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлд хөндлөнгийн байр сууринаас судалгаа шинжилгээ, хэлэлцүүлэг өрнүүлэхийн зэрэгцээ шаардлагатай тохиолдолд шүүхийн захиргааны ажилтнуудын хандлага, ур чадварыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж хамтран ажиллаж ирлээ.

2016 оны 11 дүгээр сард ШЕЗ-ийн Захиргаа удирдлагын газрын дарга Ж.Сайнхишигээр ахлуулсан шүүхийн зохион байгуулагчдын төлөөлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй баг Форумын дэмжлэгтэйгээр БНСУ-ын Дээд шүүх, Сөүл хотын дүүргийн шүүх, шүүхийн мэдээллийн төв зэрэг байгууллагын үйл ажиллагаатай танилцав. Суралцах аялалд хамрагдсан анхан шатны шүүхийн зохион байгуулагч нар шүүхэд иргэдийн төлөөлөгч оролцуулах, хэргийн хөдөлгөөний удирдлага, цахим хэлбэрээр нэхэмжлэл авах зэрэг асуудлын хүрээнд шат шатны шүүхийн ажилтнууд, шүүгч, мэдээлэл технологийн ажилтнуудтай уулзаж туршлага солилцлоо.

Дээр дурдсан суралцах аяллын үр дүнг 2016 оны 12 дугаар сарын 19-21-нд зохион байгуулагдсан шүүхийн дотоод зохион байгуулалт хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт, семинарын үеэр дэлгэрэнгүй



хуваалцаж, Монгол Улсын шүүхийн практикт нэвтрүүлэх арга замыг хэлэлцэв. Хоёрдох жилдээ зохион байгуулж буй энэхүү сургалт, семинарыг ШЕЗ-ийн сургалтын хэлтэстэй хамтран шинээр байгуулагдсан шүүхийн сургалтын Баяндөхөм төвд зохион байгуулсан бөгөөд энэ удаад оролцогчид тулгарч буй асуудлыг тодорхойлоод орхих биш, харин шүүх тус бүрийн дотоод нөөц бололцоонд суурилан

идэвх санаачилгатайгаар шийдэлд хүрэх арга замыг эрэлхийлснээрээ онцлогтой байлаа.

Эдгээр үйл ажиллагааны үр дүнд ШЕЗ-өөс 2017 оныг Шүүхийг үйлчилгээний байгууллага болгох жил болгон зарлахын зэрэгцээ шүүхийн захиргааны ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэхэд ач холбогдол өгч ажиллахаа мэдэгдээд байна.

Эхний эгнээний зүүн гар талд: Увс аймгийн шүүхийн зохион байгуулагч О.Батдорж семинарын үеэр танилцуулга хийж байгаа нь.

Хоёр дахь эгнээний зүүн гар талд: Шүүхийн зохион байгуулагчдын семинарын үеэр оролцогчдын гаргасан шүүхийн үйлчилгээний танхимын макет

Эхний эгнээний баруун гар талд: ШЕЗ-ийн Захиргаа удирдлагын газрын дарга Ж.Сайнхишиг цахим шүүхийн үйл ажиллагаатай танилцах үеэр

Хоёр дахь эгнээний баруун гар талд: Суралцах аяллын бүрэлдэхүүн БНСУ-ын Дээд шүүхийн төлөөлөгчдийн хамт

Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь




Сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөж буй эрх зүйн шинэтгэл, тэр дундаа томоохон хууль тогтоомжийн шинэчлэлийн талаар иргэд мэдээлэл багатай байгаагаас хуулиар олгогдсон эрх, боломжоо бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Энэ нь амьдрал дээр хуулийн хамгаалалт жигд, тэгш бус үйлчлэх нэг шалтгаан болж байгааг судалгааны дүн харуулав.

Өнгөрсөн жилээс Нээлттэй Нийгэм Форум Монгол Улсад иргэдийн хэрэгцээнд суурилсан, баталгаатай, тогтвортой хууль зүйн анхан шатны туслалцаа, эрх зүйн албан бус боловсрол, мэдээлэл олгох тогтолцоог албан ёсоор бий болгоход нөлөөлөл, дэмжлэг үзүүлэх зорилгоор “Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх

нь” хөтөлбөрийг эхлүүллээ. Тус хөтөлбөр нь Нээлттэй Нийгэм Сангуудаас 2020 он хүртэл хэрэгжих олон улсын санаачилгын нэгэн хэсэг болж байгаа бөгөөд эрх зүйн тогтолцоо, эдийн засгийн чадавх, газар зүйн байрлал зэрэг олон талын төлөөлөл болсон 10 улсад нэгэн зэрэг хэрэгжиж байна.

Иргэдэд тохиолддог нийтлэг бэрхшээл /судалгааны дүн/



- Ажил хөдөлмөр эрхлэлт
- Мөнгө, санхүү
- Газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Хөршийн эрх
- Нийгмийн даатгал, нийгмийн халамж
- Хэрэглэгчийн эрх
- Төрийн үйлчилгээ авах харилцаа
- Орон сууц, барилга, нийтийн аж ахуй
- Хууль сахиулах, цагдаагийн үйлчилгээ
- Суурь боловсролын үйлчилгээ
- Ялгаварлал
- Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох, нөхөн төлбөр
- Татвар, бүртгэл, шүүх, нотариатын үйлчилгээ
- Гэр бүлийн харилцаа



Иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдал

2016 онд иргэдийн өдөр тутмын амьдралд нийтлэг тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, түүнийгээ хууль, эрх зүйн боломжийг ашиглан шийдэх чадавхтай байгаа эсэхийг тогтоох зорилгоор үндэсний хэмжээний судалгааг Форумын судалгааны зөвлөх Х.Номингэрэл болон Хараат бус судалгааны хүрээлэнтэй хамтран гүйцэтгэлээ.

Уг судалгааг 7 аймгийн 30 сум, нийслэлийн 4 дүүргийн нийт 1630 иргэнийг хамруулан нүүр тулсан ярилцлагын аргаар хийв. Судалгаанд хамрагдсан иргэдэд сүүлийн 3 жилд бодитой тулгарсан хууль зүйн үр дагавар бүхий бэрхшээл байсан эсэх, байсан бол түүнийгээ шийдвэрлэж буй арга замыг нь тодорхойлох замаар иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдлыг үнэлэхийг зорилоо.

Дээрх зурагт: Хараат бус судалгааны хүрээлэнгийн судлаачид орон нутгийн иргэдтэй ярилцаж, судалгаа авч байгаа нь

Энэхүү судалгааны арга зүй нь сүүлийн хориод жилийн хугацаанд олон улсын хэмжээнд хууль зүйн үйлчилгээний хүртээмж, эрэлт хэрэгцээг судлах дэвшилтэт арга зүй болж ирсэн юм. Бид энэхүү арга зүйг Монгол Улсын нөхцөл байдалд нийцүүлэн боловсруулахын зэрэгцээ олон улсын хэмжээнд харьцуулагдахуйц байхад анхаарч ажиллалаа.

Судалгааны дүнгээс харахад Монгол Улсын нийт иргэдийн 54,8 хувьд нь ямар нэг байдлаар хууль зүйн үр дагавар бүхий бэрхшээл учирсан байх бөгөөд тэдний 50,5 хувь нь бэрхшээлээ шийдэх аливаа оролдлого алхам хийгээгүй байна. Үүний шалтгааныг 40,1 хувь нь ямар эрхтэйгээ болон ямар алхам хийх ёстойгоо мэдэхгүй; 36,8 хувь нь юу ч хийгээд нэмэргүй гэж бодсон гэж хариулсан нь иргэдэд эрх, ашиг сонирхлоо

НЭЭЛТТЭЙ НИЙГМИЙН САНГУУДЫН ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ УЛС ОРНУУД

- АНУ
- Индонези
- Македони
- Молдав
- Монгол
- Непал
- Пакистан
- Өмнөд Африк
- Сьерра Лион
- Украин

ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ГЭДЭГ НЬ:

- Иргэдийн мэдээлэл хайх, эрэлхийлэх, олж авах эрхийг баталгаажуулах замаар эрх зүйн хүрээнд бий болсон боломжийг мэдэхэд нь туслах;
- Олж авсан мэдээллээ ашиглан хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадвар, нөхцөл боломжоор хангах; хуулийн хүрээнд эрх ашгаа хангуулах, хамгаалуулах; аливаа бэрхшээл учирсан үед зөрчигдсөн эрхээ нэхэмжлэх чадвар, боломжоор хангах;
- Хууль, бодлогын хүрээнд гаргаж буй аливаа шийдвэр нь иргэдийн хууль ёсны ашиг сонирхолтой зөрчилдсөн тохиолдолд иргэд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад оролцож үзэл бодол, байр сууриа илэрхийлж сонсгох боломжоор хангах харилцан хамааралтай үйл явц юм.

“ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ” БҮСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2016 ОНЫ 12 САРЫН 1:
ТӨВИЙН БҮС - УЛААНБААТАРТ:

Нийслэл хот болон Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Төв аймгууд

2016 ОНЫ 12 САРЫН 5:
ЗҮҮН БҮС - ЧИНГИС ХААН ХОТОД

Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгууд

2016 ОНЫ 12 САРЫН 9
БАРУУН БҮС - ХОВД ХОТОД

Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Завхан аймгууд

2016 ОНЫ 12 САРЫН 13:
ТӨВИЙН БОЛОН ГОВИЙН БҮС - АРВАЙХЭЭР ХОТОД

Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Архангай аймгууд

Дээрх хуваарийн дагуу цуврал хэлэлцүүлэг зохион байгуулагдаж 750 гаруй иргэд оролцлоо.

хуулийн дагуу хамгаалах чадавх сул байгаагийн илрэл юм. Бэрхшээлээ шийдвэрлэх аливаа оролдлого хийсэн иргэдийн хувьд ойр дотнынхондоо хандах нь түлхүү бөгөөд зохих үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага, хуульч, өмгөөлөгчид хандах байдал хангалтгүй байна.

Иргэдийн хувьд амьдарч буй нутаг орныхоо Засаг даргын тамгын газар, боломжтой бол ойр байрлах хуульч өмгөөлөгчид хандах болон тусгайлсан цахим хуудаснаас мэдээлэл, үйлчилгээ авбал илүү хялбар дөхөм гэж үзсэнийг судалгааны дүнгээс харж болно.

Форум энэ судалгааг тогтмол давтамжтай хийж, түүнд суурилсан бодлогыг хууль зүйн салбар тодорхойлж хэрэгжүүлдэг болоход чиглэсэн нөлөөллийн ажил эхлүүлээд байна.

Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний хөтөлбөр

2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд бий болсон шинэ Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрх зүйн чадавхыг дээшлүүлэх үзэл баримтлалыг тусган хэрэгжүүлэхэд бодлогын нөлөөлөл хийж ХЗДХЯ-тай хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд онцгойлон анхаарч ажиллалаа.

ХЗДХЯ-ны Бодлогын

хэрэгжилтийг зохицуулах газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төв, ХЭҮК, орон нутгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтэс зэрэг төрийн байгууллагын төлөөлөл, Хууль зүйн клиник төв, Глоб интернэшнл зэрэг иргэний нийгмийн байгууллага, Швейцарын хөгжлийн агентлагийн Иргэдийн оролцоо төсөл зэрэг хандивлагчийн төлөөлөл бүхий төслийн зөвлөлдөх баг нөлөөллийн болон судалгааны зөвлөхийн оролцоотой харилцан мэдээлэл солилцох, иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх үзэл санааг таниулан сурталчлах цуврал уулзалт зохион байгуулав. Мөн төсөл хэрэгжүүлж буй эрх зүйн бүлийн хувьд адил төстэй бусад орны туршлага, сургамжаас суралцуулах зорилгоор зөвлөлдөх багийн гишүүдийг Молдав, Украин улсуудын хууль зүйн анхан шатны үйлчилгээ, эрх зүйн мэдээлэл түгээх тогтолцоотой танилцах аялалд хамрууллаа.

Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх тогтолцоог бий болгоход анхаарах чухал асуудал болох тогтвортой санхүүжилтийн талаар Канадын Оттава хотод зохион байгуулагдсан олон улсын хуралдаанд зөвлөлдөх багийн гишүүд оролцон мэдлэг мэдээлэл олж авав.

Нөлөөллийн ажлын үр дүнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний хөтөлбөр



боловсруулж, хэрэгжүүлэх замаар иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх зорилт тусгагдав. Улмаар ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, төслийн зөвлөх Ж.Хунан, Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа нар Унгар Улсын Будапешт хотод Төв Европын их сургуулиас зохион байгуулсан Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх манлайлагчдын сургалтад хамрагдаж цаашдын хамтын ажиллагааны цар хүрээ болон үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалыг тодорхойлж чадсан юм.

2016 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Форум нь ХЗДХЯ-тай хамтран “Иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдал” сэдэвт үндэсний хэмжээний цуврал хэлэлцүүлэг эхлүүлсэн бөгөөд эхний хэлэлцүүлэгт нийслэлийн 9 дүүрэг, төвийн

Дээрх зурагт: 2016 оны 12 дугаар сарын 1-нд Хууль сахиулахын их сургуульд зохион байгуулсан бүсийн зөвлөлдөх хэлэлцүүлэг

Баруун гар талд: ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал нар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж байгаа нь



6 аймгийн иргэд, төрийн байгууллагуудын төлөөлөл оролцож судалгааны дүн, үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалтай танилцаж санал шүүмжээ өгсөн юм. Энэ үеэр ХЗДХЯ болон ННФ-ын хооронд бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийг боловсруулах чиглэлд хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Үндэсний зөвлөлдөх хэлэлцүүлэг нь нийт 21 аймаг, 330 гаруй сумаас төлөөлөл оролцуулан бүсчилсэн хэлбэрээр

зохион байгуулагдсан бөгөөд хэлэлцүүлгийн үеэр иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдал судалгааны үр дүн, Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийн үзэл баримтлал, эрх зүйн цахим хөтөч www.e-khutuch.mn сүлжээний талаар танилцуулга хийгдэв. Оролцогчид иргэдэд нэн шаардлагатай эрх зүйн мэдээлэл, хууль зүйн анхан шатны тусламжийг хэн, хэрхэн хүргэх боломжтой талаар тодорхой санал, зөвлөмжөө хуваалцсан нь үндэсний хөтөлбөр боловсруулах ажилд үнэтэй хувь нэмэр болов.

Сонгууль, улс төрийн санхүүжилт

Иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хангасан чөлөөт, шударга сонгууль нь ардчилсан тогтолцооны амин чухал үнэт зүйл билээ. Монгол Улс 1992 онд Үндсэн хуулиа баталснаас хойш 2016 онд долоо дахь удаагаа төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулав. Энэ удаагийн сонгууль нь хууль, эрх зүйн шинэ орчинд явагдсанаараа онцлог болсон юм.

“
2016 оны
УИХ-ын сонгуулийн
санхүүжилтийн
шинэ зохицуулалтын
хэрэгжилт, үр дүнг
үнэлэх зорилгоор
иргэний нийгмийн
байгууллагууд
сонгуулийн
санхүүжилтэд
мониторинг хийлээ.”

Улсын Их хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-нд баталсан Сонгуулийн тухай хуулиар өмнө нь тус тусдаа хуулиар зохицуулж байсан УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн сонгуулиудыг нэгтгэсэн зохицуулалт хийсний зэрэгцээ 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр сонгуулийн холимог тогтолцоог олонхийн буюу мажоритар тогтолцоогоор солив.



“Санал бүхэн үнэ цэнэтэй” уриан дор болсон “Миний гар” артивизм арга хэмжээний үеэр онгогчдын саналыг илэрхийлэх утга бүхий 500 ширхэг гарын баримлыг иргэд өөрийн хүссэн өнгө, сэтгэмжээр урлан будсан. Эдгээр гарын баримлыг чөлөөт уран бүтээлч Б.Мөнхцэцэг бүтээв.



Сонгууль хаяанд ирсэн үед ийнхүү хуульд томоохон өөрчлөлт хийж байсан тохиолдол урд өмнө гарч байгаагүй ба үүнээс улбаатай сонгуулийн бэлтгэл ажил зарим талаар удаашрах, түүнчлэн сонгуульд оролцохоор зэхэж байсан нам, улс төрчдийн зүгээс сонгууль шударга явагдах эсэхэд эргэлзэх хандлага ажиглагдаж

байлаа. Цаашид ийм үзэгдэл давтагдах нь сонгуульд итгэх олон нийтийн итгэлийг сэвтээх сөрөг нөлөөтэй болох нь тодорхой харагдаж байв.

ННФ-ын зүгээс сонгуулийн хуулийг шинэчлэх явцад улс төрийн намуудын төлөөлөл болон бусад талуудыг оролцуулан таван

удаагийн цуврал хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд эдгээрээс гурав нь сонгуулийн шинэчлэлийн чухал асуудал болох санхүүжилтийн асуудлыг тал бүрээс нь нарийвчлан авч үзэхэд чиглэж байв.

Улмаар 2015 оны эцсээр УИХ-аас баталсан дээрх хуульд сонгуулийн зардлыг тайлагнах,

2016 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН
САНАЛ ХУРААХ, ТООЛОХ
АЖИЛЛАГААНЫ АЖИГЛАЛТ

Ажиглалт нь сонгуулийн өдрийн 06:00 цагаас хэсгийн хороод санал хураалтад бэлтгэснээс эхлэн санал хураах, санал тоолох үйл ажиллагаа, техникийн тооллого болон сонгуулийн эцсийн дүнг хэсгийн хороод хуралдаанаараа батлах үйл явцыг хамрав. Төрлийн хувьд суурин ажиглалт хийсэн бөгөөд сонгуулийн баримт бичгийг тээвэрлэн дээд шатны сонгуулийн хороонд хүргэх ажиллагааг хянаагүй болно. Иргэний нийгмийн ажиглагчид нь төслийн багаас урьдчилан боловсруулсан сонгуулийн санал авах, тоолох үйл ажиллагааг шалгах хуудас, санал тоолох үйл ажиллагааны үнэлгээний хуудас, санал тоолох үед гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг бүртгэх хүснэгтийг зааврын дагуу бөглөж, цугласан мэдээллээ фото зургийг нь авах, видео бичлэг хийх, баримт бичгийг хуулбарлан авах, урьдчилан бэлтгэсэн ажиглалтын болон үнэлгээний маягт бөглөх аргаар баримтжуулсан болно.

Төрийн бус байгууллагын 202 ажиглагчийн ирүүлсэн мэдээллийг нэгтгэн үзвэл 2016 оны УИХ, Нийслэлийн ИТХ-ын сонгуулийн санал хураах, тоолох, дүнг гаргах үйл явц хуулийн хүрээнд явагдсан ба сонгуулийн дүнд нөлөөлөхүйц ноцтой зөрчил гараагүй гэж дүгнэж байна. Ажиглалт хийсэн хэсгийн хороодод зохион байгуулалтын болон тохиолдлын чанартай жижиг зөрчлүүд гарсан ч энэ нь санал тооллогын дүнд сөрөг нөлөө үзүүлээгүй байна.

хяналтыг сайжруулахтай холбоотой хэд хэдэн чухал өөрчлөлт тусгалаа олсныг онцлох нь зүйтэй. Тухайлбал, уг хуулиар анх удаа сонгуульд оролцохоор хүсэлт гаргаж буй улс төрийн нам, эвсэл сүүлийн нэг жилийн хугацаанд иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан хандивын тайлангаа; нэр дэвшигчдийн хувьд хөрөнгө орлогын мэдүүлгээ СЕХ-нд хүлээлгэн өгөх зохицуулалт шинээр нэмэгдсэн юм. Энэ нь сонгуулийн санхүүжилтийн мэдээллийг сонгуулиас өмнө ил тод, хяналттай болгоход чиглэсэн чухал өөрчлөлт болсон. Түүнчлэн өмнө нь СЕХ-ны хариуцан гүйцэтгэдэг байсан нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайланд хяналт тавих үүргийг Төрийн аудитын байгууллагад шилжүүлэн хариуцуулсан ба тус байгууллага нь хяналт тавих үүргээ хэрэгжүүлэхдээ Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтарч ажиллах бололцоотой байдлаар хуульчилж өгчээ.

ННФ-аас 2016 оны сонгуулиар сонгуулийн санхүүжилттэй холбоотой хуульд туссан дээрх шинэ зохицуулалтын хэрэгжилт, үр дүнг үнэлэх зорилгоор “Сонгуулийн санхүүжилтийн мониторинг”-ийг “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-ний гишүүн “Филантропи” Хөгжлийн Төлөө Төв ТББ болон Төв, Өмнөговь аймгуудын иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээ, сайн дурынхантай

хамтран хэрэгжүүлээ. Мониторингийн хүрээнд сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг 3 үе шаттайгаар буюу сонгуулийн санал хураах өдрөөс өмнөх үе, сонгуулийн кампанит ажлын үе, санал хураалт явагдсан өдрөөс хойших үе гэж ангилан хуулийн хэрэгжилтэд бие даасан хяналт тавив. Ийнхүү мониторинг хийхэд сонгуулийн бүхий л үе шатанд улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн санхүүжилтийн мэдээлэл ил тод бус, түүнд тавих хяналт хангалтгүй байгаа нь харагдсан. Мониторингийн үр дүнд үндэслэн ННФ хуулийг цаашид яаж боловсронгуй болгох, түүнчлэн хэрэгжилтийг нь хэрхэн сайжруулах талаар тодорхой зөвлөмж гарган олон нийт, холбогдох талуудад хүргээд байна.

Сонгуулийн санхүүжилтийн мониторингоос гадна сонгуулийн үйл явцын ил тод байдлыг ханган, зөрчил маргаанаас сэргийлэхэд гол нөлөөтэй гэж үзсэн хэд хэдэн чиглэлээр 2016 оны УИХ-ын сонгуулийн үйл явцад бие даасан хяналт тавих ажлыг мөн “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-тэй хамтран хэрэгжүүлээ.


Тухайлбал, Сүлжээний гишүүн МИДАС ТББ нь сонгуулийн автоматжуулсан системд хөндлөнгийн мониторинг хийх ажлыг хариуцан ажилласан. Монгол Улс сонгуулийн санал тоолох автомат



Дээрх зурагт: Сонгуулийн мониторинг хийсэн иргэний нийгмийн сүлжээний гишүүд болон сайн дурын ажиглагчид

СОНГУУЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН МОНИТОРИНГИЙН ҮР ДҮНГЭЭС

төхөөрөмжийг 2012 оны УИХ болон Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд анх ашигласан билээ. 2016 оны сонгуулийг угтан улс төрийн намуудын зүгээс автомат төхөөрөмжийн найдвартай ажиллагаанд эргэлзэн, хүчтэй шүүмжлэх хандлага ажиглагдаж байсныг энд дурдах нь зүйтэй. Эргэлзээ маргаантай байгаа энэ асуудлыг анхааралдаа авч МИДАС ТББ-ын мэргэжилтнүүд СЕХ-ны дэргэдэх Мэдээллийн технологийн ажлын хэсгээс санал тоолох төхөөрөмжүүдийг сонгуульд туршин бэлтгэх, баталгаажуулж, гэрчилгээжүүлэх ажлыг хөндлөнгөөс ажигласан ба төхөөрөмжүүдээс санамсаргүй байдлаар сонгон



авч боловсруулсан тестийн тавил, хувилбаруудаараа бие даасан тест хийв. Сонгуулийн үеэр дээрх ажиглалт, туршилтын үр дүнг тухай бүр олон нийтэд шуурхай танилцуулахад ННФ дэмжлэг үзүүлж ажиллав.

2016 оны сонгуулийн сурталчилгаа нь Сонгуулийн тухай хуулийн дагуу 6 дугаар сарын 11-27-ны өдрийг

дуустал нийт 18 хоногт буюу харьцангуй богино хугацаанд явагдсан билээ. Энэ хугацаанд сонгогчдыг тэнцвэртэй үнэн зөв мэдээллээр ханган нэр дэвшигч, улс төрийн нам, эвслийн байр суурийг ойлгуулах, зөв сонголт хийхэд туслах чухал үүрэгтэй хэвлэл мэдээллийн хөтөлбөрт ажиглалт хийхэд нь "Глоб Интернэшнл төв" ТББ-д дэмжлэг

2016 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН
САНАЛ ТООЛОХ ҮЙЛ ЯВЦЫН
АЖИГЛАЛТ

Санал тоолох үйл явцыг төрийн бус байгууллагын 101 ажиглагч хэсгийн хороодод биечлэн ажигласан бөгөөд үүнээс 86 хувьд нь санал тоолох үйл ажиллагааг бүхэлд нь ажиглаж болохуйц байсан. Ажиглагчдын мэдээллээс үзвэл санал тоолох явцад ноцтой зөрчил, дутагдал гараагүй бөгөөд нээлттэй, ил тод явагджээ.

Хэсгийн хороодын 83 хувьд нь санал тоолох ажиллагааны үед санал тоолох төхөөрөмж эвдэрч, гацаагүй, 79 хувьд санал тоолох ажиллагаа завсарлалгүй, шууд явагдсан гэсэн бөгөөд зарим хороодод санал тоолж хэвлэх үед цаас нь дууссан, тоолж эхлэх гэсэн зааварчилгаа хүлээгдсэн, СЕХ-оос техникийн тооллого явагдах эсэхийг хүлээсэн, намын төлөөлөл нэмж орж ирсэн зэрэг шалтгаан байсан байна.

Ийнхүү нийт хэсгийн хороодын 92 хувь нь саналын хуудасны дүнг ажиглагчдад хэвлэж өгсөн ба 73 хувь нь дүнг уншиж сонгон, 82 хувь нь нэн даруй мэдээлжээ. Мөн 82 хувь нь саналын хуудасны зурган файлыг ажиглагчдад CD дээр хуулж өгсөн боловч бусад хэсгийн хороод техникийн мэдлэг болон бэлтгэл хангалтгүй, зурган файлыг хуулж авах хүсэлтээ бичгээр гаргах, заавал DVD авчрахыг шаардсанаас зарим хэсгийн хорооноос ажиглагчид мэдээллийг авч чадсангүй.

үзүүлээ. Мониторингийн хүрээнд үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлэг эрхэлдэг телевизийн таван сүвгийн нийт 1626 цаг 41 минут 46 секундын хөтөлбөрт ажиглалт хийжээ.

Мониторингийн тайланд дээрх телевизийн сүвгуудын мэдээний хөтөлбөр нь нам, эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгаа болон хувирсан ба хуульд заасан сурталчилгааны цагийн хязгаарыг хэтрүүлсэн зэрэг зөрчлийг дурдаж цаашид ямар арга хэмжээ авах нь зүйтэй талаар тодорхой зөвлөмж боловсруулан танилцуулжээ.

Дээрх хэд хэдэн чиглэлээр хийж гүйцэтгэсэн мониторинг, ажиглалтаас гадна сонгуулийн өдрийг угтан сонгогчдын боловсролд зориулсан шинэлэг арга хэмжээ зохион байгуулахад иргэний нийгмийн залуустай хамтран ажиллав. “Санал бүхэн үнэ цэнэтэй” уриан дор 2016 оны 6 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд болсон “Миний гар” хэмээх артивизм буюу “арт+активизм” олон нийтийн оролцооны урлагийн арга хэмжээний үеэр чөлөөт уран бүтээлч Б.Мөнхцэцэгийн бүтээсэн сонгогчдын саналыг илэрхийлэх утга бүхий 500 ширхэг гарын дүрстэй баримлыг иргэд өөрийн хүссэн өнгө, сэтгэмжээр урлан будсан. Иргэдийн оролцоотой амилсан эдгээр бүтээлийг олон нийт үзэж сонирхох боломжтой задгай талбайд байрлуулсан нь олны анхаарлыг татсан арга хэмжээ болов. Ийнхүү иргэдийн өөрсдийнх нь бүтээлч сэтгэхүйд

тулгуурлан зохион байгуулсан арга хэмжээний үеэр нийт 3,000 орчим сонгогчид сонгуульд идэвхтэй оролцохын ач холбогдлыг таниулсан мэдээллийг түгээсэн болно.

Энэ дашрамд дурдахад “артивизм” гэдэг нь тулгамдаж буй нийгмийн асуудлаар тодорхой байр суурийг бүтээлч байдлаар илэрхийлэн бусадтай урлагаар холбогдохыг ойлгоно. Уран бүтээлчид ийнхүү урлагаар дамжуулан нийгмийн чухал асуудлыг хүмүүст хүргэх нь нөлөөллийн хамгийн үр дүнтэй аргад тооцогдог дэлхийн чиг хандлага болоод байна.

Сонгуулийн үйл явцын хамгийн чухал үе шат нь санал хураах өдөр билээ. 2016 оны 6 дугаар сарын 29-нд тохиосон эл чухал өдөр Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний сайн дурын 202 ажиглагч Улаанбаатар хотын сонгуулийн хороодын 25 хувь буюу 101 хэсгийн хороон дээр ажиллаж ажиглалт хийв. Ажиглалт нь сонгуулийн санал хураах өдрийн 06:00 цагаас эхлэн санал хураах, санал тоолох ажиллагаа, техникийн тооллого болон сонгуулийн эцсийн дүнг хэсгийн хороод хуралдаанаараа батлах үйл явцыг хамарсан. Ажиглалтад хамрагдсан 101 хэсгийн хорооноос 23-т нь техникийн тооллого явагдсан ба эл үйл явцыг ажиглагчид 6 дугаар сарын 30-ны өдрийн өглөө хүртэл бүхэлд нь ажигласан юм.

Эцэст нь сонгуулийн ажиглалт, мониторингийн дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд цаг алдалгүй хүргэх, улс төрийн санхүүжилтийн сэдвээрх мэдээ, мэдээллийг олон нийтэд тогтмол, үе шаттайгаар хүргэх, энэ сэдвээр сэтгүүлчдийн ойлголт, мэдлэгийг гүнзгийрүүлэх зорилгын хүрээнд 2014 онд байгуулсан сэтгүүлчдийн клубт дэмжлэг үзүүлэн хамтын ажиллагаагаа 2016 онд үргэлжлүүлээ. Клубийн гишүүд тогтмол уулзан сонгуулийн шинэ хууль болон улс төрийн намын тухай хуулийн шинэчлэл, санхүүжилтийн ил тод байдал, хариуцлага, хяналтын механизмын талаар мэдээлэл солилцон мөн судлаач, иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран мэдээ нийтлэл бэлтгэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ирлээ. 2016 онд клубийн гишүүн дөрвөн сэтгүүлчийг 2016 оны 9 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд Балба Улсын Катманду хотноо болох Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн Азийн 2 дахь удаагийн бага хуралд оролцоход нь дэмжлэг үзүүллээ. “Азийг эрэн сурвалжлахуй” сэдвийн дор болох уг арга хэмжээг Дэлхийн Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сүлжээ, Балба Улсын Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төв, Конрад-Аденауэр сантай хамтран зохион байгуулсан билээ. Уг үйл ажиллагаа нь эрэн сурвалжлах болон дата сэтгүүл зүйн чиглэлээр ажилладаг сэтгүүлчдийн чадавхыг бэхжүүлэх, мэргэжил

нэгтнүүдтэйгээ сүлжээ үүсгэн хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилготой байв.

Олон нийтийг мэдээллээр хангах ажлын хүрээнд сэтгүүлчидтэй хамтран ажиллахаас гадна МИДАС ТББ-тай хамтран Улс төрийн томоохон албан тушаалтнуудын хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхлын мэдээлэл, нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан зэргийг нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор www.shilennam.mn цахим мэдээллийн санг өргөжүүлэн хөгжүүлэхэд анхаарч ирлээ. Энэхүү сайтаас сонгуульд өрсөлдөж байсан намууд тухайн сонгуулийн жил хаанаас, ямар хэмжээний хандив авсан хамаарлыг нэгтгэн, харьцуулж харах боломжтойгоос гадна бизнесийн аль салбараас түлхүү хандив авч байгааг мөн үзүүлэхийг зорьж байна. Энэ мэдээлэл ил болсноор бодлого боловсруулагчдын гаргаж буй шийдвэрт мөнгөний нөлөө хэрхэн тусч буйг сонгогчид хянах боломж бүрдэх сайн талтай.

Доорх зурагт: МИДАС төрийн бус байгууллагын ажилтнууд сонгуулийн автомат төхөөрөмж дээр тест хийж байгаа нь

2016 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТЕХНИКИЙН ТООЛЛОГЫН АЖИГЛАЛТ:

Төрийн бус байгууллагын ажиглалтыг зохион байгуулах багийн төлөөлөл 8 дүүрэгт техникийн тооллого явагдах хэсгийн хороодыг сугалаагаар шодоход хөндлөнгийн ажиглалт хийж оролцсон. Ийнхүү бидний ажигласан 101 хэсгийн хорооноос 23 нь техникийн тооллого хийгдэхээр сонгогдсон юм.

Ажиглагчдын мэдээллээс үзэхэд техникийн тооллого явагдах үйл явц ажиглагчдад 100 хувь нээлттэй явагдсан ба СЕХ-оос баталсан журмын дагуу хийгджээ. Техникийн тооллого дунджаар 1:30 минутын дараа эхэлж дунджаар 4-12 цаг үргэлжилсэн.

Мөн энэ хэсгийн хороодын 7 дээр нь саналын хуудас болон санал авах машины санал зөрөх тохиолдол гарсан байна. Тодруулбал 1-10 саналын зөрүү гарах тохиолдлууд байсан ба шалтгаан нь нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг хэтрүүлэн тэмдэглэсэн, мөн хэсгийн хороодын ажилчид олон цаг завсарлалгүй ажилласнаас алдаж тоолох тохиолдлууд ажиглагджээ.



Төрийн ил тод хариуцлагатай байдал

Нээлттэй Нийгэм Форумын 2014–2017 оны стратегид төрийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг бодитой хангахад хувь нэмрээ оруулах зорилго дэвшүүлсэн билээ. Энэ зорилготой холбогдуулан ННФ-аас төрийн ил тод байдал, хариуцлагын механизмыг зохицуулж буй гол хуулиудын хэрэгжилтэд иргэний нийгмийн зүгээс тавих хяналтыг тогтмолжуулах, улмаар хэрэгжилтийг сайжруулах нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зэрэг ажлыг санаачлан зохион байгуулж ирлээ.

Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм

ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦОО

УИХ-аас захиргааны үйл ажиллагааг нэгдсэн стандартад оруулж, иргэдийн оролцоог баталгаажуулсан Захиргааны ерөнхий хуулийг 2015 оны 6 дугаар сарын 19-нд баталсан бөгөөд тус хууль нь энэ оны 7 дугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн билээ. Захиргааны ерөнхий хуулиар захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн шийдвэр, үйл ажиллагааг томъёолж өгөхийн зэрэгцээ, үйл ажиллагаа явуулах үе шатыг нарийвчлан зохицуулснаараа захиргааны байгууллагын дур зоргоор авирлахыг хязгаарлаж, харилцааны нөгөө тал болох иргэн, хуулийн этгээдэд захиргааны шийдвэр гаргах

үе шатад оролцох эрхийг нээж өгснөөрөө түүхэн ач холбогдолтой.

Захиргааны байгууллага нь захиргааны акт гаргахдаа нөхцөл байдлыг судлах, нотлох баримт цуглуулах, эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх этгээдийг сонсох, эцэст нь хаяглагдсан этгээдэд мэдэгдсэний үндсэн дээр шийдвэр хүчин төгөлдөр болохоор хуульчилсан нь захиргааны байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлж, шийдвэрийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс хамгаалах үндэс суурийг тавьж өгсөн юм. Үүний дүнд захиргааны шийдвэр гаргах шатанд иргэдийг оролцуулах эсэх нь тухайн захиргааны байгууллага, албан тушаалтны үзэмжээр шийдэгддэг байсныг халж, гарцаагүй оролцуулах нөхцлийг зааснаараа иргэд захиргааны үйл ажиллагаанд өөрийн хүсэл сонирхлоор

оролцох боломжийг олгосон билээ.

ННФ нь захиргааны шинэчлэлийн үйл явцад идэвхтэй оролцохыг эрмэлзэж ирсэн бөгөөд холбогдох хуулиудын ажлын хэсэгт орж ажиллах, хуулийн төсөлд санал, шүүмж өгөх, шинэ хуулийн үзэл баримтлал, зохицуулалтыг иргэд, иргэний нийгэмд сурталчлан таниулах сургагч багш бэлтгэх сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, иргэд, иргэний нийгмийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр дэмжин ажилласан билээ. Зөвхөн хуулийн төсөлд санал шүүмж өгөөд зогсолгүй хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс аймаг, нийслэл, сум, дүүргийн нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд нэгдсэн удирдамжаар мониторинг хийх ажлыг эхлүүлсэн юм. Мониторинг хийх төрийн бус байгууллагыг урьдчилан



сургалтад хамруулж бэлтгэсэн бөгөөд мониторингийн дунд шатанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор нэгдсэн сургалт уулзалтыг зохион байгуулсан билээ. Мониторингийг 2016 оны 7 дугаар сарын 1-ээс 12 дугаар сарын 31-нийг дуустал 21 аймаг, нийслэл, 21 сум, 8 дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Засгийн газрын нэг агентлагийг оролцуулан хэрэгжүүллээ.

УИХ, орон нутгийн сонгууль явагдсан жил Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэн нь онцлог байлаа. Сонгуулийн дараагаар бүтцийн өөрчлөлт, төрийн албан хаагчдын халаа сэлгээ

явагдсан нь Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг сааруулж, мониторингийн явцад зарим хүндрэлийг учруулсан. Тухайлбал, Захиргааны ерөнхий хууль баталснаас хойших хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэл нэг жил орчмын хугацаанд хэрэгжилтийн бэлтгэлийг хангах хүрээнд үндэсний хэмжээнд төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг төр, олон улсын байгууллагууд хамтран шат дараатайгаар хийсэн хэдий ч сонгуулийн дараа төрийн албан хаагчдын халаа сэлгээ их хийгдсэний улмаас шинээр томилогдсон албан хаагчид хуулиа мэдэхгүй байх нь түгээмэл тохиолдсон юм.

Дээрх зурагт: Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх Төрийн бус байгууллагыг чадавхжуулах сургалтын явцаас.



Увс аймгийн ЗДТГ-ын архивт гарсан тогтоол, шийдвэр, захирамжтай танилцаж байгаа нь

ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Нийслэл Улаанбаатар хот, 21 аймгийн нийт 33 ТББ-дад “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх нь” сэдвээр 6-р сард 3 өдрийн сургалт зохион байгуулав.
- 21 аймаг, нийслэл, 21 сум, 8 дүүргийн ИТХ, ЗДТГ, Засгийн газрын нэг агентлагийн шийдвэр гаргах ажиллагаа Захиргааны ерөнхий хуулийг баримталж буй эсэхт хийх мониторингийг хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс он дуустал нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлээ.
- Мониторинг хийж байгаа ТББ-дад тулгарч буй асуудалд туслах, мэдээллээр хангах, явцын үр дүнг сонсох зорилгоор дунд хугацааны уулзалт хэлэлцүүлгийг хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн гишүүдтэй хамтран 11-р сард зохион байгууллаа.

Захиргааны байгууллагын үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаж буй эсэхэд анх удаа иргэний нийгмийн байгууллага мониторинг хийсэн нь онцлог байв. Учир нь мониторингид хамрагдсан захиргааны байгууллагын зүгээс төрийн бус байгууллага энэ асуудлаар мониторинг хийх эрх зүйн чадамжтай эсэх, мониторинг хийх зөвшөөрлийг хэн олгосон, ямар зорилготой болох, улс төрийн зорилгоор ашиглахгүй гэх баталгаа байгаа эсэх зэрэгт ихээхэн эргэлзэж байсан бөгөөд энэ нь мониторинг хийх төрийн бус байгууллагуудаас шаардаж байсан мэдээлэл, баримтаар нотлогдож байгаа билээ. Үүний улмаас мониторингийн эхэн үед мэдээлэл олж авахад ихээхэн хүндрэлтэй тулгарсан. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулиар иргэдийн мэдээлэл хайх, олж авах эрхийг баталгаажуулж, мэдээллийг ямар зорилгоор авах гэж байгааг лавлахыг хориглож, ил тод байх мэдээллээ гаргаж өгөхөөс цааргалсан албан хаагчийг ажлаас халах хүртэл хариуцлага тооцохоор заасан билээ. Гэтэл тус хууль хэрэгжиж эхлээд даруй 6 жил өнгөрч байхад төрийн албан хаагчид мониторинг хийх гэж байгаа төрийн бус байгууллагад хууль бус шаардлага, шалгуур тавьж мэдээлэл өгөхөөс цааргалж байсан нь төрийн үйл ажиллагаа ил тод байх талаар төрийн

албан хаагчдын хандлагад дорвитой өөрчлөлт гараагүй болохыг илтгэн харуулж байна. Шинээр томилогдсон албан хаагчид хуулиа сайн мэдэхгүй, хуучин албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах эсэхдээ итгэлгүй байгаа нь мониторингийн явцад ажиглагдсан. Энэ мэтээр хуучин, шинэ төрийн албан хаагчдын хандлага шинэ хуулийн орчинд ажиллахаар бэлтгэгдээгүй байгаа нь захиргааны шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд ноцтой саад тээг учруулахаар байна.

Мониторинг эхэлсэн эхний хоёр сарын хугацаанд мэдээлэл олж авахад төрийн бус байгууллагуудад нилээд хүндрэл учирч байсан бол дунд хугацаанаас эхлээд хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох тал дээр ахиц дэвшил гарч эхэлсэн. Мониторинг хийж буй төрийн бус байгууллагууд өөрсдийн санаачлагаар Захиргааны ерөнхий хуулийн талаар сургалт, мэдээлэл, хэлэлцүүлгийг төрийн албан хаагчид, иргэдийн дунд хийсэн бөгөөд 10 аймаг, 3 дүүрэгт хамгийн багадаа 376 төрийн албан хаагчид, 200 гаруй иргэд, иргэний нийгмийн байгууллага үүнд хамрагджээ. Үүний зэрэгцээ мониторинг хийж байгаа төрийн бус байгууллагын зөвлөмж, саналыг үндэслэн нийслэл, Өмнөговь аймаг, Хан-Уул дүүргийн Засаг дарга нар Захиргааны ерөнхий хуулийн



Булган сумын багийн хэсгийн ахлагч нарт мониторингийн үр дүнгийн тухай болон ЗЕХуулийн хэрэгжилтэд "Иргэдийн оролцоо" сэдвээр ярилцлага зохион байгуулав.

хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр захирамж баталсныг онцлон дурьдах нь зүйтэй.

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн дүнгээс харахад төрийн албан хаагчдын Захиргааны ерөнхий хуулийн талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Мониторинг хийсэн нийслэл, 16 аймаг, 16 сум, 8 дүүргийн мэдээллээс дүгнэхэд захиргааны байгууллага захиргааны акт гаргах явцдаа нөхцөл байдлыг хангалтгүй судлах, сонсох ажиллагаа хийхгүй байх, эсхүл өөр зорилгоор хийгдсэн хэлэлцүүлгийн үр дүнг сонсох ажиллагаа хийсэн мэтээр тайлагнах, захиргааны акт тус бүрт хувийн хэрэг, дагалдах хуудсыг хөтлөхгүй байгаа нь ажиглагдлаа. Хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр зарим

аймаг, орон нутаг санаачлага гаргаж байгааг дурьдвал, Өмнөговь аймгийн Засаг дарга захиргааны актын дагалдах хуудасны загварыг баталж, мөрдүүлсэн бол Төв аймаг дагалдах хуудас, хувийн хэргийн нэгдсэн загвар гаргахаар ажиллажээ. Бусад аймаг, дүүргийн тухайд дээрээс нэгдсэн загвар ирвэл мөрдөнө гэсэн байдлаар асуудалд хайнга хандаж байна.

Мониторингоос харахад захиргааны хэм хэмжээний актыг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, бүртгүүлэлгүй дагаж мөрдүүлэх зөрчил нийтлэг байна. Үүний зэрэгцээ хянуулахаар хүргүүлдэг ч ХЗДХЯ-аас бүрдэл дутуу, холбогдох хуульд нийцүүлэх, эсхүл хүчингүй болгох тухай дүгнэлт хүлээн авсны дараа холбогдох арга хэмжээ

авахын оронд шууд дагаж мөрдүүлээд явдаг нийтлэг зөрчил байна. Үүний зэрэгцээ захиргааны хэм хэмжээний актыг захиргааны актаасаа ялгаж танихгүй байх асуудал тулгамдаж байна. Нөгөө талаас Захиргааны ерөнхий хуулийн үр шимийг шууд хүртэх учиртай иргэд, хуулийн этгээд энэ хуулийн талаар сайн ойлголт мэдээлэлгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа юм. Тиймээс цаашид Захиргааны ерөнхий хуулийн сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, төрөл бүрийн гарын авлага, материалыг боловсруулж, түгээх, энэ үйл явцад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглах, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд тулгарч байгаа асуудлаар нэгдсэн удирдамж, заавар баталж захиргааны байгууллагад хүргэх, төрийн

албан хаагчдыг чадавхжуулах, захиргааны хэм хэмжээний актын хяналт шалгалтыг улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар явуулах, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн санг шинэчлэх шаардлагатай. Мөн түүнчлэн сонсох ажиллагааг хэрхэн зохион байгуулах, нөлөөллийн шинжилгээг хэрхэн хийх, хувийн хэрэг, дагалдах хуудасны загвар ямар байх, хэрхэн хөтлөх талаар нарийвчилсан удирдамж, заавар гаргах хэрэгцээ шаардлага байна.

Мониторингд хамрагдсан ТББ-ууд хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс мониторинг хийсэн нь хуулийг хэрэгжүүлэхэд тодорхой түлхэц өгсөн болохыг онцлон тэмдэглэсэн билээ.

ТӨРИЙН АЛБАНЫ БИЕ ДААСАН БАЙДАЛ БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад ННФ-ын зүгээс анхаарч ирсэн нэг чухал асуудал нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үйл явц юм.

2016 онд ННФ-аас дээрх хуулийн хэрэгжилтийг үнэлэх зорилгын хүрээнд төрийн албанд томилогдохоор завдаж буй этгээдээс хувийн ашиг сонирхлын урьдчилсан

мэдүүлэг (ХАСУМ) авах, тэдгээрийг хянах, хяналтын үр дүнд үндэслэн арга хэмжээ авах байдалд мониторинг хийхэд нь Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ТББ-д дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Монгол Улсын төрийн албанд нийт 186458 хүн ажиллаж байгаагаас 21 хувь нь буюу 39583 төрийн албан хаагч хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах ёстой ба тэдний 7515 буюу 18 орчим хувь нь улс төрийн албан тушаалтан байдаг аж. Мониторингийн тайлангаас үзэхэд 2016 онд Авлигатай тэмцэх газар (АТГ) нийт 11840 ХАСУМ хүлээн авч хянасан нь өмнөх оны 7893 ХАСУМ-тай харьцуулахад 66 хувиар өссөн дүнтэй байна. Зөвхөн 2016 оны байдлаар ХАСУМ-ийг хянуулахаар АТГ-г ирүүлсэн шалтгаан, нөхцөлийг авч үзвэл шинээр томилогдож байгаа 1895, албан тушаалын ангилал зэрэглэл дэвшсэн 4050, буурсан 103, шилжин томилогдсон 3758, эрхлэх асуудлын чиг үүрэг өөрчлөгдсөн 1134 тохиолдол байв. Эндээс харахад 2016 онд ХАСУМ шаарддаг төрийн албаны орон тооны 30 орчим хувьд нь өөрчлөлт орсон дүр зураг харагдаж байна. 2016 он сонгуулийн жил байсныг харгалзан үзвэл дээрх тоо нь сонгуулийн үр дүнгээр өөрчлөгдөх боломжтой улс төрийн албан тушаалтнуудын тооноос даруй 2 дахин илүү

байгаа нь анхаарал татаж байна. 2008 онд Төрийн албаны тухай хуульд туссан өөрчлөлтөөр төрийн албыг улс төрөөс хараат бус болгохыг зорьсон ч бодит байдалд төрийн алба улс төрөөс хараат байдалтай хэвээр байгааг дээрх тоо харуулж байна.

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгтэй холбоотой хуулийн хэрэгжилтийн явцад гардаг түгээмэл зөрчлүүд нь ХАСУМ гаргуулж, холбогдох байгууллагаар хянуулахгүйгээр нийтийн албан тушаалтныг томилох, худал мэдүүлэх, бүрэн гүйцэд мэдүүлэхгүй байх, нэр дэвшигчийн хамаарал бүхий этгээд нь өөрийнх нь эрхлэх асуудлын хүрээнд шууд хамааралтай ажил үйлчилгээ эрхлэх зэрэг зөрчлүүд байдаг байна.

Хэдийгээр Авлигатай тэмцэх газар ХАСУМ-ыг хянаж үзээд тухайн этгээдийг нийтийн албанд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх, хэрэгжүүлэх албан үүрэг нь тухайн этгээдийн хувийн ашиг сонирхолтой харшлах эсэх талаар дүгнэлт гаргах боловч албан тушаалтныг томилох эсэх шийдвэрт шууд оролцох эрхгүй. Өөрөөр хэлбэл, томилох байгууллага, албан тушаалтан нь Авлигатай тэмцэх газрыг зөвхөн “сонсох” чиг үүрэгтэй байна. Хуулийн энэхүү хийдлээс үүдэн сонирхлын зөрчилтэй этгээд төрийн

албанд томилогдож байгааг мөн тайланд дурджээ. Тухайлбал, 2016 хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ АТГ-аар хянуулаагүй төрийн албанд томилогдсон тохиолдол 118 байсан аж.

Цаашид сонирхлын зөрчлийг зохицуулж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад ННФ анхаарал хандуулан ажиллах болно.

Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь

ННФ 2014 оноос эхлэн Нээлттэй Нийгэм Сангуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр иргэдэд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ баталгаажуулахад нь туслах төслийг Монгол Улсад хэрэгжүүлж ирлээ. Төсөл нь Дэлхийн нөөцийн хүрээлэн олон улсын байгууллагын арга зүйн дэмжлэгтэйгээр иргэд амьдарч буй нутаг орныхоо байгаль орчны байдал, усны нөөц, бохирдлын хүчин зүйлс зэрэг мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх зорилготой.

Иргэдэд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ баталгаажуулахад нь туслах төслийн эхний шат 2015 оны 6 дугаар сар хүртэл үргэлжлэн усны талаарх мэдээллийн ил тод байдал, хүртээмжийн судалгааг хийх, иргэдийн оролцооны загвар

төсөл хэрэгжүүлэх, байгаль орчны мэдээллийг нийтэд ил болгох загвар стандарт боловсруулах зэрэг чиглэлд Хүний эрх, хөгжил төв, Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн, Ил тод байдал сан, Байгаль орчин, эрүүл мэнд төв зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан юм.


Уг төслийн хоёр дахь шатны ажил 2015 оны 10 дугаар сараас эхлэн 2017 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд үргэлжилж байгаа бөгөөд Байгаль орчин, эрүүл мэнд төв, Ил тод байдал сан, Хөвсгөл Далайн Эзэд хөдөлгөөн зэрэг иргэний нийгмийн байгууллагуудад тэтгэлэг олгон хамтран ажиллаж байна. Төслийг байгаль орчны бохирдол, доройтолд өртсөн нийслэлийн Хан-Уул дүүргийн 12, 13, 14-р хороо болон Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлж байгаа юм. Эдгээр байгууллагын үйл ажиллагааны үр дүнд иргэд өөрсдийн аж төрж буй хороо, багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхай болон бусад үйлдвэрлэл, тэдний амьдарч буй орчинд үзүүлж байгаа нөлөөллийн талаар мэдээлэл олж авах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсооход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах дадал чадварт суралцан эрх ашгийнхаа төлөө хамтран тэмцэж байна.

Байгаль орчин, эрүүл мэнд төв

Төслийн эхний шатанд хүндрэлтэй байсан асуудлын нэг нь иргэд амьдарч буй орчныхоо бохирдлын талаар тодорхой мэдээлэл авахыг хүсдэг боловч тэр мэдээлэл байхгүй байх явдал юм. Иймд иргэдийн амьдрах орчны бохирдлын байдлыг нарийвчлан судлах, мэдээллийг ил тод байлгах зайлшгүй шаардлагатайг тодорхойлсон бөгөөд нотолгоонд суурилсан нөлөөллийн ажиллагаа явуулах, иргэд байгаль орчны мэдээлэл авах эрхийг баталгаажуулах үүднээс дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүнд:

- Олон улсын хэмжээнд нэг мөр болон хэрэгжиж буй “Усны засаглал”-ын ойлголт, зарчмын талаар холбогдох талуудтай хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах, сонин, сэтгүүлд нийтлэл хэвлүүлэх, ярилцлага өгөх зэрэг нөлөөллийн ажлууд хийгдлээ. Монгол Улсад байгаль орчны талаар шийдвэр гаргах үйл явцад эдгээр зарчмыг нэвтрүүлснээр иргэдийн мэдээлэл авах эрх, шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо гэх зэрэг засаглалын элементүүд баталгаажих юм.
- Аж ахуйн нэгж, байгууллага, суурьшлын бүсээс гарч буй бохирдлын байдалд

АГААРЫН БОХИРДЛЫН ХЯНАЛТЫН ЖИШЭЭ: УТААНЫ БОХИРДЛЫН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ КОД



тухайн орчинд оршин суугчид өөрсдөө хяналт тавьж, амьдрах орчиндоо хариуцлагатай хандан цэвэр таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Чех, Энэтхэг, Индонез, Оросын Холбооны улсуудын туршлага дээр үндэслэн “Орчны бохирдолтын байдалд өнгөт кодоор хяналт хийх аргачлал”-ын төсөл боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт албан ёсоор танилцууллаа.

Ил тод байдал сан

Монгол Улсын иргэд оршин суугаа нутаг орныхоо байгаль орчны мэдээллийг энгийн

ойлгомжтой хэлбэрээр олж авахад нь туслахад чиглэсэн аргачлал бүхий мэдээллийн ил тод байдлын загварыг бий болгож нэвтрүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн 12, 13, 14-р хороо, Төв аймгийн Заамар сумын жишээн дээр орон зайн зураглалын шинэлэг аргыг ашиглан туршилтын мэдээлэл боловсрууллаа.

Сонгон авсан орон нутгийн иргэдийн хувьд амьдрах орчин, эрх ашгаа хамгаалах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах үйл явцад оролцоход нь туслах, тэдний хамгийн чухал, илүү тодорхой мэдэхийг хүссэн байгаль орчны 5 төрлийн мэдээллийн загварыг тэргүүн ээлжид багцлан загварчилж гаргалаа. Үүнд:

- Газрын мэдээлэл:** Газрын нэгдмэл сангийн ангилал, бүсүүд, газар эзэмшил, ашиглалтын бүртгэлийн мэдээлэл, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт;
- Ус, гол, рашааны мэдээлэл:** Булаг, гол мөрөн, нуур тойром, газрын доорх усны орд, рашаан, ус хангамжийн эх үүсвэр, тэдгээрийн хамгаалалт, ариун цэврийн бүс, уст цэг, ус ашиглах зөвшөөрөл, ус хаях, зайлуулах цэг ба усны барилга байгууламж;
- Тусгай хэрэгцээний газар нутгийн мэдээлэл:** Тусгай хэрэгцээний газар нутаг, тэдгээрийн ангилал тус бүрээр, түүний дотор тусгай хамгаалалттай газар нутаг,

ангилал тус бүрээр, энэ газар нутаг дахь газар ашиглалт;

4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээлэл: Тухайн орон нутаг дахь аж ахуй, бизнесийн үйл ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнүүд;

5. Уул уурхайн үйл ажиллагааны мэдээлэл: Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл, түүнийг олгох үйл явц, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт, нөхөн сэргээлт зэрэг хамаарна.

Эдгээр мэдээллийг нэгдсэн мэдээллийн сангаас болон орон нутгийн эрх бүхий байгууллагаас цуглуулж, үнэн зөв байдлыг газар дээр нь очиж шалгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлээд байна. Түүнчлэн төслийн талаарх нэгдсэн мэдээллийг сонирхсон иргэдэд хүргэх www.baigaliorchin.mn цахим хуудас болон нийгмийн сүлжээг хариуцан ажиллаж байна.

Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн

Иргэдийг чадавхжуулж, усны талаар шийдвэр гаргах үйл явцад оролцуулахад шаардлагатай албан ёсны

механизмыг бий болгох зорилгоор хэд хэдэн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна. Ингэхдээ Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны болон Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн иргэдийг нэгтгэн зохион байгуулалтад оруулж, Шинэ суурьшил- эрүүл аюулгүй орчин, Мөнх ногоон хас, Тоонот Монгол төрийн бус байгууллагуудыг нэгтгэн чадавхжуулж байна. Түүнчлэн, Байгаль орчны сэтгүүлчдийн сүлжээ ТББ үүсгэн байгуулагдаж түүнтэй хамтран ажилласнаар эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ эвсэл хэлбэрээр байнга, тууштай шаардаж эхэллээ. Эдгээр төрийн бус байгууллага нь бие даан ажлаа удирдах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах чадвар дадал эзэмшиж, төсөл боловсруулж, мониторинг хийх ур чадварт суралцаж, түүний үр дүнд үндэслэн бодлого боловсруулах төр, засгийн үйл ажиллагаанд үр ашигтай нөлөөлөх чадавхтай болж байгаа нь төслийн нэг томоохон үр дүн юм.

Орон нутгийн иргэдийн төлөөллөөс бүрдсэн дээрх төрийн бус байгууллагууд нь өөрсдийн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компани ус ашиглалтын гэрээг холбогдох төрийн байгууллагатай байгуулсан эсэх, түүний

УСНЫ ЗАСАГЛАЛЫН ЗАРЧИМ

Усны ашиглалт, менежментэд хамаарах улс төр, нийгэм, эдийн засаг, төрийн захиргааны тогтолцоог Усны засаглал гэж ойлгоно. Товчилбол хэн, хэзээ, хэрхэн ямар ус хэрэглэхийг шийдвэрлэх үйл явц юм.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 2015 оны Сайд нарын нэгдсэн хуралдаанаас тодорхойлсон Усны засаглалын зарчмуудыг доорх диаграммаар харуулав.

Эдгээр зарчим нь хүний эрх, хуульт ёсыг дээдэлсэн, бүх нийтийг хамруулсан, хууль ёсны, ил тод, хариуцлагатай байх зэрэг сайн засаглалын ерөнхий зарчмуудад суурилсан болно.



Төрийн ил тод, хариуцлагатай байдал

дагуу ус ашиглалтын төлбөрийг зохих ёсоор төлж буй зэрэг асуудлаар усны мониторинг хийсэн бөгөөд ус ашиглалтын гэрээний хугацаа сунгагдаагүй, ашиглалтын төлбөр төлөгдөөгүй, гэрээнд заасан хэмжээнээс хэд дахин их ус хэрэглэж байгааг тогтоогоод байна.

Хан Уул дүүргийн 13-р хорооны Туул тосгоны иргэдийн үүсгэн байгуулсан “Шинэ суурьшил- эрүүл аюулгүй орчин” ТББ тосгоны иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангуулах зорилгоор хорооны удирдлага, уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн дунд гурвалсан хэлэлцээр хийсэн, УИХ-ын өргөдлийн байнгын хороонд хандан хууль бус уурхайн үйл ажиллагааг таслан зогсоох чиглэлд нөлөөлөл явуулсан, Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын Хан-Уул дүүргийн дэд зөвлөлд иргэдийн төлөөлөл болж сонгогдсон түүхийг дараагийн хуудаснаас харна уу (Цэцгээгийн түүх-2).

Төслийн хүрээнд зохион байгуулсан “Хатан Туулыг хамгаалах арга зам” илтгэлийн уралдаан, “Хатан Туул хатаж ширгэх учиргүй” сэтгүүл зүйн шилдэг бүтээлийн уралдаан нь Туул голын бохирдлын асуудлыг төр, засаг болон олон нийтийн анхаарлын төвд оруулж,



түүнийг хамгаалах хөдөлгөөнийг өрнүүлж, нийгмийн давалгаа болгов.

Эдгээр нөлөөллийн ажлын үр дүнд Туул голын усны нөөцийн хомсдол, бохирдлын асуудалд УИХ-ын гишүүдийн

Алт угаах зориулалт бүхий хөдөлгөөнт төхөөрөмж Туул голын эрэг дээр бий болгосон хиймэл нууранд үйл ажиллагаа явуулж байгаа байдал - Төв аймгийн Заамар сумын Хайлааст баг



Алтны уурхай Туул голоос хиймэл нуур үүсгэх зорилгоор ус татаж буй байдал

Гэрэл зургийг Мөнх ногоон хас ТББ-аас ирүүлэв.

Вашингтон хотноо усны засаглалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж буй Индонези, Монголын иргэний нийгмийн байгууллагын түншүүддээ ур чадвар олгох сургалт семинар зохион байгууллаа. Энэхүү сургалт семинарын явцад төслийн хүрээнд цуглуулсан мэдээллийг үр нөлөөтэйгээр олон нийт, бодлого боловсруулагчдад хүргэх дэвшилтэд аргуудаас танилцуулав. Мөн байгаль орчны чиглэлээр ажилладаг Америкийн Нэгдсэн Улсын төрийн болон төрийн бус байгууллагуудаас туршлага судлан, орчны бохирдлын эрх зүйн зохицуулалт, шийдвэр гаргах явцад олон нийтийн оролцоог хэрхэн хангадаг талаар суралцлаа.

анхаарлыг хандуулж чадлаа. Ингэснээр Өргөдлийн байнгын хороо тусгайлан ажлын хэсэг байгуулан ажиллаж, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулан Засгийн газрын авах арга хэмжээний тухай тодорхой чиглэл бүхий тогтоол батлав. Түүнчлэн Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу авах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дуустал болон Туул голыг хамгаалах тухай хууль батлагдах хүртэл УИХ-ын ажлын хэсгийг ажиллуулахаар шийдвэрлэсэн юм.


Төслийн хугацаанд Дэлхийн Нөөцийн хүрээлэнгээс Америкийн Нэгдсэн Улсын

Төслийн хамтрагч байгууллагын төлөөлөгч нар Дэлхийн Нөөцийн Хүрээлэнгээс зохион байгуулсан сургалт семинарт оролцов. Зураг дээр Монголын болон Индонезийн иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид сургалтын үеэр



ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХЭЭ ХАЙСАН НЬ - II

(Цэцгээгийн түүх)



© Нээлттэй Нийгэм Форум, 2016



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР



Олборлох салбарын засаглал

Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын хүрээнд олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын “ашиг хүртэгч эзэд”-ийг ил тод болгох үүрэг хүлээлээ.



ОУИТБС-ын тайлангаар 1.39 их наяд төгрөгийн орлогыг ил тод болгосон нь олборлох салбараас Засгийн газрын хүлээн авсан нийт орлогын 97,9 хувийг хамарчээ. Тайлангаар илэрсэн шийдвэрлэгдээгүй зөрүү нь 112 сая төгрөг болж өмнөх оныхоос 469 сая төгрөгөөр багассан.”

Олборлох салбарын засаглалд ил тод, хариуцлагатай байдлыг төлөвшүүлэх стратегийн зорилтынхоо хүрээнд ННФ нь 2016 онд ОУИТБС-ын шинэ стандартыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, гэрээний ил тод байдлыг хангах, иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулахаар ажиллаж буй. Энэ хүрээнд бодлогын судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан эрдэс баялгийн салбарын засаглалд шинэ тутам орж ирж байгаа ойлголтуудыг талуудад танилцуулан яриа хэлэлцүүлэг өрнүүлж, байр суурийг нь нэгтгэх замаар төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх гүүр болж ажиллаж ирлээ. Түүнчлэн тус салбарт тулгамдаж буй асуудлаар иргэний нийгмийн байгууллагуудын санал шүүмжийг нэгтгэн төрийн бодлого шийдвэрт тусгуулах чиглэл барьж ажиллалаа.


2016 онд эрдэс баялгийн салбарын бодлого, эрх зүйн орчинд нэлээдгүй өөрчлөлт гарав. Ялангуяа шийдвэр гаргах үйл явцад томоохон өөрчлөлт авчрах хууль тогтоомжууд шинээр батлагдаж гарсны дотор Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээр тусгай

зөвшөөрөл олгох, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ батлах, газар, ус ашиглах зөвшөөрөл олгох, хамтын ажиллагааны гэрээ байгуулах зэрэг салбарын хэмжээнд гардаг гол гол шийдвэрт олон нийтийн оролцоог хангах шинэ журам үйлчилж эхэллээ. Мөн нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах хамтын ажиллагааны гэрээний загвар батлагдсанаар гэрээнд иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчин сайжирлаа. Ирээдүйн өв сангийн тухай хууль батлагдсан нь байгалийн нөхөн сэргээгдэхгүй баялгаас орсон орлогыг урт хугацааны хуримтлал үүсгэн хойч үедээ өвлүүлэн үлдээх эрх зүйн үндсийг тавилаа.

Ийнхүү нэг талаар, салбарын засаглалд нааштай өөрчлөлт авчрах эрх зүйн орчин бүрдэж байгаа ч сүүлийн жилүүдэд бий болсон эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан уул уурхайн үйлдвэрлэлийг тэлэх бодлого эрчимжиж, засаглалд тавих шаардлага сулрах эрсдэл бий болов. Тухайлбал, “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, “Алт-2” хөтөлбөрийн хүрээнд алт олборлолтыг нэмэгдүүлж, ой, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд уул уурхайн ажиллагаа явуулахыг



ОУИТБС-ын нэгдсэн тайлангаар үлдсэн шийдэгдээгүй зөрүү (2006-2015 оны тайлан)



ОУИТБС-ын 10 дугаар тайлангаар Засгийн газрын 2015 онд олборлох салбараас хүлээн авсан 1.39 их наяд төгрөгийн орлогод тулган баталгаажуулалт хийж 112 сая төгрөгийн зөрүүг илрүүллээ.

Ил тод байдлын тайлан гаргасан компанийн тоо 2012-2015 онд



Ил тод байдлын тайлан гаргасан компаниудын тоо 2015 онд өмнөх оноос 38.6 хувиар буурсан байна.

зөвшөөрсөн нь тусгай зөвшөөрлийн тоог үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг ихэсгэх эрсдэл дагуулж байна.

2006 оноос хэрэгжиж эхэлсэн Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангах санаачилгын стандарт 2016 онд шинэчлэн батлагдлаа. “Тайлагналтаас өөрчлөлт рүү” шинэ уриан дор хэрэгжиж эхэлсэн энэхүү үйл явц нь цар хүрээгээ тэлж, компаниудын жинхэнэ эздийг ил тод болгохыг шаардах болов. ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч улсууд 2020 он гэхэд эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бүх компаниудынхаа “ашиг хүртэгч эзэд”-ийн мэдээллийг олон нийтэд ил тод болгох үүргийг хүлээгээд байна.

Мөн Монгол Улс 2016 онд ОУИТБС-ын шинэ стандартын дагуу баталгаажуулалтад

хамрагдаж “мэдэгдэхүйц ахиц дэвшил” гаргасан орон болж ил тод байдлын стандартыг хэрхэн хэрэгжүүлж байгаагаа олон улсад үнэлүүллээ. Хэдийгээр баталгаажуулалтыг амжилттай давсан ч оролцогч талуудын хамтын ажиллагааг улам сайжруулах, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой зөрчлийн мэдээллийг ил тод болгох, төрийн өмчит компаниудын тайлан мэдээг сайжруулах зэрэг асуудлаар сануулга авлаа.

Өнгөрсөн онд гарсан Монгол Улсын ОУИТБС-ын 10 дугаар тайлан буюу 2015 оны тайлан нь анх удаа шинэ стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд 2015 онд хийгдсэн Туршилтын баталгаажуулалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд олон шинэ мэдээллийг багтааснаараа онцлогтой байв. Тусгай зөвшөөрөл олгоход гарсан

зөрчлүүд, олборлох салбараас орж буй орлогын хуваарилалт, түүнийг тайлагнахад учирч буй бэрхшээл, Засгийн газраас төрийн өмчит компаниудад олгосон зээл, түүний баталгаа зэрэг мэдээлэл уг тайланд анх удаа тусав. Энэ удаагийн тайлангаар нийт 1.39 их наяд төгрөгийн орлогыг ил тод болгосон нь олборлох салбараас Засгийн газрын хүлээн авсан нийт орлогын 97,9 хувийг хамарчээ. Тайлангаар илэрсэн шийдвэрлэгдээгүй зөрүү нь 112 сая төгрөг болж өмнөх оныхоос 469 сая төгрөгөөр багассан ч компаниудын тайлан гаргах идэвх санаачилга буурчээ. Нийт 3329 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дөнгөж 23,4 хувь буюу 782 нь 2015 онд ил тод байдлын тайлан гаргажээ. Энэ нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлага байгааг илтгэж байна.

Олборлох салбарын засаглалын хөтөлбөрийн гол үйл ажиллагаа нь 2016 онд эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн нөлөөллийн ажлууд хийх, энэ салбарт хийгдэж байгаа томоохон гэрээнүүдийг ил тод болгоход техникийн туслалцаа үзүүлэх, мөн салбарын асуудлаар ажиллах иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэлээ.

Эрх зүйн орчныг сайжруулах

Бид 2016 онд ОУИТБС-ын стандартад шинээр тусгагдсан “ашиг хүртэгч эзэд”-ийн ил тод байдлын шаардлагыг хангахад төвлөрч ажиллалаа. Энэ хүрээнд аж ахуйн нэгж, өмч хөрөнгийн бүртгэл мэдээллийн тогтолцоо, эрх зүйн орчныг үнэлэх бодлогын судалгаа хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хууль эрх зүйн орчинд оруулах өөрчлөлтүүдийг тодорхойллоо. Уг судалгааны дүгнэлт, зөвлөмжид тулгуурлан ОУИТБС-д оролцогч талуудын дунд яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, хууль эрх зүйн нөлөөллийн ажил үргэлжилж байна (Судалгааг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас үзнэ үү).

Ийнхүү ил тод байдлын шаардлага дахь шинэ тутам ойлголтыг холбогдох талуудад танилцуулснаар Нээлттэй засаглалын түншлэлийн 2015-2018 оны Үндэсний төлөвлөгөө,

“Эрдэс баялгийн салбарт Ашиг хүртэгч эздийн ил тод байдлыг хангах нь” хэлэлцүүлгийн явц



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг төрийн үйл ажиллагааны бодлогод “ашиг хүртэгч эзэд”-ийн ил тод байдлыг хангах асуудал тусгалаа олов.

Гэрээний ил тод байдлыг хангах

Эрдэс баялгийн салбарт төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагаас иргэд, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг нийтэд ил тод болгох мэдээллийн цахим санг 2016 онд шинээр хийлээ. Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд (www.iltodgerее.mn; www.resourcecontracts.mn) уул уурхай, газрын тосны салбарын Хөрөнгө оруулалтын, Бүтээгдэхүүн хуваах, Орд ашиглах, төрийн өмчийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх болон орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнүүдийг холбогдох

тайлбарын хамт оруулав. Мөн гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн тайлан мэдээ, тусгай зөвшөөрөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, менежментийн төлөвлөгөө зэрэг холбогдох баримт бичгүүдийг байршуулснаар хэрэглэгчид тухайн төсөлтэй холбогдох цогц мэдээллийг нэг дороос авч, дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа хийх боломж бүрдлээ.

Түүнчлэн эрдэс баялгийн салбарын гэрээнд ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Захиргааны ерөнхий хуулийн Сонсох ажиллагааг уул уурхай, газрын тосны салбарын гэрээнд хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг хөндсөн анализ бэлтгэн холбогдох талуудад хүргэв Ийнхүү шинэ тутам бий болсон иргэдийн оролцооны журмыг эрдэс баялгийн салбарт хэрэгжүүлэх нь уг салбар дахь орлогын урсгалыг хянах,



нийгмийн шударга ёсыг хангах, хүний эрх, хүрээлэн буй орчны зөрчлөөс сэргийлэх, эцсийн дүндээ гэрээний чанар, үр дүнг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.


Иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх

Бид 2016 онд иргэний нийгмийн байгууллагуудыг байгалийн нөөц баялаг ашиглах гэрээнд дүн шинжилгээ хийх чадавхтай болгоход түлхүү анхаарч сургалт-хэлэлцүүлэг зохион байгуулж, гэрээний мониторингийн тэтгэлэг олгож ажиллалаа. Үүнд, татвар санхүү, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, эрх зүй, хөдөлмөр, байгаль орчин гэх мэт олон зангилаа асуудлыг хамарсан томоохон гэрээ хэлцэлд нарийвчилсан тооцоо, дүн шинжилгээ хийх, үр дүнд нь тулгуурлан нөлөөллийн ажил хийх чиглэлээр иргэний нийгэмд

дутагдаж буй чадавхыг нөхөхийг зорилоо. Одоогоор ТАН эвслийн гишүүн байгууллагууд Гацууртын ордын Хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээрийн ил тод байдалд мониторинг хийх тэтгэлэг аваад ажиллаж байна. Иргэний нийгэм, судлаач мэргэжилтнүүдийн цаашдын хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Евроазийн олборлох салбарын мэдлэгийн төвөөс зохион байгуулсан гүнзгийрүүлсэн сургалтад судлаач нарыг хамруулав. Мөн Орон нутгийн хамтын ажиллагааны

ЭРДЭС БАЯЛГИЙН ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН САН

www.iltodgeree.mn сайтаас гэрээ төдийгүй түүний хэрэгжилт, байгаль орчныг хамгаалахтай холбоотой тайлан зэрэг тухайн төсөлтэй холбоотой цогц мэдээллийг авах боломжтой. Мөн гэрээний заалтуудыг агуулга, чиглэлээр нь ангилан холбогдох тайлбар нэмсэн нь Хэрэглэгчид уншиж ойлгоход хялбар дөхөм болсон. Мөн харилцан хамаарал бүхий заалтуудыг нэг дор ялган харах, ижил төрлийн гэрээний нөхцөлүүдийг хооронд нь харьцуулан судлах боломжтой.



ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ГЭРЭЭНД СОНСОХ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Эрдэс баялгийн салбарын гэрээ нь субъектын хувьд нэг талд нь заавал төрийн захиргааны байгууллага байдаг; зохицуулах асуудлын хувьд нийтийн өмчийн баялаг болох ашигт малтмал, газрын тос хайх, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулдаг; хууль зүйн үндэслэлийн хувьд Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай, Хөрөнгө оруулалтын хуулиуд зэрэг нийтийн эрх зүйн хэм хэмжээний хүрээнд байгуулагддаг зэрэг шинжээрээ Захиргааны ерөнхий хуульд заасан “захиргааны гэрээ”-ний үндсэн шинжийг хангаж байгаа юм. Ийнхүү “захиргааны гэрээ” болохын хувьд түүнийг байгуулахад Захиргааны ерөнхий хуульд заасан “сонсох ажиллагаа” буюу олон нийтийн оролцооны журмыг заавал хэрэгжүүлэх шаардлагатай.

Бодлогын цуврал #24



гэрээнд хяналт тавих чадавхыг бэхжүүлэх үүднээс хөдөө, орон нутгийн ТББ-ууд тэтгэлэг авч орон нутгийн хөгжил, хүрээлэн буй орчин, иргэдийн нийтлэг эрх ашиг хөндөгдсөн асуудлуудаар ажиллаж байна.

Гэрээний мониторингийн багуудыг сургалтад хамруулж, орон нутгийн гэрээний ойлголт, эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийг үнэлэх арга зүй, мониторингийн удирдамжийг танилцуулав. Мониторингийн дүнд гэрээний мэдээлэл, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хянах үйл явц иргэдэд нээлттэй бус, гэрээнд хэрэгжилтийг нь хэмжих эсхүл анхнаасаа хэрэгжих огт боломжгүй заалт тусгах явдал түгээмэл байгааг олж тогтоов. Тэрчлэн хуулийн заалтыг хуулж бичих, эсхүл бүр хууль зөрчсөн заалтуудыг их тусгаж байгаа нь гэрээний ач холбогдлыг бууруулахын хамт уг гэрээний хүчин төгөлдөр байдалд ч эргэлзэхэд хүргэж байгаа юм.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар төрийн бус байгууллагуудад шинээр олгогдсон нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрхийг хэрэгжүүлэх, шүүхийн тогтолцоог ашиглан хариуцлагыг бодит хэрэг болгоход ТББ-уудын үйл ажиллагааг мөн дэмжиж ажиллав. Гэвч өмгөөллийн үйл явцаас харахад хууль бус шийдвэр гаргасан, эсхүл хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй төрийн албан тушаалтанд хариуцлага тооцуулах нэхэмжлэлүүдийн дийлэнх нь

шүүхийн шатанд гацаж, үр дүн нь удааширч байна. Энэ нь нэг талаар нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах талаарх шүүхийн ойлголт, хандлага нөгөө талаар төрийн бус байгууллагуудын хуулийн мэдлэг чадавх нимгэн, хуульч мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа сул байгааг илтгэж байна. Иймд цаашдаа дээрх чиглэлээр шүүх, төрийн бус байгууллага, олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, хуульчдын идэвх санаачилга, хамтын ажиллагааг өрнүүлэхэд анхаарч ажиллах болно.

ННФ иргэний нийгмийн сүлжээг бэхжүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлж ТАН эвслийн зохицуулагчийн хувьд эвслийн өдөр тутмын болон сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг гардан хэрэгжүүлж байна. ОУИТБС-ын баталгаажуулалтын үеэр эвслийн гишүүдийг зохион байгуулж, эрдэс баялгийн салбарын засаглал, Санаачилгын хэрэгжилтэд тулгарч байгаа асуудлуудын талаар санал шүүмж бэлтгэн ОУИТБС-ын олон улсын нарийн бичгийн дарга нарын газар болон Удирдах хороонд хүргүүлснээр дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн тодорхой зөвлөмжүүдийг Баталгаажуулалтын тайланд тусгуулж чадлаа. Мөн “Төлсөнөө нийтэл” олон улсын сүлжээний 2020 хүртэлх Стратегийн баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх Бизнес төлөвлөгөөнд санал шүүмж өглөө. ТАН эвсэл нь 2016 оноос “Төлсөнөө нийтэл” олон улсын сүлжээний Зөвлөх хороонд Евроазийн бүсийн төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна.

Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо

Төсвийн ил тод байдлыг зохицуулж буй холбогдох хууль, тогтоомжуудын хэрэгжилтийг улс, орон нутгийн хэмжээнд бүхэлд нь иж бүрэн судалгаа хийлээ. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хэрхэн хангаж байгаад иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс мониторинг хийхээс гадна хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулсан нь үр дүнгээ өгөв.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд орон нутгийн 30 гаруй төрийн бус байгууллага 2016 оны эхний хагас жилд мониторинг хийж, нөлөөллийн үйл ажил явуулсан нь эерэг нөлөөлөл үзүүлэв.”

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын төсвийн зарлага эрс нэмэгдсээр байна. Тухайлбал, 2000 онд нэгдсэн төсвийн нийт зарлага 366 тэрбум төгрөг байсан бол 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9.5 их наяд төгрөг болж даруй 26 дахин өсжээ. 2016 оны байдлаар төсвийн нийт орлогын 80 орчим хувийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс төлж буй татвар бүрдүүлж байна. Түүнчлэн төсвийн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн төсвийн эрх мэдэл, зарцуулах хөрөнгийн хэмжээ нэмэгдлээ. Үүний сацуу улсын төсвийн удирдлага, өрийн асуудал хурцаар тавигдах болсон зэргээс үүдэн төсвийн ил тод, хариуцлагатай байдал, удирдлагыг сайжруулах нь нэн чухал байна.

Монгол Улсын төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад ННФ стратегийнхаа хүрээнд тогтмол анхаарч судалгаа шинжилгээ, уулзалт хэлэлцүүлэг, хяналт мониторинг хийж ирлээ. Өнөөгийн байдлаар манай

улсад төсвийн мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн хууль эрх зүйн орчин харьцангуй сайжраад байгаа боловч энэ нь эргэлт буцалтгүй үйл явц болж чадаагүй байна. Шилэн дансны тухай хууль 2014 онд батлагдан төсвийн бүх байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газрууд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, орлого, зарлагын гүйлгээ тус бүрээ шийдвэрийн хамт ил тод мэдээлэх шаардлагатай болсон нь иргэд, иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-уудын зүгээс төсвийн зарцуулалтыг нарийвчлан хянах боломжийг нээв. Уг хууль батлагдсанаас хойш өөрчлөлт ороогүй боловч түүнийг хэрэгжүүлэх журамд ухралт гараад байна. Тухайлбал, 2016 онд шинэчлэгдсэн “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д ихэнх мэдээллийг PDF форматаар нийтэлж байхаар заасан нь өмнөх журамд тавигдаж байсан Excel, XML форматаар нийтлэх шаардлагаас ухарсан алхам юм.

Цаашилбал, төрийн өмчийн компаниудын төсвийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Учир нь уг хуулиар төрийн өмчийн үйлдвэрийн газрууд таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээг ил болгохоор заасан боловч хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа тохиолдолд компани энэхүү гүйлгээний мэдээллийг нийтлэхгүй байхаар заажээ. Гэтэл төрийн өмчит ихэнх компани хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулагддаг ба тэдгээрээс нэлээд нь алдагдалтай ажиллан, төсвийн татаас авсан хэвээр байна. Иймд эдгээр компанийн гүйлгээний мэдээллийг ил болгох нь төсвийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

ННФ төсвийн ил тод байдлын чиглэлээр олсон амжилтыг бататгаж, цаашид төсвийн хөрөнгийн удирдлага, хариуцлагыг дээшлүүлэх үйл явцыг дэмжин ахиц гаргахад нь хувь нэмэр оруулах зорилгоор төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн мониторингийн төслүүдийг ИНБ-уудтай хамтран хэрэгжүүлж, судлаачидтай хамтран холбогдох судалгаа, үнэлгээ хийж байна. Тухайлбал, бид улсын болон орон

нутгийн төсвийн ил тод байдалд үнэлгээ хийснээс гадна Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад нөлөөллийн үйл ажиллагааг дэмжиж ирлээ. Түүнчлэн, төсвийн ил тод байдлын чиглэлээрх олон улсын уулзалт, хэлэлцүүлэгт оролцон санал бодлоо солилцов. Цаашилбал, төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах чиглэлээр ажилладаг ТББ-уудын сүлжээг хамруулан орон нутгийн төсвийн ил тод байдлын мэдээлэл цуглуулах арга зүйн сургалт, семинар хийж, судалгааны мэдээлэл цуглуулах ажилд оролцуулснаас гадна Шилэн дансны мониторинг хийсэн ТББ-уудад туршлагаа солилцох боломж олгох уулзалт зохион байгуулав. Бид төсвийн болон мэдээллийн ил тод байдлын холбогдох хууль эрх зүйн баримт бичигт үндэслэн өмнөх онд боловсруулсан улс, орон нутгийн төсвийн үйл явцын цахим цаглабарыг үргэлжлүүлэн ажиллуулаа. Швейцарын Хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Хотын засаглал төслийн хүрээнд нийслэлийн зарим дүүрэгтэй хамтран Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-ийн төлөвлөлтийн үйл явцад тулгарч буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох чиглэлээр ажиллаж уг сангаас санхүүжүүлэх төсөлд иргэдээс санал авах хуудсыг шинэчлэн гурван дүүрэгт турших ажлыг

ШИЛЭН ДАНСНЫ МОНИТОРИНГ ХИЙЖ БУЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД

- ЛЭОС - ийн Архангай аймгийн салбар зөвлөл
- Баян-Өлгий аймгийн урианхай, тува, дөрвөд иргэдийн нийгмийн хөгжлийг дэмжих холбоо
- Амар тайван итгэл ТББ
- Булганы мэдээ сонин
- Говь-Алтай аймаг дахь НДЭХ салбар
- Хөгжлийн Түншлэл ТББ
- Дархан-Уул аймгийн худалдаа аж үйлдвэрийн танхим
- Дорноговь аймаг дахь залуучуудын салбар байгууллага
- УТБА –ийн Дорнод салбар
- БОНӨБ-эрдэнэ холбоо
- Өрнөх Хөгжил ТББ
- Эрдэнэт хүмүүний эв нэгдэл ТББ
- ЛЭОС - ийн Өвөрхангай аймгийн салбар зөвлөл
- Өмнөговь аймаг дахь НДЭХ салбар
- Сэтгэшгүй Оюундалай НҮТББ
- Төв аймаг дахь Ажил олгогч эздийн бизнес холбоо
- Увс аймгийн Баруун Бүс Нутгийн Хөгжлийг Дэмжих Сайнтус төв ТББ
- Ховд аймгийн НДЭХ салбар
- Хөвсгөлийн Хөгжил дэвшилд ТББ

ШИЛЭН ДАНСНЫ МОНИТОРИНГ ХИЙЖ БУЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД

/Үргэлжлэл/

- Сэлэнгэ аймгийн АОЭ-ийн холбоо
- Хэнтий аймгийн АОЭ-ийн холбоо
- Төсвийн удирдлагын хүрээлэн
- Хууль бидний амьдралд ТББ
- Урагш дэвших холбоо ТББ
- Хэрэглэгч сан ТББ
- Үнэн Хатамж ТББ
- Захиргааны шинэ санаачилга ТББ
- Онол Арга ТББ
- Хүншихүйн зам ТББ
- Налайхын амьдрал сонин
- Залуус манлайлал ТББ



Шилэн дансны мониторинг хийсэн ТББ-уудын туршлага солилцох уулзалтад оролцогчид (Улаанбаатар хот, 2016 он)

зохион байгуулж, холбогдох зөвлөмж боловсруулав.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн мониторинг

Төсвийн ил тод байдлыг хангахад нэн чухал ач холбогдолтой Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ННФ 2015 онд ИНБ-уудтай хамтран улсын хэмжээнд хяналт, мониторинг хийсэн нь хуулийн хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлэв. 2016 оны эхний хагас жилд уг хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс орон нутагт мониторинг, нөлөөллийн үйл ажиллагаа хийсэн 30 гаруй ТББ-ын үйл ажиллагааг бид үргэлжлүүлэн дэмжиж ажиллаж байна.

Эдгээр ТББ аймаг, сумын ЗДТГ, ИТХ болон эмнэлэг, сургууль зэрэг төсвийн байгууллагуудаас гадна зарим төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар зэрэг байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавив. Тэд мониторингийнхоо дүнд үндэслэн зохих зөвлөмж гарган ажиглалтад хамрагдсан байгууллагуудад хүргэв. Үүнээс гадна хуулийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, хэрэгжилтийг хянахад иргэдийн оролцоог хангах чиглэлээр ажиллалаа. Энэ хүрээнд уулзалт, сургалт хийснээс гадна хуулийн талаар нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевизээр цацав. Зарим төрийн бус байгууллага тухайн орон нутагтаа иргэний хяналтын баг байгуулж хуулийн хэрэгжилтэд хяналт



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 21 аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд хэрхэн хангаж байгаад ИНБ-уудын хийсэн мониторингийн дүн (аймаг, нийслэлээр)

Цуврал инфографик болон мониторингоор цуглуулсан тоон мэдээллийг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас үзнэ үү.

тавилаа. Мөн зарим нь Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран орон нутагтаа төсвийн мэдээллийн ил тод байдлыг хэрхэн хангаж байгаа талаар үзүүлэх сургуулилт зохион байгуулж төрийн байгууллагуудыг хамруулан, санхүүгийн ил тод байдлын талаар хэлэлцүүлэг өрнүүлжээ. Энэ үеэр төрийн байгууллага санхүүгийн тайлан мэдээлэл, бичиг баримтаа дэлгэн үзүүлж, хуулийг сайн хэрэгжүүлж байгаа байгууллагууд туршлагаа солилцсон нь үр дүнтэй арга хэмжээ болжээ.

Мониторингоор орон нутгийн төсөв, түүний захирагчийн шилэн дансны мэдээллийг цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулах тухай хуулийн заалт бүрэн хэрэгжихгүй байгаа нь харагдав. Мөн зарим төрийн

байгууллага мэдээллийг хуульд заасан хугацаанд нь бүрэн нийтлэхгүй, харин сар бүрийн сүүлийн долоо хоногт нийтэд ил болгож байв. Зарим байгууллага мэдээллийн самбар байхгүй, самбартай ч мэдээлэл нийтлэхгүй байна. Нийтэлсэн мэдээллийн зарим нь харагдахгүй ор нэр төдий, бүдэг, жижиг, огноо нь тодорхойгүй зэрэг шаардлага хангахгүй байх тохиолдол ч цөөнгүй ажиглагдав. Түүнчлэн гүйлгээнд холбогдох шийдвэрийг хавсаргахыг холбогдох журмаар зохицуулсан боловч хэрэгжихгүй байх зэрэг дутагдал доголдол цөөнгүй харагдлаа.

Шилэн дансны мониторинг хийсэн ТББ-уудын туршлага солилцох уулзалтыг ННФ-аас зохион байгууллаа.

ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖӨӨС

- Хуулийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх механизмыг тодорхой болгох.
- Төрийн байгууллагуудын удирдах ажилтнуудын үр дүнгийн гэрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгай заалт оруулан дүгнэж байх.
- Иргэдийн мэдлэг, хяналтыг дээшлүүлэх.

Мониторингийн үр дүнд иргэдийн идэвх тодорхой түвшинд дээшилж сонирхсон байгууллагынхаа санхүүгийн мэдээллийг авах хандлага нэмэгдэн төрийн байгууллагын ажилтнууд хуулийн хэрэгжилтэд онцгой анхаарах болсон нь ажиглагдсан байна. Цаашид төсвийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх үүднээс хуулийн дагуу 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ, худалдан авалтын мэдээллийг нийтлэх босгыг 1 сая төгрөг болгон бууруулах саналыг ТББ-уудын зүгээс гаргав.

Шилэн дансны мэдээлэл нийтлэх явц 2015 оны сүүлийн хагас жил болон 2016 оны эхний хагас жилд харьцангуй хэвшиж байсан боловч 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш хуулийн хэрэгжилт харьцангуй сулраад байна. Иймд сонгуулиас хойш томилогдсон улс, орон нутгийн төр засгийн байгууллагуудын удирдлага, ажилтнууд хуулийн хэрэгжилтийг хангахад нөлөөлөх чиглэлээр иргэний нийгмийн зүгээс үргэлжлүүлэн ажиллах шаардлагатай хэмээн бид үзэж, шилэн дансны мэдээлэлд мониторинг хийж, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах ТББ-уудыг 2016 оны сүүлээс дэмжин үргэлжлүүлэн ажиллаж байна. Энэ удаагийн мониторингийг 2016 оны 12 дугаар сараас 2017 оны эхний хагас жил дуустал нийт 6 сарын хугацаанд хийж байгаа

Зурагт “Нээлттэй засаглалын түншлэлийн Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр дэх Төсвийн ил тод байдлын чиглэлээр өгсөн амлалтууд” сэдэвт уулзалтын явцыг харуулав. Зүүн гар талд: ННФ-ын Хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам (АНУ, Вашингтон хот. 2016 оны 6 сард)



ба мониторингоор аймаг, нийслэлийн Засаг дарга, ЗДТГ-ууд болон зарим төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийг хамруулж, дүнг нийтэд хүргэхээр ажиллаж байна.

Төв засгийн газрын төсвийн ил тод байдлын судалгаа

Улсын төсвийн ил тод байдлыг сайжруулахад нөлөөлөх зорилгоор Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас (www.internationalbudget.org) дэлхийн 100 гаруй орны төсвийн ил тод байдлын үнэлгээг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хоёр жил тутамд гүйцэтгэдэг юм. Уг судалгаанд Монгол Улс 2006 оноос хамрагдсан бөгөөд энэхүү судалгаа нь манай улсын Засгийн газрын төсвийн нээлттэй байдлын түвшинг тодорхойлж, бусад улс орнуудтай харьцуулах

боломжийг олгодгоороо ач холбогдолтой юм. 2015 оны судалгаагаар Засгийн газрын төсвийн ил тод байдал хангалтгүй хэвээр байгаа нь харагдав. Бид 2016 онд ээлжит судалгааг эхлүүлээд байгаа ба төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалт зэрэг үе шатуудыг хамарсан 8 гол баримт бичгийн нээлттэй байдлаас гадна төсвийн үйл явцад иргэдийн оролцоог хэрхэн хангаж байгааг үнэлж байна. Судалгааны дүнг 2017 онд нийтэд танилцуулахаар ажиллаж байна.

Төсвийн ил тод байдлын талаарх олон улсын уулзалт, хэлэлцүүлэг

Нээлттэй Нийгэм Форумын судлаачид төсвийн ил тод байдлын чиглэлээр олон улсын хэмжээнд зохион байгуулагддаг



уулзалт, хэлэлцүүлгүүдэд оролцож ирлээ. Мэдээллийн ил тод байдлын олон улсын санаачилга болох Нээлттэй засаглалын түншлэлийн Төсвийн ил тод байдлын ажлын хэсгээс 2016 оны 6 дугаар сард АНУ-д зохион байгуулсан “Нээлттэй засаглалын түншлэлийн Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр дэх Төсвийн ил тод байдлын чиглэлээр өгсөн амлалтууд” сэдэвт уулзалтад бид оролцов. Уулзалтын үеэр 10 гаруй орны сангийн яам болон иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл тухайн улсын Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр дэх Төсвийн ил тод байдлын чиглэлээр өгсөн амлалтуудын талаар хэлэлцэв. Энэ үеэр Монгол Улсын төсвийн ил тод байдлын чиглэлээр нэн тэргүүнд хийх шаардлагатай байгаа ажлуудын талаар Нээлттэй Нийгэм Форумас мэдээлэл хийв.

Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээ

Орон нутгийн төсвийн зарлага 2013 онд 1.8 орчим их наяд төгрөг байсан бол 2016 онд 2.2 их наяд төгрөг буюу нэгдсэн төсвийн нийт зарлагын 27 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 8 хувьд хүржээ. Өсөн нэмэгдэж буй төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөв захиран зарцуулагчдын хариуцлагыг дээшлүүлэхэд орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах нь нэн чухал үүрэгтэй юм.

ННФ-ын 2011 оноос эхлэн хоёр жил тутамд хийж буй орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгааны дүн төсвийн ил тод байдал хангалтгүй байгааг харуулж ирлээ. 2013 онд хийгдсэн хоёр дахь удаагийн судалгаанаас хойш Шилэн дансны тухай хууль батлагдаж төсвийг ил

ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР НЭН ТЭРГҮҮНД ХИЙХ ШААРДЛАГАТАЙ АЖЛУУД

- Нэгдсэн төсвийн санал, жилийн явцын болон эцсийн тайлангуудад төсвийн зарлагыг чиг үүргийн ангилал (хөтөлбөр, салбараар)-аар бэлтгэсэн мэдээллийг нэмж оруулах.
- Төсвийн хагас жилийн тоймыг нийтэд мэдээлэх
- Цахим хэлбэрээр нийтэлж буй төсвийн үндсэн баримт бичгүүд дэх тоон мэдээллийг компьютерээр боловсруулалт хийх боломжтой формат (xls)-аар нийтлэх

ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН ТУЛД:

- Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу жил бүр төсвийн хяналтын сонгол зохион байгуулах, холбогдох журам батлах, түүнийг иргэдэд сурталчлах.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн санхүүжилтийг бууруулахгүйгээр иргэд төсвийн үйл явцад шууд оролцох боломжийг хадгалах.

МОНИТОРИНГИЙН ДҮН

- Засаг даргаас ИТХ-д өргөн барьсан төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, газар зохион байгуулалт, концесс, хувьчлалын баримт бичгийн төслүүд хаалттай байгаа учраас иргэд саналаа хэлэх боломж бүрдэхгүй байна.
- ИТХ-ын хуралдааны товыг нийтэд хугацаа тулган зарлаж байгаа нь иргэд шууд болон сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан саналаа илэрхийлэх боломжийг хязгаарлаж байна.
- Дүүргүүдийн ИТХ-ын хуралдааны тэмдэглэл болон батлагдсан төсвийн ил тод байдал хангалтгүй байна.
- Төсвийн баримт бичгүүдийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Цахим хуудасны загвар, дизайн өөрчлөгдөхөд, эсвэл улс төрийн сонгуулиар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, албан тушаалтнууд солигдсоны дараа шинээр цахим хуудас хийгдэж өмнөх төсөв, санхүүгийн мэдээлэл алга болж байна.

Төсвийн ил тод байдлын мониторингийн дүнгээс

тод болгох, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй төрийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох хууль эрх зүйн орчин бүрдсэн билээ. Иймд орон нутагт уг хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж, төсвийн ил тод байдалд бодит өөрчлөлт гарч буй эсэхийг тодорхойлох зорилгоор орон нутгийн төсвийн ил тод байдлын ээлжит үнэлгээг 2016 онд гурав дахь удаагаа хийж байна. Энэ удаагийн судалгаанд 21 аймаг, нийслэлээс гадна нийслэлийн 9 дүүргийг хамруулж байна. Үнэлгээг орон нутгийн төсвийн ил тод байдалд тавигдах шаардлагыг тодорхойлж буй Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан журмуудын дагуу ил тод болговол зохих төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгүүдийг 2015 оны 6 дугаар сарын 1-нээс 2016 оны 6 дугаар сарын 1 хүртэлх нэг жилийн хугацаанд хэрхэн ил тод болгосон байдалд үндэслэн хийж байна. Судалгааны тайланг ирэх онд нийтэд танилцуулах юм.

Зурагт: “2016 оны Нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдаан ба баримт бичгийн ил тод, нээлттэй байдал” мониторингийн дүнг танилцуулах уулзалтад оролцогчид (Улаанбаатар хот. 2016 оны 4 дүгээр сар)



Төсвийн ил тод байдал ба хариуцлагын механизмын хэрэгжилтийг хянах иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэх

Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад түүнийг шаардах эрэлт чухал юм. Энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор ННФ-аас сургалт, семинар зохион байгуулах, мониторингийн төслүүдэд хамруулах зэрэг ажлуудыг хийж ирлээ. Төрийн бус байгууллагуудын ажилтнуудын төсвийн хууль эрх зүйн талаарх мэдлэгийг дээшлүүлэх үүднээс 2016

МОНИТОРИНГИЙН ДҮН

“Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээнээс нийслэл, түүний 9 дүүргийн 2016 оны төсвийн төслийг хэлэлцэж баталсан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны явцыг ажиглаж, уг хурлаар баталсан баримт бичгүүдийн нээлттэй байдал, иргэдийн оролцоог хэрхэн хангаж байгаад мониторинг хийв. Үр дүнг нийслэл, дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөллийг оролцуулан 2016 онд танилцуулж Мониторингийн тайланг forum.mn болон tusuv.mn цахим хуудсанд нийтэллээ.



онд 30 гаруй байгууллагын ажилтнуудыг орон нутгийн төсвийн ил тод байдлын эрх зүй, судалгааны мэдээлэл цуглуулах арга зүйн сургалтад хамруулж, судалгааны мэдээлэл цуглуулахад оролцуулав. Үр дүнд нь тэд төсвийн мэдээлэл цуглуулах, мониторинг хийх чадвар эзэмшин, тодорхой төслүүд дээр бидэнтэй хамтран ажиллаж байна.

“Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний үйл ажиллагаа

Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад нөлөөлөх чиглэлээр ажилладаг “Иргэд төсвөө хянана” иргэний

нийгмийн сүлжээний үйл ажиллагааг бэхжүүлэхэд ННФ байнгын дэмжлэг үзүүлж ирлээ. Тус сүлжээ төсвийн мэдээллийн www.tusuv.mn цахим хуудас ажиллуулж, сүлжээний гишүүн байгууллагуудын ажиглалт, мониторингийн явцад олж авсан төсвийн холбогдолтой мэдээллийг байршуулж олон нийтэд тогтмол хүргэж байна. Уг сүлжээнээс Нийслэл ба түүний 9 дүүргийн 2016 оны төсвийн төслийг хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны үйл явц болон түүгээр баталсан баримт бичгүүдийн нээлттэй байдал, иргэдийн оролцоог хэрхэн хангаж байгаад хийсэн мониторингийн дүнг нийслэл, дүүргүүдийн ИТХ-ын төлөөллийг оролцуулан 2016 онд танилцууллаа.



Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ ба бизнесийн орчин

Монгол Улсын 2017 оны төсөвт тойм дүгнэлт хийж, анхаарах асуудлуудыг хөндөн, бодлого боловсруулагчид болон иргэний нийгмийн төлөөллийн дунд цуврал хэлэлцүүлэг өрнүүлэв.

“**2017 оны төсвийн төлөвлөлтөд орлогыг зарлагад нийцүүлэх, төсвийн тэнцлийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэх гэсэн оролдлого давтагдав. Төсвийн хүндрэлээс гарахад гол нь төлөвлөлт, хариуцлагатай байдлаа сайжруулах шаардлагатай байгааг төр засаг анхаарах хэрэгтэй байна.**”

Сүүлийн арав гаруй жилийн туршид ННФ бусад байгууллага, судлаачидтай хамтран Монгол Улсын төр засгийн санхүү, төсвийн болон бизнесийн орчны талаарх бодлого, төлөвлөлтөд бие даасан, хөндлөнгийн судалгаа хийж дүнг нь бодлого боловсруулагчид, олон нийтэд хүргэж ирлээ. Үүний дотор цаг үеийн асуудлаар судалгаа хийхээс гадна улсын төсвийн төлөвлөлт, өрсөлдөх чадвар, бизнесийн орчныг тодорхойлох судалгааг жил бүр хийж байна.

Улсын төсвийн судалгаа, шинжилгээ

Манай улсад төсвийн сахилга бат, хариуцлага хангалтгүй байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд төсвийн алдагдал эрс нэмэгдэж улмаар Засгийн газраас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хязгаарыг тодорхой хугацаанд өсгөлөө. Төсвийн алдагдлаа нөхөх зорилгоор Засгийн газар дотоод болон гадаад бондыг жил дараалан гаргах болсноор хуримтлагдсан

алдагдлын хэмжээ нэмэгдэж түүнийг цаашид санхүүжүүлэх эх үүсвэр улам бүр өндөр зардалтай болсоор байна. Иймд иргэний нийгмийн зүгээс төсвийн талаар мэдээлэлтэй байж, төр засгаас төсвийн хариуцлагаа дээшлүүлэхийг шаардах нь нэн чухал байна.

Төсвийн зарцуулалтын хариуцлагатай байдал, төлөвлөлтийг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор ННФ жил бүр ирэх оны улсын төсвийн төсөлд тойм дүгнэлт хийн анхаарах асуудлуудыг хөндөн дүгнэлт, санал зөвлөмж гаргаж бодлого боловсруулагчид болон иргэний нийгэмд танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлж ирлээ. Бидний хэрэгжүүлж буй энэхүү тогтмол үйл ажиллагаа нь иргэний нийгэм, ялангуяа хэвлэл мэдээллийнхний дунд хүлээлт үүсгэсэн арга хэмжээ болоод байна. Төсвийн төлөвлөлтөд хийсэн хараат бус судалгааны дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өргөнөөр ашиглан нийтэд мэдээлэл хүргэж байна. Энэ нь татвар төлөгчдөөс хуримтлуулах орлогыг оновчтой зарцуулах болон төсвийн төлөвлөлтийг

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОН БАТЛАГДСАН ТӨСӨВТ ХИЙСЭН ТОЙМ ДҮГНЭЛТИЙН ТАЙЛАНГУУД



- Орлогын төлөвлөлт
- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт
- Зарлагын удирдлага
- Өрийн удирдлага

Судалгааны тайлангуудыг forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

ТОЙМ СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ГАРГАСАН ЗӨВЛӨМЖӨӨС

- Төсвийн орлого бүрдүүлэлтийг сайжруулах, зардлыг хэмнэх, өрийн дарамт болон төсвийн алдагдлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх;
- Төсвийн хүндрэлээс гарахын тулд гадаад тусламжид найдахаас илүүтэйгээр төсвийн сахилга батыг сайжруулах;
- Төсвийн орлогыг төсвийн зарлагад нийцүүлэх замаар төсвийн тэнцлийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэн төлөвлөдөг буруу жишгийг халах эрх зүйн тогтолцоо бүрдүүлэх.

сайжруулах талаар бодлого боловсруулагчдад иргэний нийгэм дуу хоолойгоо хүргэх ач холбогдолтой юм.


2016 онд Монгол Улсын 2017 оны Нэгдсэн төсвийн төсөл ба батлагдсан төсөвт орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, өрийн удирдлага болон эрүүл мэнд, боловсролын салбарын зарлагын төлөвлөлтийн чиглэлээр тойм судалгаа хийгдэв. Судалгаагаар төсвийн орлогыг төлөвлөхөд ашигласан суурь зарчмууд болох зарим салбаруудад аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бууруулах, татвар хураамжийн хувь хэмжээг нэмэхгүй, шинээр бий болгохгүй байх, томоохон төслүүдийг эрчимжүүлж бүтээн

байгуулалтыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийн ихэнх нь эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй өнөө үед хэрэгжих боломж бага байгаа тул төсвийн орлого тасалдах эрсдэл өндөр байгаа нь ажиглагдав. Мөн УИХ-аас нэгдсэн төсвийн урсгал зардлын хэмжээг өсгөж, харин хөрөнгийн зардлыг бууруулж баталснаас гадна төсвийн тэнцлийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэх зорилгоор төсвийн орлого болон нэрлэсэн ДНБ-ий хэмжээг өргөн барьсан төслөөс өсгөв. Төсвийн өнөөгийн нөхцөл байдалд гадаадын зээл, тусламж авах нь эдийн засгийн хүндрэлээс гарах, валютын ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах боломжит нэг хувилбар мөн

боловч төсвийн сахилга бат хангалтгүй, алдагдал ихтэй одоогийн бодлогыг үргэлжлүүлбэл цоорхой саванд ус хадгалахтай адил талаар судалгаанд хөндөгдөв.

Засгийн газраас сүүлийн жилүүдэд төсвийн алдагдлаа нөхөх, хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор дотоод, гадаадын ихээхэн хэмжээний бонд гаргаж Хөгжлийн банкны гадаад зээлд баталгаа гаргалаа. Эдгээр бондын эргэн төлөх хугацаа тулж татвар төлөгчдийн хөрөнгийг ашиглах нөхцөл байдалд хүрээд байна. Иймд Засгийн газар дамжуулан зээлдүүлэх, зээлийн баталгаа гаргах, түүний эргэн төлөлтөд хяналт тавих тогтолцоог

Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ ба бизнесийн эрчин



Монгол Улсын 2017 оны төсвийн төлөвлөлтийн асуудлаарх цуврал хэлэлцүүлгийн үеэр. Улаанбаатар хот, 2016 оны 10-11 дүгээр сар

МОНГОЛ УЛСЫН ӨРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2017 оны байдлаар Засгийн газрын нийт өрийн үлдэгдэл 24,8 их наяд төгрөг болж ДНБ-ий 84.8 хувьд хүрэхээр байна. Үүний 54 хувийг гадаад өр, 30.6 хувийг дотоод өр эзэлнэ.

Монгол Улсын Засгийн газрын өр, төлбөрийн талаарх инфографикийг forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

зохицуулж буй Өрийн удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна. Мөн бид Монгол Улсын өр, төлбөрийн өнөөгийн байдлыг судалж, энэ талаарх мэдээллийг олон нийтэд хүргэлээ.


удирдлага”, “Монгол Улсын эрүүл мэнд, боловсролын салбарын 2017 оны зарлагын төлөвлөлт” сэдэвт цуврал хэлэлцүүлэг зохион байгуулагдав. Үүнд:

- Сангийн яамнаас нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, өрийн удирдлагын талаар;
- Сангийн яам болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас эрүүл мэнд, боловсролын салбарын зарлагын төлөвлөлтийн талаар;
- ННФ-ын санаачилгаар судлаачид төсвийн төлөвлөлтөд хөндлөнгийн, хараат бус тойм дүгнэлт хийснээ тус тус танилцууллаа.

Төсвийн асуудлаарх уулзалт, хэлэлцүүлэг

ННФ судлаачидтай хамтран Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд тойм судалгаа хийж, төсвийн төлөвлөлтөд анхаарах асуудлуудыг хөндсөнөөс гадна Сангийн яам болон бусад төр засгийн байгууллага, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан жил бүр цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж ирлээ. Тухайлбал, 2017 оны нэгдсэн төсвийн төлөвлөлтийн асуудлаар 2016 оны 10 дугаар сард “Монгол Улсын 2017 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт”, 11 дүгээр сард “Монгол Улсын 2017 оны төсвийн тэнцэл, өрийн

2017 оны төсвийн төсөлд хийсэн тойм дүгнэлт, илтгэлүүд, хэлэлцүүлгүүдийн тэмдэглэл зэргийг forum.mn цахим хуудсанд нийтэлж, олон нийтэд хүргэлээ.



Бизнесийн орчин

Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн дүнг бид олон нийтэд өргөн хүрээнд танилцуулснаар энэхүү судалгааны дүн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийн биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн тоонд багтаад байна

Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ) жил бүр эрхлэн гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийнхаа дүнг 9 дүгээр сард дэлхий даяар танилцуулав. Өрсөлдөх чадварын индекс нь тухайн улсын хүрч чадах хөгжлийн түвшинг тодорхойлдог эдийн засгийн бүтээмжид нөлөөлөгч хүчин зүйлүүдийн үнэлгээнд үндэслэдэг юм.

Монгол Улс 2005 оноос энэхүү тайланд нэгдсэн ба энэ хугацаанд ННФ нь ДЭЗФ-ын түншээр ажиллалаа. Бид уг тайлан дахь Монгол Улсын дүнг олон нийтэд өргөн хүрээнд танилцуулснаар манай улсын төр засгийн зүгээс өрсөлдөх чадварын судалгааны дүнд анхаарал хандуулж, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийн биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн тоонд энэхүү судалгааны дүн багтаад байна.

Судалгаанд хамрагдаж эхэлснээс хойших хугацаанд манай улс 3.2-3.9 оноо авсан нь өрсөлдөх чадварын хувьд дорвитой өөрчлөлт гарахгүй байгааг харуулж байна.


Монгол Улс өрсөлдөх чадварын хувьд авбал зохих онооноос дөнгөж талаас илүү хувийг авч байгаа нь энэ талаар дорвитой ахиц гаргах шаардлагатай байгааг харуулж байна. Ялангуяа институциудын чанар, дэд бүтэц болон санхүүгийн зах зээлийн хөгжил гэсэн үзүүлэлтүүдийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Өрсөлдөх чадварыг тодорхойлогч 12 тулгуур үзүүлэлтээс Монгол Улс 4 үзүүлэлтээр бага зэрэг ахиц гаргажээ.

Өрсөлдөх чадварын индексийн 12 тулгуур үзүүлэлтийг бүрдүүлдэг 115 дэд үзүүлэлтээс манай улс 140-өөд орноос 10 гаруй үзүүлэлтээр эхний 50 байрт багтсан нь тэмдэглүүштэй юм.

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ОНОО, ЗЭРЭГЛЭЛ, 2005-2016 ОН

Өрсөлдөх чадварын 2016-2017 оны тайлангаар Монгол Улс 3.8 оноо авснаар судалгаанд хамрагдсан 138 орноос 102 дугаарт эрэмбэлэгдэв.

Эх сурвалж: ДЭЗФ-ын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангууд



МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТ



Өмнөх онтой харьцуулахад макро эдийн засгийн орчны үзүүлэлт 0,4; санхүүгийн зах зээлийн хөгжил, технологийн бэлэн байдал, дээд боловсрол ба мэргэжлийн сургалт гэсэн үзүүлэлтүүд тус бүр 0,1 оноогоор өсөв.

Цалин хөлс тогтоох уян хатан байдал, хөрөнгө оруулагчийн хамгаалалт, интернэтийн хурд, ажлаас халахад гарах зардал, татварын нийт хувь хэмжээ, үүрэн холбооны интернэт хэрэглэгчдийн тоо, их дээд сургуульд хамрагдалт, математик, шинжлэх ухааны боловсролын чанар, бизнес эхлэн эрхлэхэд шаардагдах журмын тоо, эрдэмтэд, инженерүүдийн хүрэлцээ зэрэг үзүүлэлтээрээ Монгол Улс эхний 50 байрт багтав.

“Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2016-2017” дахь Монгол Улсын зэрэглэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон инфографикийг fogum.mn хуудаснаас үзнэ үү.



БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР

Тэгш хамруулах боловсрол

Тэгш хамруулах боловсролын хөтөлбөр нь боловсролын салбар дахь иргэний нийгмийн оролцоо, үр нөлөөг бэхжүүлэх урт хугацааны зорилгынхоо хүрээнд бодлогын үйл явцад идэвхтэй оролцож буй байгууллагуудын цаашдын институцийн хөгжлийг дэмжихийн зэрэгцээ боловсролын асуудлаар ажиллаж эхэлж буй төрийн бус байгууллагуудын чадавхыг хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын асуудлыг шат шатандаа хяналт тавих үүрэгтэй хорооны Засаг дарга, сургуулийн захирал, дүүрэг, нийслэлийн Засаг дарга, ИТХ, салбарын яам болон мэргэжлийн хяналтын алба зэрэг засаг захиргааны болон салбарын олон албан тушаалтан оролцож, хуулиар оноосон үүргийнхээ дагуу идэвх санаачилгатай ажиллаж байж боловсролын хүртээмж, чанар сайжрах юм.”

Манай хөтөлбөр 2016 онд хот, хөдөөгийн иргэний нийгмийн байгууллагуудын нотолгоонд суурилсан бодлогын нөлөөллийн чадавхыг бэхжүүлж, орон нутагтаа бодлогын яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд нь туслахын зэрэгцээ үйл ажиллагаа нь тогтворжсон хоёр байгууллагын засаглал, стратегийн болон хөтөлбөрийн төлөвлөлтийг бэхжүүлэхэд дэмжиж ажиллав. Үүний зэрэгцээ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих шинэ тогтолцоог бий болгох зорилгоор Хүн ам, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам (хуучин нэрээр)-ны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын Комисст техник арга зүйн дэмжлэг үзүүлж байна.

ННФ-ын дэмжлэгтэй байгуулагдсан Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ 2016 онд хөгжлийн бэрхшээлтэй

Баруун гар талд: Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээний сургалт, хэлэлцүүлгийн явц

Доорх зурагт: ННФ-ын Боловсрол, Нийгмийн бодлогын асуудал хариуцсан менежер А. Гэрэлмаа хэлэлцүүлгийн үеэр



хүүхдийн боловсролын үйлчилгээнд гарсан амжилт, тулгамдаад байгаа асуудлуудыг баримтжуулах зорилгоор мониторингийн 5 төсөл хэрэгжүүлэв. Сүлжээний гишүүн 5 төрийн бус байгууллага хамтран төсөл боловсруулах аргазүйн зөвлөмж гарган хот, хөдөөгийн иргэний нийгмийн байгууллагуудад хүргэсэн ба 2016 оны 3 дугаар сард 20 гаруй төслөөс таван төслийг шалгаруулав. Шалгарсан төслийн багуудад баримт нотолгоо цуглуулж, бодлогын нөлөөлөл хийхтэй холбоотой 3



МОНИТОРИНГИЙН ДҮНГЭЭС

- Сонгино Хайрхан дүүргийн хэмжээнд нийт 29 сургуулиас зөвхөн нэг сургууль л тэргэнцэртэй хүүхдэд зориулж бүх хичээлийг нь нэгдүгээр давхрын ангиудад оруулахаар зохицуулж, өөр нэг сургуулийн багш өөрийн санаачилгаар хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийн яриа, харилцааны ур чадварыг тоглоомын аргаар сайжруулсан туршлага дээрээ үндэслэн арга зүйн гарын авлага боловсруулж гаргажээ.
- Завхан аймагт сүм, хийдэд шавилан сууж байгаа сургуулийн насны 100 гаруй хүүхэд ерөнхий боловсрол эзэмшихгүй байгаа бөгөөд гадаад, дотоодод шашны боловсрол эзэмшихээр бэлтгэгдэж байгаа эдгээр хүүхдийн суурь боловсролын асуудлаар сүм, хийдийн удирдлага, сумын засаг захиргаа хэрхэн хамтран ажиллаж болох тухай яриа эхлүүлээд байна.

удаагийн сургалт хийхдээ ННФ нь Сүлжээний 4 байгууллагын 6 хүнийг мониторингийн сургагчаар давхар бэлдэж, сургалтуудаа хамтран хэрэгжүүллээ. Төсөл хэрэгжүүлэх явцад Түгээмэл хөгжил төв, “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл, Боловсролын тэгш байдал ТББ-ыг мониторингийн зөвлөхөөр ажиллуулсан нь шинэ болон туршлагатай ТББ-ууд туршлагаа хуваалцах, харилцан хариуцлага хүлээж хамтран ажиллах өгөөжтэй бөгөөд үр дүнтэй ажил боллоо.

Мониторингийн багууд өөр өөр аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэрт ажиглалт хийн мэдээлэл цуглуулсан ч баримт нотолгоо, хөндөж гаргасан асуудал, дэвшүүлсэн бодлогын саналууд нь манай орны хувьд нийтлэг бөгөөд

боловсролын салбарыг бүхэлд нь хамарсан агуулгатай байгаа нь ажиглагдлаа (Мониторингийн төслүүдийн тоймыг харна уу.). Мониторингийн үр дүнд Архангай, Өмнөговь аймгийн засаг захиргааны байгууллагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаар хамтран ажиллах тодорхой саналууд гаргахын зэрэгцээ Сүлжээний байгууллагууд хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн элсэлт, анги дэвшилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын судалгаа, нөлөөллийн ажил хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Боловсролын асуудлаар ажиллаж байгаа, ажиллах сонирхолтой төрийн бус байгууллага, их дээд сургууль, судалгааны институтийн судлаачдыг уулзуулах, хамтран ажиллахад сэдэлжүүлэх зорилгоор нэг сарын

МОНИТОРИНГИЙН ДҮНГЭЭС

- Архангай аймагт сургуульд элсэн орсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ихэнх нь дунд ангид элсэхгүй завсардаж байгаагийн шалтгааныг судлахад анги дэвших шалгалтад ордоггүй, улмаар ангийн журнал дээр нэр нь бичигддэггүй болох нь илэрчээ. Энэ нь нэг талаас сургууль, багшийн ажлыг сурагчдын шалгалтын амжилтаар хэмждэг, нөгөө талаас шалгалтын явцад хүүхдэд ямар нэг дэмжлэг үзүүлэх боломжгүй хатуу зохицуулалттай холбоотой ажээ. Харин одоогоор сургуулийн захирлуудын Үр дүнгийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн анги дэвшилтийн үзүүлэлтийг нэмж тусгах тухай шийдвэр гараад байна.

Мониторингийн багууд Нөлөөллийн стратеги боловсруулах сургалтын үеэр



мэдээллийн аян зохион байгуулав. Нэг сарын хугацаанд долоо хоног бүр 3 цагийн семинар, түүнийг дагалдсан бие даасан жижиг судалгаа гэсэн бүтэцтэй модуль сургалт хэрэгжүүлж, 50 гаруй хүнд сурч боловсрох эрх, тэгш хамруулах боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, тохирох хэрэглэгдэхүүний жишээ, хувилбарт үнэлгээ зэрэг асуудлаар мэдээлэл сонсож, бие дааж судалснаа гэрийн

даалгавар хэлбэрээр ирүүлж санал солилцох боломж олгов. Сургалтыг Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, ННФ, “Бүх нийт боловсролын төлөө” эвсэл, Түгээмэл хөгжил төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт зэрэг байгууллагын судлаачид багаар төлөвлөн, хэрэгжүүлсэн нь хамтын ажиллагааны бас нэг арга хэмжээ болж чадав.

ННФ нь боловсролын



салбарт үр нөлөөтэй ажиллаж байгаа иргэний нийгмийн байгууллагуудын хөгжлийг дэмжих тэтгэлгээ 2016 онд үргэлжлүүлэн олгов. 1,5-2 жилийн хугацаатай, төрийн бус байгууллагын засаглал, стратегийн төлөвлөлтийг сайжруулах, одоо хэрэгжиж байгаа хөтөлбөрөө бэхжүүлэх, нэн шаардлагатай хөтөлбөр шинээр бий болгоход нь туслах зорилтууд агуулдаг энэхүү тэтгэлгийг 2016 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн

оролцоо, тэгш хамруулах боловсролын асуудлаар сүүлийн 10 орчим жил идэвхтэй ажиллаж байгаа хоёр төрийн бус байгууллага авлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо ТББ нь манай тэтгэлгийн дэмжлэгтэйгээр байгууллагын 4 жилийн Стратегийн төлөвлөгөөгөө салбар нэгжүүдтэйгээ хамтран боловсруулаад байгаа ба сайн дурын үндсэн дээр хэрэгжиж ирсэн Зөвлөх эцэг эхийн уулзалтыг хөтөлбөр

болгож, хөтөлбөрийн зохицуулагчийн удирдлага дор жилийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөртэй болгож тогтмолжуулаад байна. Одоо уг байгууллага нь нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар өргөдөл гомдол гаргахад нь эцэг эхчүүдэд туслах үйлчилгээ бий болгохоор ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо нь хүүхдийнхээ

МОНИТОРИНГИЙН ДҮНГЭЭС

- Өмнөговь аймагт байнгын асаргаанд байх хөгжлийн бэрхшээлтэй 30 гаруй хүүхэд сургуульд сурахгүй байгаа ба төсөл, кампанит ажлын хүрээнд цөөн хэд нь бичиг үсгийн сургалтад хамрагджээ. Эдгээр хүүхдэд боловсролын үйлчилгээ хүргэх арга эвээ олохгүй байгаа сургууль, орон нутгийн удирдлагуудад хандан сургуульд түшиглэсэн зайны сургалт, зуны сургалт зэрэг бэлэн туршлагыг авч ашиглах, мөн гэрээр сургах олон улсын туршлагыг нэвтрүүлэхийг зөвлөжээ.
- Эрдэнэтийн багийн судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд элсүүлэх, завсардуулахгүй байх асуудлыг хариуцсан албан тушаалтан, тэдний үүрэг хариуцлагын зураглалыг гаргажээ. Уг судалгаагаар “Шат шатандаа хариуцах, хяналт тавих үүрэгтэй хорооны Засаг дарга, сургуулийн захирал, дүүрэг, нийслэлийн Засаг дарга, ИТХ, салбарын яам, боловсролын мэргэжлийн хяналтын алба зэрэг салбарын болон засаг захиргааны олон албан тушаалтан оролцож, хуулиар оноосон үүргийнхээ дагуу идэвх санаачилгатай ажиллаж байж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хүртээмж сайжрах болно.” гэсэн дүгнэлт гарсан байна.

эрх ашгийг хамгаалахаар нэгдсэн эцэг эхчүүдийг төлөөлж, бодлого шийдвэр гаргагчдад тэдний дуу хоолойг хүргэхийн зэрэгцээ арвин туршлага дээрээ тулгуурлан бодлого, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг үнэтэй мэдээллээр хангаж чадах иргэний нийгмийн чухал байгууллага юм.

Энэ жил байгууллагын хөгжлийн дэмжлэгийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлж, бие даан амьдрахад нь туслах эрхэм зорилго бүхий Түгээмэл хөгжил төв авсан ба дунд хугацааны Стратеги, Удирдах Зөвлөлийн тууштай оролцоог хангасан дүрэм боловсруулж хэрэгжүүлэх, “Тэгш хамруулах боловсрол” ба “Бие даан амьдрах эрх” хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны болон хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Голдуу сайн дурын залуус, дэмжигчдийг зохион байгуулж нөлөөллийн кампанит ажил хэрэгжүүлж ирсэн туршлагатай Түгээмэл хөгжил төв нь 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг хүлээн зөвшөөрсөн заалт оруулахад гол үүргийг гүйцэтгэсэн ба одоо судалгаанд суурилан бодлогын нөлөөллийн арга хэлбэрээр ажиллах хүсэлтэй байгаа юм.

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих тогтолцоог бий болгох ажил 2013 онд Хүн

ам, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам (ХАХНХЯ)-ны харьяанд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын Комисс байгуулах тухай шийдвэр гарснаар эхэлсэн. Шинэ тогтолцоо бий болгоход мэдлэг, арга зүй дутагдахаас эхлээд хөгжлийн стратеги, хүний нөөц, удирдлагын хомсдол зэрэг олон асуудал тулгардаг. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд ХАХНХЯ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Комиссын дүрмийг боловсруулж, оновчтой харьяалал, бүтэц, орон тоог бий болгоход анхаарч ирсэн ба ННФ нь хамтран ажиллагч байгууллагын хувьд Комиссын гишүүдэд агуулга, арга зүйн дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ стратегийн төлөвлөгөөгөө боловсруулахад нь туслах гаднын зөвлөх ажиллуулав. Гэвч 2016 онд хамтын ажиллагаа саарч, ялангуяа Комиссын бүрэлдэхүүн бүрэн шинэчлэгдсэн тул өмнөх дэмжлэг төдийлөн ажил хэрэг болж биелэхгүй байгаад сэтгэл зовниж байна. 2016 онд шинээр бүрэлдсэн Комиссын хүсэлтээр 2014 онд боловсруулсан Комиссын дүрмийг шинэчлэн боловсруулахад зөвлөн ажилласан нь шинэ багтай хамтын ажиллагаа бий болгоход туслав. 2017 онд ННФ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын Комисс хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, батлуулаад байна.

Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь

Хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх нь нийгмийн эрүүл мэндийн салбарын тэргүүлэх нэг зорилт, залуучуудын хөгжлийн бодлогын зангилаа асуудал болдог байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, АНУ-ын Өвчлөлийг хянах, урьдчилан сэргийлэх байгууллага зэрэг нэр хүнд бүхий эх сурвалжууд олон жилийн баримт, нотолгоонд үндэслэн залуу хүмүүсийн дундах нас баралт, сэтгэцийн эрүүл мэндийн хямрал, зан үйлийн зөрчлийн томоохон шалтгаан болоод байгаа үе тэнгийн дарамт, дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрт хөрөнгө оруулахыг идэвхтэй уриалж байна.



Анагаахын Шинжлэх Ухааны Их Сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль өнгөрсөн жил “Залуучуудын дундах хүчирхийлэл ба урьдчилан сэргийлэлт” нэртэй 3 кредитийн хичээлийн хөтөлбөр, сурах бичиг боловсруулан бакалаврын сургалтын хөтөлбөртөө нэвтрүүлж эхлээд байна.”

Бид 2014 оноос залуу хүмүүс, ялангуяа өсвөр насны хүүхдүүдийн дундах дарамт, дээрэлхэлт, хүчирхийллийг нийгмийн бодлогын асуудал болгож тавих, урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрийн туршлага бий болгохоор ажиллаж байна. Монголд иргэний нийгмийн байгууллагууд 20 гаруй жил уйгагүй ажиллан, гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг өргөн хүрээнд таниулж чадсан нь манай ажилд чухал суурь болж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Өнгөрсөн жилүүдэд манай хөтөлбөр нийгмийн эрүүл мэнд, нийгмийн ажлын мэргэжилтнүүд, олон нийтийн анхаарлыг уг асуудалд татаж, урьдчилан сэргийлэх мэргэжил арга зүйн суурийг бий болгоод байна. Цаашид бий болгосон агуулга, арга зүйгээ хороо, дүүргийн нийгмийн ажилтнуудад хүргэж өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхийн

зэрэгцээ мөн олон нийтийг мэдээлэлжүүлэх, залуучуудын хөгжлийн бодлого, хөтөлбөрт хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилтыг оруулж ирэх чиглэлд анхааран ажиллана.

2015-2016 онд манай хөтөлбөр нийгмийн эрүүл мэнд, нийгмийн ажлын мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулийн хоёр тэнхимтэй хамран ажиллалаа. АШУИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Зан үйл судлал, нийгмийн ажлын тэнхим өнгөрсөн жил “Залуучуудын дундах хүчирхийлэл ба урьдчилан сэргийлэлт” нэртэй 3 кредитийн хичээлийн хөтөлбөр, сурах бичиг боловсруулсан ба энэ жил бакалаврын сургалтын хөтөлбөртөө нэвтрүүлэн хэрэгжүүлж эхлээд байна. 2017 оноос эхлэн тус сургуулийг төгсөн гарч байгаа шинэ мэргэжилтнүүд залуучуудын хүчирхийллийг

урьдчилан сэргийлэх асуудлаар мэргэжлийн мэдлэг, арга зүй эзэмшин төгсөх юм. Тус сургуулийн 5 оюутан энэ сэдвийн хүрээнд дипломын судалгаа хийхээр хороон дээр ажиллаж байгаа нь энэ чиглэлийн судалгааны баазыг баяжуулах юм. Багш нар нь нийгмийн ажилтан бэлтгэдэг төрийн болон хувийн их дээд сургуулиудад хөтөлбөрөө танилцуулж, тараан түгээх ажил эхлүүлэхийн зэрэгцээ олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцон шинээр бий болгож буй хөтөлбөрийн туршлагаасаа хуваалцсан байна.

2016 онд шинээр ШУТИС-ийн Нийгмийн ажлын тэнхимтэй хамтран ажиллаж байна. Хорооны нийгмийн ажилтны дийлэнхийг бэлдэн гаргадаг энэ сургуулийн нийгмийн ажил, сэтгэл судлалын багш нар хамтран сургалтын хөтөлбөртөө залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх агуулга, арга зүйг багтаах зорилгоор бакалаврын хөтөлбөртөө агуулгын өөрчлөлт хийж, оюутнуудын ашиглах ажлын дэвтэр боловсруулаад байна. Нэгэнт боловсруулсан агуулга, аргачлалаа одоо ажиллаж байгаа хорооны нийгмийн ажилтнуудад хүргэх зорилгоор мэргэжил дээшлүүлэх зуны сургалтын хөтөлбөр мөн боловсруулж байна. Оюутны судалгааны ажлууд 2017 оноос эхэлнэ.

Хамтран ажиллагч хоёр сургуулийн багш нар хороо, сургуулийн түвшинд шууд аваад ашиглаж болох аргачлал боловсруулаад байна. АШУИС-ийн баг хүчирхийлэлд холбогдох эрсдэлийг илрүүлэх 3 түвшний үнэлгээний аргачлал боловсруулсан ба эдгээр нь нийт залуучуудын дундах хүчирхийллийн цар хүрээ, хэлбэр, давтамжийг баримтжуулах, хүчирхийлэлд холбогдох өндөр эрсдэлтэй хувь хүмүүсийг хөтөлбөрт хамруулах зорилгоор илрүүлэх, мөн хүчирхийлэл үйлдсэн, түүнд өртсөн залуучуудын нөхөн сэргээх үйл ажиллагаанд хамруулах зорилгоор илрүүлэх тус бүрийн зорилготой болно. 2017 оноос уг арга зүйг турших, хорооны нийгмийн ажилтнуудад эзэмшүүлэх сургалт зохион байгуулахын зэрэгцээ хүчирхийллийг урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий орон нутгийн цагдаа нарт танилцуулах ажил төлөвлөөд байна.

ШУТИС-ийн баг Улаанбаатар хотын хоёр хороон дээр өсвөр насны хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зохион байгуулах зорилгоор ашиглаж болох нөөц, боломжууд, бусад хороонд тараан түгээж болох туршлагыг баримтжуулах судалгаа хийсэн ба арга зүйг нь орон нутгийн нөөцийн зураглалын арга зүй болгон боловсруулж, сургалтдаа ашиглахаар бэлдээд байна.

Хоёр тэнхимийн боловсруулсан арга зүй, хэрэглэгдэхүүнүүдийг танилцуулгад оролцсон дүүргийн нийгмийн бодлогын мэргэжилтнүүд өндөр сэтгэгдэлтэй хүлээн авсан ч орон нутгийн сонгуулийн дараа шинээр бүрдээд байгаа дүүрэг, хорооны удирдлагуудад дахин танилцуулах шаардлагатай болоод байна.

Дотоодын мэдлэг, арга зүй бий болгох үйл явцыг гаднын туршлага, чанартай мэдээллээр дэмжих хэрэгтэй гэж үзэн манай хөтөлбөрөөс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын “Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: Баримт нотолгооны тойм” гарын авлагыг орчуулан хэвлэлд бэлдээд байна. Уг гарын авлага нь дэлхийн олон улс оронд хэрэгжсэн залуучуудыг хүчирхийллээс хамгаалах зорилготой янз бүрийн бодлого, хөтөлбөрийн үнэлгээний тайлангуудыг нэгтгэн шүүж, олон эх сурвалжийн мэдээллийг харьцуулах замаар үр нөлөөтэй хөтөлбөр, арга хэмжээг үр нөлөөтэй эсэх нь тодорхойгүй арга хэмжээнээс ялгаж өгсөн байна. Энэ гарын авлага нь орон нутаг, үндэсний түвшний бодлого, хөтөлбөрийн сайн туршлагыг Монгол хэлээрээ судлах боломж олгож байгаа юм.

Олон нийт, залуу хүмүүст хандсан “Хүчирхийлэл



бидний сонголт биш” нэртэй 2 хэсэг баримтат нэвтрүүлэг бэлдэн, үндэсний телевизтэй хамтран олон нийтэд хүргэлээ. Нэвтрүүлэгт төрийн бус байгууллагын судлаач, их дээд сургуулийн багш нар, цагдаа болон прокурорын байгууллагын төлөөлөгчдийг оролцуулан, бий болоод байгаа мэдлэг, судалгааны дүгнэлт, аргачлал зэргээ танилцуулсан. МҮОНРТ нь манай хоёр нэвтрүүлгийг үнэ төлбөргүй гаргаснаас гадна “Энд гарц бий” нэвтрүүлгийн сэдэв болгон авч, манай хамтран ажиллагч судлаачдыг урьж нэг

Дээрх зурагт: Төрийн бус байгууллага, хороо, дүүргийн мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтын явцыг харуулав.

Баруун гар талд: “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын захирал И. Мандухайхатан



цагийн шууд хэлэлцүүлэг хийв. Мөн өсвөр насныханд чиглэсэн контент дагнан бэлтгэдэг Yolo.mn вэб сайтын хамт олон үе тэнгийн хүчирхийллийн талаар мэдээлэл авсны үндсэн дээр “Ангийн хөрөг” буландаа дээрэлхэлт, гадуурхалтын эсрэг агуулга оруулжээ. Цаашид

уламжлалт болон нийгмийн сүлжээнд ажилладаг шинэ мэдээллийн хэрэгслүүд, мөн урлаг, соёлын салбар, уран бүтээлчидтэй хамтран олон нийтийн хандлагад нөлөөлөх арга замуудыг үргэлжлүүлэн судлах болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2016 онд нийт 2,309,000 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$ 2,263,000 Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүд, \$ 29,200-Азийн Сан, \$ 13,600- IRI, \$ 3,200 бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

Хөтөлбөр	Тэтгэлэгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР			
Хүний эрх	-	56,932	56,932
Эрх зүйн шинэтгэл	26,934	80,758	107,692
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	28,575	51,241	79,816
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	21,469	130,731	152,200
Сонгууль, улс төрийн санхүүжилт	29,286	62,682	91,968
Төрийн ил тод хариуцлагатай байдал			
Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	36,017	36,693	72,710
- Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь	10,162	4,926	15,088
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Олборлох үйлдвэрлэлийн засаглал, ил тод байдал	28,025	78,899	106,924
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	27,387	75,366	102,753
Эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээ ба Бизнесийн орчин		5,968	5,968
БОЛОВСРОЛ, НИЙГЭМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Тэгш хамруулах боловсрол	44,680	28,728	73,408
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	26,022	33,726	59,748
БУСАД			
- Азийн орнуудын ардчилалын туршлага солилцох үйл ажиллагаа	964,858	421	965,279
ЗАХИРГАА		406,792	406,792
НИЙТ ДҮН	1,243,414	1,053,863	2,297,277

ТЭТГЭЛГИЙН ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Нийт тэтгэлгийн зардал
ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨР			
Хүний эрх	-	-	-
Эрх зүйн шинэтгэл	26,214	720	26,934
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь	20,280	8,295	28,575
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь	-	21,469	21,469
Сонгууль, улс төрийн санхүүжилт	20,326	8,960	29,286
Төрийн ил тод хариуцлагатай байдал			
Хариуцлагатай байдлыг бэхжүүлэх механизм	36,017	-	36,017
Байгаль орчны талаар иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь	-	10,162	10,162
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨТӨЛБӨР			
Олборлох үйлдвэрлэлийн засаглал, ил тод байдал	23,950	4,075	28,025
Төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцоо	27,387	-	27,387
Эдийн засгийн дүн шинжилгээ ба Бизнесийн орчин	-	-	-
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР			
Тэгш хамруулах боловсрол	44,680	-	44,680
Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь	26,022	-	26,022
БУСАД			
Азийн орнуудын ардчиллын туршлага солилцох үйл ажиллагаа	964,858	-	964,858
ЗАХИРГАА	-	-	-
НИЙТ ДҮН	1,189,733	53,681	1,243,414

2016 ОНД ОЛГОСОН НИЙТ ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

\$ доллар

д/д	Байршил	Тэтгэлэг хүртэгчийн нэр	Төрөл	Тэтгэлгийн дүн
1	Улаанбаатар	Ж.Баярцэцэг	Иргэн	\$720
2	Улаанбаатар	Д.Цэрэнжав	Иргэн	\$1,105
3	Улаанбаатар	Б.Баярмаа	Иргэн	\$3,618
4	Улаанбаатар	Д.Цэрэнжав	Иргэн	\$2,986
5	Улаанбаатар	Л.Долгормаа	Иргэн	\$3,558
6	Улаанбаатар	Д.Сүнжид	Иргэн	\$2,763
7	Улаанбаатар	Х.Номингэрэл	Иргэн	\$2,763
8	Улаанбаатар	Д.Алтантуяа	Иргэн	\$2,729
9	Улаанбаатар	Д.Ёндонжамц	Иргэн	\$2,815
10	Улаанбаатар	А.Түвшинтулга	Иргэн	\$2,637
11	Улаанбаатар	Ж.Хунан	Иргэн	\$2,522
12	Улаанбаатар	П.Хашчулуун	Иргэн	\$2,240
13	Улаанбаатар	Д.Сайнбаяр	Иргэн	\$2,240
14	Улаанбаатар	М.Амарбаяр	Иргэн	\$2,240
15	Улаанбаатар	Б.Даваатогтох	Иргэн	\$2,240
16	Улаанбаатар	Л.Төр-Од	Иргэн	\$978
17	Улаанбаатар	Ж.Хунан	Иргэн	\$2,655
18	Улаанбаатар	Г.Баясгалан	Иргэн	\$2,585
19	Улаанбаатар	О.Батдорж	Иргэн	\$1,356
20	Улаанбаатар	С.Гантогтох	Иргэн	\$1,153
21	Улаанбаатар	Д.Золжаргал	Иргэн	\$1,153
22	Улаанбаатар	Э.Мөнхсайхан	Иргэн	\$1,153
23	Улаанбаатар	Г.Олонбаяр	Иргэн	\$1,153
24	Улаанбаатар	Д.Орхонтамир	Иргэн	\$1,172
25	Улаанбаатар	Ж.Сайнхишиг	Иргэн	\$1,153
26	Улаанбаатар	Ч.Отгочулуу	Иргэн	\$997
27	Улаанбаатар	И.Индранила	Иргэн	\$995
28	Дорнод аймаг	УТБАкадеми Дорнод салбар	ТББ	\$885
29	Өмнөговь аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$885
30	Улаанбаатар	Хууль бидний амьдрал	ТББ	\$885
31	Хөвсгөл	Хөвсгөлийн хөгжил, дэвшилд	ТББ	\$885
32	Улаанбаатар	Хэрэглэгч сан	ТББ	\$885
33	Орхон аймаг	Эрдэнэт хүмүүний эв нэгдэл	ТББ	\$885

34	Улаанбаатар	Урагш дэвших холбоо	ТББ	\$885
35	Өвөрхангай аймаг	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	\$885
36	Дархан-Уул аймаг	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	ТББ	\$885
37	Булган аймаг	Булганы мэдээ сонин	ТББ	\$885
38	Завхан аймаг	Өрнөх хөгжил	ТББ	\$885
39	Улаанбаатар	Үнэн хатамж	ТББ	\$885
40	Баянхонгор аймаг	Амартайван итгэл	ТББ	\$885
41	Ховд аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$885
42	Говьсүмбэр аймаг	Хөгжлийн түншлэл	ТББ	\$885
43	Төв аймаг	Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$885
44	Баян-Өлгий аймаг	Нийгмийн хөгжлийн дэмжих холбоо	ТББ	\$885
45	Хэнтий аймаг	Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$885
46	Налайх дүүрэг	Эгэл	ХХК	\$885
47	Говь-Алтай аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$885
48	Улаанбаатар	Гадаад харилцааны яам	Төрийн	\$134,430
49	Улаанбаатар	Мидас	ТББ	\$3,974
50	Улаанбаатар	Филантропи Хөгжлийн төлөө төв	ТББ	\$12,458
51	Улаанбаатар	Монголын хуульчдын холбоо	ТББ	\$2,305
52	Архангай аймаг	Архангай бие даан амьдрах төв	ТББ	\$2,043
53	Завхан аймаг	Өрнөх хөгжил	ТББ	\$1,728
54	Өмнөговь аймаг	Өмнөговь бие даан амьдрах төв	ТББ	\$1,841
55	Орхон аймаг	Эрдэнэт бие даан амьдрах төв	ТББ	\$2,162
56	Улаанбаатар	Сонгино бие даан амьдрах төв	ТББ	\$2,040
57	Улаанбаатар	Түгээмэл хөгжил	ТББ	\$2,486
58	Улаанбаатар	Бүх нийтийн боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл	ТББ	\$559
59	Улаанбаатар	Гадаад харилцааны яам	Төрийн	\$32,490
60	Улаанбаатар	Гадаад харилцааны яам	Төрийн	\$81,978
61	Улаанбаатар	Зориг сан	ТББ	\$1,415
62	Өвөрхангай аймаг	Хийморьтны ухаан	ТББ	\$1,529
63	Хөвсгөл	Хөвсгөл далай ээж	ТББ	\$2,620
64	Өвөрхангай аймаг	Эх нутаг хөгжил төв	ТББ	\$989
65	Орхон аймаг	Төр иргэн түншлэл	ТББ	\$1,702
66	Төв аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$2,007
67	Өвөрхангай аймаг	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	\$2,509
68	Өмнөговь аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$1,397
69	Архангай аймаг	Мэдлэгийн сүлжээ	ТББ	\$1,032

Санхүүгийн тайлан

70	Баян-Өлгий аймаг	Сонгогчдын эрх, шудрага ёс	ТББ	\$1,032
71	Баянхонгор аймаг	Баянхонгор бизнес мэдээллийн төв	ТББ	\$1,032
72	Булган аймаг	Хуульч эмэгтэйчүүдийн холбоо	ТББ	\$965
73	Говь-Алтай аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$1,032
74	Говьсүмбэр аймаг	Тахил тогоот	ТББ	\$1,032
75	Дархан-Уул аймаг	Орхон 21-р зуун төв	ТББ	\$1,032
76	Дорноговь аймаг	Манлайлагч иргэд	ТББ	\$965
77	Дорнод аймаг	УТБАкадеми Дорнод салбар	ТББ	\$1,029
78	Дундговь аймаг	Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Дундговь салбар	ТББ	\$1,032
79	Завхан аймаг	Өрнөх хөгжил	ТББ	\$1,032
80	Орхон аймаг	Эрдэнэт хүмүүний эв нэгдэл	ТББ	\$1,032
81	Өвөрхангай аймаг	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		\$1,032
82	Өмнөговь аймаг	Баг сумдын үндэсний холбоо	ТББ	\$1,032
83	Сүхбаатар аймаг	Сэтгэшгүй -оюун далай	ТББ	\$873
84	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ-итгэл Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$1,032
85	Төв аймаг	Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$1,032
86	Увс аймаг	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$965
87	Ховд аймаг	Нийгмийн хариуцлага иргэдийн оролцоо	ТББ	\$965
88	Хөвсгөл	Сүүн тахилт	ТББ	\$1,032
89	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	ТББ	\$1,032
90	Багануур дүүрэг	Хууль, хүний эрх төв	ТББ	\$1,032
91	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	\$1,032
92	Улаанбаатар	Татварт иргэний хяналт	ТББ	\$1,032
93	Налайх дүүрэг	Ирээдүйн босго	ТББ	\$965
94	Улаанбаатар	Монголын Тува эмэгтэйчүүдийн Тува ээж нийгэмлэг	ТББ	\$1,032
95	Улаанбаатар	Хүний нөөц нийгмийн түншлэл	ТББ	\$1,032
96	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$1,032
97	Улаанбаатар	Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо	ТББ	\$1,032
98	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$965
99	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	ТББ	\$965
100	Улаанбаатар	Иргэдэд туслах хүний эрхийн төв	ТББ	\$965
101	Улаанбаатар	Улс төрийн боловсролын академи	ТББ	\$1,491
102	Улаанбаатар	Ангир нүдэн мөндөөхэй	ТББ	\$2,845
103	Улаанбаатар	Булаг шанд гол мөрний эхийг хамгаалах сан	ТББ	\$3,055
104	Улаанбаатар	Амьд хууль төв	ТББ	\$3,515
105	Дундговь аймаг	Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан	ТББ	\$1,716

Санхүүгийн тайлан

106	Улаанбаатар	Зориг сан	ТББ	\$1,629
107	Хэнтий аймаг	Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$2,669
108	Улаанбаатар	Буйрнуур Халх гол Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	ТББ	\$2,598
109	Дорнод аймаг	Монголын Байгаль орчныг хамгаалах холбооны Дорнод салбар	ТББ	\$3,116
110	Улаанбаатар	Гадаад харилцааны яам	Төрийн	\$62,472
111	Ховд аймаг	Ховдын толь	ТББ	\$2,808
112	Улаанбаатар	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн	ТББ	\$3,702
113	Улаанбаатар	Гадаад харилцааны яам	Төрийн	\$34,944
114	Баян-Өлгий аймаг	Албан журмын даатгагчдын холбоо	ТББ	\$971
115	Булган аймаг	Гэрэлт ирээдүйн оршихуй	ТББ	\$980
116	Дархан-Уул аймаг	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	\$1,411
117	Завхан аймаг	Завхан аймгийн ахмад мэргэжилтний холбоо	ТББ	\$993
118	Орхон аймаг	Төр иргэн түншлэл	ТББ	\$1,095
119	Увс аймаг	Өсвөр үе ирээдүй Увс төв	ТББ	\$962
120	Ховд аймаг	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	ТББ	\$1,659
121	Улаанбаатар	Мидас	ТББ	\$3,894
122	Улаанбаатар	Гэгээ Мандал	ТББ	\$846
123	Улаанбаатар	Түгээмэл хөгжил	ТББ	\$16,216
124	Улаанбаатар	МУИС ХЗСургууль	Сургууль	\$9,902
125	Улаанбаатар	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	\$885
126	Увс аймаг	Сайн тус төв	ТББ	\$885
127	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ-итгэл Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$885
128	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$885
129	Дундговь аймаг	БОНӨБ Эрдэнэ холбоо	ТББ	\$885
130	Сүхбаатар аймаг	Сэтгэшгүй -оюун далай	ТББ	\$885
131	Улаанбаатар	Залуус манлайлал төв	ТББ	\$885
132	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн залуучуудын холбоо	ТББ	\$885
133	Улаанбаатар	Төсвийн удирдлагын хүрээлэн	ТББ	\$885
134	Улаанбаатар	Онол арга	ТББ	\$851
135	Улаанбаатар	Хүншихүйн зам	ТББ	\$885
136	Улаанбаатар	Монголын Криминологичдын холбоо	ТББ	\$12,047
137	Улаанбаатар	Гадаад харилцааны яам	Төрийн	\$33,053
138	Улаанбаатар	МУШУТИС Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн Сургууль	Сургууль	\$26,022
139	Улаанбаатар	Гадаад харилцааны яам	Төрийн	\$584,000
140	Улаанбаатар	Боловсролд тэгш боломж	ТББ	\$14,757
НИЙТ				\$1,243,414

Удирдах зөвлөлийн гишүүд, ажилтнууд

Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

Г. Уранцоож	УЗ-ийн дарга, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн
Ж. Үнэнбат	УЗ-ийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын гүйцэтгэх захирал
Ч. Хашчулуун	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ЭЗС-ийн багш
Ч. Лодойравсал	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ХШУИС-ийн багш
Ц. Отгонбаатар	УЗ-ийн гишүүн
О. Энхтуяа	УЗ-ийн гишүүн, Дэ Нэйчэр консерванси ТББ-ын захирал

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

П. Эрдэнэжаргал	jargal@forum.mn
-----------------	-----------------

Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд

П. Бадамрагчаа	Засаглалын хөтөлбөрийн менежер	badmaa@forum.mn
А. Гэрэлмаа	Боловсрол, Нийгмийн бодлогын хөтөлбөрийн менежер	gerelmaa@forum.mn
Д. Оюунбадам	Эдийн засгийн хөтөлбөрийн менежер	oyunbadam@forum.mn
Б. Хишигсайхан	Засаглалын хөтөлбөрийн менежер	khishgee@forum.mn
Д. Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер	enhee@forum.mn
Д. Эрдэнэчимэг	Эдийн засгийн хөтөлбөрийн менежер	dorjdari@forum.mn
О. Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан	passistant@forum.mn
У. Энхцэцэг	Хөтөлбөрийн туслах ажилтан	assistant@forum.mn
Б. Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан	fellowship@forum.mn
Д. Балжид	Мэдээллийн менежер	baljid@forum.mn
Б. Мөнхгэрэл	Сэтгүүлч	munkhgerel@forum.mn
Д. Жавхлан	Санхүүгийн захирал	javkhlan@forum.mn
Д. Аюуш	Оффис менежер	ayush@forum.mn
Г. Одонмижид	Нягтлан бодогч, тэтгэлгийн менежер	odnoo@forum.mn
Э. Сэйнтүвшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	sainaa@forum.mn
Д. Ганзул	Захирлын туслах (2016 оны 9 сар хүртэл)	
Б. Амгалан	Захирлын туслах (2016 оны 9 сараас)	amgalan@forum.mn
Б. Баатар	Захиргааны ажилтан	baatar@forum.mn
Г. Цэдэвхүү	Захиргааны ажилтан	tsedev@forum.mn
Н. Хүрэлболд	Захиргааны ажилтан	

Нийтлэг И-мэйл: osf@forum.mn
